



Нээлттэй
Нийгэм
Форум

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ

Судалгааны тайлан

Улаанбаатар, 2011



Нээлтэй
Нийгэм
Форум

Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг

Судлаач: У.ТУЯА, Ph.D.

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Ч.АЛТАНГЭРЭЛ, M.Ed.

*НҮБ-ын Хүүхдийн сангийн Өсвөр үеийнхний хөгжил,
оролцооны мэргэжилтэн*

Хянан тохиолдуулсан: А.ГЭРЭЛМАА

Нээлтэй Нийгэм Форумын менежер

Энэхүү судалгаагаар гаргасан үнэлэлт, дүгнэлт нь Нээлтэй Нийгэм Форумын байр суурийг илэрхийлэхгүй ба уг судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачийн үзэл бодлыг илэрхийлнэ.

© Нээлтэй Нийгэм Форум

Судалгааны тайланг хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж олшруулахыг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс

DDC
370.112
T-727

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ISBN 978-99929-64-46-4

Гарчиг

Товчилсон үг.....	4
Зургийн товъёог	6
Графикийн товъёог	6
Хүснэгтийн товъёог	7
Удиртгал	8
НЭГ. СУДАЛГААНЫ ТОЙМ	12
ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН.....	16
2.1. Монгол Улсын үндсэн хууль дахь үнэт зүйлсийн зураглал	16
2.2. Үнэт зүйл ба нийгмийн ухааны боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр	24
2.3. Үнэт зүйл ба хичээл.....	39
ГУРАВ. ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	68
3.1 Иргэний боловсролын тухай ойлголт, үзэл баримтлал	68
3.2 Иргэний боловсролын талаарх үндэсний санаачлагууд.....	71
ДӨРӨВ. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ	81
4.1. ЕБС-ийн сургалтаар олгож буй иргэний боловсол: Одоог харах нь.....	81
4.2 Бодлогын зөвлөмж: Урагшаа харах нь.....	90

Товчилсон үг

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АР	Архангай
АТБХ	Агуулгын тогтолцооны бүтэцчилсэн хүрээ
БГД	Баянгол дүүрэг
БДБХ	Бага, дунд боловсролын тухай хууль
БДБС	Бага, дунд боловсролын стандарт
БДБКСШХУБ	Бага, дунд боловсролын киррикулим болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал
БЗД	Баянзүрх дүүрэг
БХ	Боловсролын тухай хууль
БНОУХ	Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ДА	Дархан-Уул
ЕБ	ерөнхий боловсрол
ЕБС	ерөнхий боловсролын сургууль
ЕБССББ	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого
ИНБ	иргэний нийгмийн байгууллага
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо ТББ
МБХАН	Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ
МННХ	Монголын нээлттэй нийгэм хүрээлэн
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
МУ	Монгол Улс
МҮЭХ	Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
НУБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХЭДКГ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо

СӨБСББ	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого
СӨБХ	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
СӨБДС	Сургуулийн өмнөх боловсролын стандарт
СБД	Сүхбаатар дүүрэг
ТББ	төрийн бус байгууллага
ТБББ	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
ТНУ	Түүх, нийгмийн ухаан
ТНУБ	Түүх, нийгмийн ухааны боловсрол
ТНУБС	Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
УТБА	Улс төрийн боловсролын академи ТББ
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮТ	Хууль зүйн үндэсний төв
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХӨУБ	хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага
ЦС	цогцолбор сургууль
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага

Зургийн товъёог

Зураг 1.	Судалгааны бүтэцчилсэн хүрээ.....	12
Зураг 2:	МУ-ын Үндсэн хуульд шингээсэн үнэт зүйлс ба Иргэний боловсролын агуулга.....	18
Зураг 3.	Үнэт зүйлсийн түвшин	19
Зураг 4:	Үндсэн хууль дахь нийтлэг үнэт зүйлс	19
Зураг 5.	НУБ-ын агуулгын тогтолцооны хүрээ	37
Зураг 6.	Ангийн суудал зохион байгуулалт (уламжлалт хэлбэр)	46
Зураг 7.	Ангийн суудал зохион байгуулалт (жигжиг бүлгээр)	47
Зураг 8.	Ангийн суудал зохион байгуулалтын хэлбэр (том бүлгээр) 47	
Зураг 9.	Ангийн суудал зохион байгуулалтын хэлбэр (тойргоор) 48	
Зураг 10.	Ангийн мониторингийн бүрэлдэхүүн хэсгүүд	66

Графикийн товъёог

График 1.	Хичээлийн үеэр сурагчдын хийсэн үйл ажиллагаа	45
График 2:	Хичээлийн үеэр сурагчдын хийсэн үйл ажиллагааны хуваарилалт.....	45
График 3.	Багшийн дэмжиж буй үнэт зүйлсийн үзүүлэлт, багшаар ..	52
График 4:	Багшийн дэмжиж буй үнэт зүйлсийн үзүүлэлт, үйл ажиллагаагаар.....	53
Бүдүүвч 1.	Монгол Улсын ерөнхий боловсролын зорилго	21
Бүдүүвч 2.	Үнэт зүйлс: Хуулийн заалтаас хувь хүний хандлага болон төлөвших үе шат	88
Бүдүүвч 3.	Иргэний боловсрол: Асуудлын зураглал.....	89

Хүснэгтийн товъёог

Хүснэгт 1.	Боловсролын баримт бичгүүд ба үнэт зүйлс.....	21
Хүснэгт 2.	Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйлс боловсролын агуулгад.....	23
Хүснэгт 3.	Түүх, эрх зүй болон нийгмийн тухай мэдлэгийн боловсролын стандарт ба ЕБ-ын түвшин.....	25
Хүснэгт 4.	ТНУ-Нийгмийн тухай мэдлэгийн стандарт.....	27
Хүснэгт 5.	ТНУ-Эрх зүйн боловсролын стандарт.....	28
Хүснэгт 6.	Нийгмийн ухааны хичээлийн цаг, анги.....	31
Хүснэгт 7.	Тухайн ангийн сургалтын хөтөлбөрийн бүтэц.....	32
Хүснэгт 8.	Ашиглагдаж буй сурах бичиг.....	34
Хүснэгт 9.	Сурах бичгийн агуулга.....	34
Хүснэгт 10.	Сурах бичгүүдийн агуулгын залгамж холбоо.....	35
Хүснэгт 11.	Хичээлийн залгамж чанар.....	36
Хүснэгт 12.	Хичээлийн соёлын ажиглалт: Үндсэн мэдээлэл.....	40
Хүснэгт 13.	Сурагчдын хичээлд оролцсон байдал – Дархан-Уул аймгийн сургууль.....	41
Хүснэгт 14.	Сурагчдын хичээлд оролцсон байдал – аймгийн төвийн сургууль.....	42
Хүснэгт 15.	Багш 1 Сэдэв: Хүмүүнлэгийн эрх зүйн тухай ойлголт.....	43
Хүснэгт 16.	Багш 2 Сэдэв: Хөдөлмөрийн гэрээ хэзээ, хэрхэн дуусдаг вэ?.....	43
Хүснэгт 17.	Багш 3 Сэдэв: Эрүүл мэндийн даатгал.....	44
Хүснэгт 18.	Сурагчдын хийсэн үйл ажиллагаа ба хугацааг нэгтгэж харвал.....	44
Хүснэгт 19.	Багшийн дэмжиж буй үнэт зүйлсийн үзүүлэлт.....	52
Хүснэгт 20.	“Итгэл, урам” хичээлийн агуулгын тойм.....	65

Өнөө үед боловсролын үүрэг, зорилго нь тодорхой шинжлэх ухааны цогц мэдлэг олгож ирсэн уламжлалаас холдож, хүүхэд, залуучуудыг нийгмийн амьдралд бэлтгэх, бие хүн болгон төлөвшүүлэхэд чиглэгдэж байна. Учир нь нийгмийн харилцаа, үнэт зүйлс өөрчлөгдөн хувирч байна. Тухайлбал,

- Улс төрийн тогтолцоо өөрчлөгдөн, ардчиллын үнэт зүйлс бэхжин, эдийн засаг даяарчлагдахын хирээр хүний нөөцөд тавигдах шаардлагууд өндөрсөж, мэдээлэл харилцааны технологийг өргөн ашиглах болсон.
- Дотоод ба гадаад шилжилт хөдөлгөөн эрчимжиж байгаа нь соёлын болон бусад ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, түүнд дасан зохицох зэрэг асуудал чухлаар тавигдаж байна.

Эдгээрийг дагалдан хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж буй бөгөөд түүнд хэрхэн дасан зохицох, хөгжих, иргэний зүгээс төртэй харилцах¹ эрх, эрх чөлөөгөө мэдэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихэд нь дэмжлэг үзүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.²

Монгол оронд 1990-ээд оноос эхэлсэн ардчиллын үйл явц нь нийгмийн бусад салбарын нэгэн адил боловсролын тогтолцоонд өөрчлөлт шинэчлэлтийг авчирсан юм. Энэ үеэс боловсролыг “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн иргэн төлөвшүүлэх үйл явц, үр дүн”³, “мэдлэг туршлага эзэмшүүлэх, харилцаа хандлага төлөвшүүлэх”⁴ үйл явц хэмээн өргөн утгаар нь авч үзэх болов. Үүнтэй уялдуулан Монголын боловсролд бодлогын болон агуулга, арга зүйн шинэчлэлтүүд хийгдэж байна.

Уг шинэчлэлтийн хүрээнд Монголын залуу үед олгох боловсролын агуулга, аргазүй, оролцогч талуудын хүлээх үүрэг, үүн дотор иргэний боловсролын үзэл баримтлалыг тодорхойлох зэрэг олон асуултад хариулт өгөх шаардлага гарч ирэв. Энэ талаар олон улсын болон үндэсний хэмжээнд санал, санаачлагууд өрнөж байгаа бөгөөд бидний хувьд

¹ Civics education for the twenty-first century <http://portal.unesco.org/education/en/2006-08-26>

² УТБА (2007). Иргэний сонгогчийн боловсрол судалгааны тайлан. УБ

³ Боловсрол судлалын үндэс. УБ., 1999.,х.21

⁴ Боловсрол судлалын үндэс. УБ., 1999.,х.21

ерөнхий боловсролын сургалтаар суралцагчдад олгож буй иргэний боловсролын асуудлуудыг авч үзлээ. Энэхүү судалгаа нь ЕБС-ийн түвшинд иргэний боловсрол олгоход чиглэж буй “Иргэншил” хичээлээр дамжуулан иргэний боловсролын агуулга, судлагдахууны тогтолцоог хэрхэн сонгож, боловсруулж байгааг Монгол Улсын Үндсэн хууль, ерөнхий боловсролын түүх-нийгмийн ухааны боловсролын стандарт, хөтөлбөр болон ээлжит хичээлийн уялдаа холбоон дээр гаргаж тавихыг хичээсэн болно.

Эдүгээ Монголд бодлого боловсруулах үйл явц илүү нээлттэй болж, иргэдийн оролцоог чухалчилсан хандлага нийгэм болон улс төрийн соёлын нэгэн хэсэг болж буй энэ цаг үед залуу үед иргэний боловсрол олгох нь чухал ач холбогдолтой юм. Энэхүү чухал асуудалд боловсролын салбарын оролцоог оновчтой болгон эрчимжүүлэхэд уг судалгаа хувь нэмэр болно хэмээн найдаж байна. Энэ дашрамд уг судалгааг гүйцэтгэх боломж олгож, бүх талын дэмжлэгээр хангаж өгсөн Нээлттэй Нийгэм Форумд судлаачдын зүгээс талархал илэрхийлье.

Судалгааны зорилго, зорилтууд

Ерөнхий боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтын (Иргэншил хичээл) өнөөгийн нөхцөл байдал, түүний хэрэгжилт болон үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлс, тулгамдаж буй сорилт бэрхшээлүүдийг тодорхойлж, улмаар түүний чанар, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн бодлогын зөвлөмж гаргахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллалаа:

Эрх зүйн орчны шинжилгээний чиглэлээр:

- Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй боловсролын стандарт, хөтөлбөрүүд нь хүүхэд, залуучуудад хүний эрх, эрх зүйн болон ардчиллын боловсролын чиглэлээр үнэт зүйлс, ур чадвар эзэмших боломжийг хангаж буй эсэхэд үнэлгээ дүгнэлт өгөх;

Хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээний чиглэлээр:

- Иргэний боловсролын сургалтын орчин (сурах бичгийн хангамж, багшийн бэлтгэл, цагийн хүрэлцээ), мөн хичээлээр олгосон мэдлэгийг бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхүйц сургуулийн соёл (багш - сурагчийн болон багш - эцэг эхийн, мөн багш нарын хоорондын өдөр тутмын харилцаа, сургуулийн орчинд ардчилал, хүний эрх, нээлттэй олон ургальч хандлагыг хүндэтгэсэн зэрэг) хэвшсэн эсэхэд мониторинг хийх;

Сайжруулахад чиглэсэн зөвлөмж гаргах чиглэлээр:

- Дээрх шинжилгээнд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын зөвлөмж, нөлөөллийн ажлын үндэслэлийг боловсруулах зэрэг болно.

Судалгааны бүтэцчилсэн хүрээ

Судалгааны зорилгыг хангахын тулд Монгол Улсын Үндсэн хуульд тулгуурлан иргэний боловсролын үнэт зүйлсийг тодорхойлж, Үндсэн хуулиар баталгаажсан эдгээр үнэт зүйлс нь ЕБС-ийн иргэний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт хэрхэн туссан болох, нөгөө талаар энэ нь сургуулийн анги танхимд багшийн ажлын талбарт хэрхэн хэрэгжиж байна вэ гэсэн харилцан уялдаа бүхий асуултуудад хариулт олох шаардлагатай гэж үзлээ.

Судалгаанаас хүлээгдэж буй үр дүн

- ЕБС-ийн сургалтын хөтөлбөрөөр олгож буй Иргэний боловсролын өнөөгийн байдалд үнэлгээ хийж, цаашид сайжруулахад чиглэлээр боловсруулсан бодлогын зөвлөмж нь уг судалгааны гол үр дүн болно.
- Уг дүгнэлт, зөвлөмж нь өнөөгийн нийгмийн өөрчлөлтөд нийцүүлэн иргэний боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгоход чиглэсэн нөлөөллийн ажлын хэрэглэгдэхүүн болно.

Судалгааны үндсэн арга

Уг судалгаанд чанарын мэдээлэл цуглуулах аргуудыг давамгайлж ашиглалаа. Үүний шалтгаан үндэслэл нь судалгааны мөн чанартай шууд холбоотой бөгөөд тухайн судалгаа өөрөө ойлголт, хандлага, оролцогч талуудын үнэлгээ, дүгнэлт, судлаачдын үнэт зүйлсийн баримжааг тусгасан үнэлгээ зэрэг чанарын шинжилгээний төрлийн судалгаа юм. Судалгаанд дараах аргуудыг ашиглалаа:

- **Баримт бичгийн шинжилгээ**

Иргэний үнэт зүйлсийн зураглал (value mapping):

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үнэт зүйлсийг ялган зураглал гаргах, түүнийг Түүх, нийгмийн ухааны боловсролын стандартаар тодорхойлсон иргэний боловсролын үнэт зүйлсийн чиг баримжаатай харьцуулах

Сургалтын хөтөлбөрийн шинжилгээ:

ЕБС-ийн хөтөлбөрөөр олгож буй иргэний боловсролын сэдэв, агуулга нь сурагчдад эзэмшүүлэхээр зорьж буй нийтлэг үнэт зүйлс, хандлага, чадварыг төлөвшүүлэх зорилгод нийцэж буй эсэх, агуулгын залгамж холбоо хангагдаж чадсан эсэх зэрэг чиглэлээр сургалтын хөтөлбөр болон сурах бичигт шинжилгээ хийх

Сургуулийн түвшний баримт бичгийн шинжилгээ:

Сургуулийн түвшинд батлан мөрдүүлж буй үндсэн баримт бичгүүд нь суралцагчид хичээлээр сурсан зүйлсээ хэрэглээ болгох соёлыг (багш, сургуулийн удирдлагууд хүний эрх, ардчиллын зарчмыг хүндэтгэж, үзэл бодлоо илэрхийлэх, асуудал шийдвэрлэхэд оролцох боломж олгохоор тусгасан зэрэг асуулт) бүрдүүлэхэд чиглэж чадсан эсэхэд үнэлгээ дүгнэлт өгөх

Сургуулийн түвшинд гүйцэтгэсэн хичээл зохион байгуулалт болон ангийн уур амьсгалын ажиглалт:

*Ажиглалтын аргыг*⁵ ашиглан сургалтын хөтөлбөрт туссан агуулгыг хэрэгжүүлэхявцдаа багшангитанхимдардчилсануурамьсгалбүрдүүлэхэд анхаарч буй эсэх, багшийн заах арга зүй, суралцагчдын оролцоо зэрэгт ажиглалт хийж дүгнэлт боловсруулах

Сургуулийн соёлыг шинжлэх:

Ярилцлагын аргаар сургуулийн түвшний шийдвэр гаргалт болон боловсролын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн олдоцыг тандаж, сургуулийн эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилттэй холбон дүгнэлт гаргах;


Иргэний боловсролын агуулгыг зааж буй мэргэжлийн багш нартай ярилцах замаар тухайн хичээлийг төлөвлөх, зохион байгуулах, заах болон үнэлэх үйл явцад гарч буй ахиц, саад бэрхшээлийг тодорхойлж, сургалтыг сайжруулах, үр дүнд хүргэх талаарх санал зөвлөмжийг авах

⁵ Ажиглалтын хуудас боловсруулж, тэмдэглэл хөтлөх /Ажлын хуудас 1, 2, 3/

НЭГ. СУДАЛГААНЫ ТОЙМ

“Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтын үнэлгээ, мониторинг” хэмээх энэхүү судалгааны хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, агуулга хөтөлбөрийн баримт бичгээр баталгаажсан иргэний үнэт зүйлс нь ЕБС-ийн танхимын сургалтанд хэрхэн заагдаж, суралцагчдад ямар мэдлэг, чадвар, хандлагын өөрчлөлт бий болгож буйг тодорхойлох зорилгоор үнэт зүйлсийн зураглал, баримт бичгийн шинжилгээ, сургах-суралцах үйл явцын ажиглалт, орчны шинжилгээний аргуудад тулгуурлан хот болон хөдөөгийн сургуулиудыг хамруулан авч үзлээ. Иймд судалгааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох МУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үнэт зүйлс, сургалтын баримт бичиг болон хичээлийн соёл гурвын уялдаа холбоо нь уг судалгааны хүрээг тодорхойлсон болно. Үүнийг доорх Зураг 1-д дүрслэн харуулав.

Зураг 1. Судалгааны бүтэцчилсэн хүрээ



Ерөнхий боловсролын сургуулиар олгож буй Иргэний боловсролын сургалтад үнэлгээ, мониторинг хийсний эцэст бид дараах хэдэн дүгнэлтэд хүрлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг баталгаажуулан хамгаалсан байх бөгөөд эдгээр нь боловсролын салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогод тодорхой хэмжээгээр туссан байна⁶. Харин чухал баримт бичгүүдэд

⁶ Тайлангийн 2.1-д буй Зураглал “Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйлс – Иргэний боловсролын агуулгад”-ыг үзнэ үү, х. 18.,

тусгагдсан эдгээр үнэт зүйлс нь сургуулийн түвшинд хэрэгжих иргэний боловсролын хөтөлбөр болгон “буулгах”, “хэлбэржүүлэх” ажил дутагдаж байна.

Юуны өмнө Монголын боловсролын салбар ардчилсан нийгэмд амьдарч, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг эрхэмлэн дээдэлж, бусдын үзэл бодол, ахуй соёлын ялгааг хүлээн зөвшөөрдөг хариуцлагатай иргэнгэжхэн болох, тэдний итгэл үнэмшил, үнэт зүйлс ямар байх, эдгээрийг хэрхэн төлөвшүүлэх тухай үзэл баримтлал, нэгдсэн ойлголттой болох нь чухал байна. Энэ үзэл баримтлалын үүднээс иргэний боловсролынагуулгыг ялган тодорхойлж, нэг агуулгыг хэт давамгай тусгах (тухайлбал, эрх зүйн боловсрол), эсвэл зарим шинжээчийн цохон тэмдэглэснээр экологийн, шашны болон хүлээцтэй хандах, олон соёлт, эдийн засаг зэрэг иргэний боловсролын бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг тэнцвэртэй тусгах замаар уг боловсролын өнөөгийн хязгаарлагдмал хүрээг тэлэх боломж бүрдэх юм. Нөгөө талаас, боловсролын салбарт иргэний боловсролыг дэмжсэн олон төсөл, хөтөлбөрийн үр дүнд нэлээдгүй туршлага хуримтлагдаад байгаа ч эдгээрийг тогтвортой хадгалах бодлогын дэмжлэг дутагдсаны улмаас сургалтын тогтолцоо болж төлөвшөөгүй байна. Тиймээс боловсролын салбарын шийдвэр гаргагчид нь иргэний боловсролын талаарх дэлхий нийтийн чиг хандлага, эрдэмтэн судлаачдын байр суурь, ялгаатай хандлагуудыг харьцуулан судалсаны үндсэн дээр Монгол Улсын өнөөгийн хөгжилд нийцсэн иргэний боловсролын үзэл баримтлалыг олон талын оролцоотой тодорхойлж, түүндээ нийцсэн бодлого, сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн иргэний боловсролын хичээлийн тухайлсан стандарт, сургалтын хөтөлбөр боловсруулах хэрэгцээ тулгамдаад байна. Өнөөгийн байдлаар сургуулийн түвшний эдгээр чухал баримт бичиг боловсруулагдаагүй байгаа байгаа бөгөөд ЕБС-ийн эрх зүйн боловсролын стандартад суурилсан хөтөлбөрөөр иргэний боловсрол олгох практик үйлчилж байна.

Ерөнхий боловсролын сургуулиар олгож буй нийгмийн ухааны боловсролын (сургалтын) өнөөгийн байдлыг шинжилж үзэхэд иргэний боловсролын хичээлийг янз бүрээр нэрлэж байгааг жигдлэх, агуулгыг сонгох, хичээлийн ба хичээлийн бус үйл ажиллагааны хэсэгт оновчтой хуваарилах талаар дахин нарийвчилсан судалгаа хийх шаардлага тодорхой харагдаж байна. Тухайлбал, өнөөдөр нэгэн зэрэг судалж буй “Иргэншил”, “Иргэний боловсрол” хэмээх хоёр хичээл нь иргэний боловсрол олгох нэгэн зорилготой боловч хоорондоо уялдаагүй, өөр

өөр хандлагад суурилсан тул энэ чиглэлд гаргаж буй хүчин чармайлт, шинэчлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна гэж дүгнэж болохоор байна.

Хичээлийн болон сургуулийн орчны ажиглалтын дүнгээс харахад танхимын сургалтын уур амьсгал, орчин нөхцөл болон сургуулийн соёл нь үндэсний болон салбарын бодлогын баримт бичигт туссан үнэт зүйлс, иргэний, ардчилсан, хүмүүнлэг нийгэмд ажиллаж амьдрахад шаардагдах мэдлэг, хандлагыг суралцагчдад төлөвшүүлэхэд бодитой дэмжлэг болж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, ардчилал, оролцоо, хүний эрх зэрэг сэдвийг хичээлээрээ зааж байгаа боловч анги танхим болон сургуулийн орчинд суралцагчидтай зөвлөлдөх, тэдний оролцоог хангах, ялгаатай байр суурь, үзэл бодлыг хүндэтгэн харьцах, хамтдаа шийдвэр гаргах үйл ажиллагаа харагдахгүй байна.

Үнэт зүйлсийг төлөвшүүлэх нь угаасаа нарийн ярвигтай үйл явц бөгөөд үүнд багш маш чухал үүрэгтэй. Гэтэл “Иргэний боловсрол” хичээлийн сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээ, сурах бичиг боловсруулагдаагүй, энэ чиглэлээр мэргэжлийн заавар зөвлөмж өгөхгүй байгаа нь танхимын сургалтыг төлөвлөн, хэрэгжүүлэх шатанд багшид олон бэрхшээл үүсгэдэг байна. Танхимд уншуулах, бичүүлэх, өөрөө ярьж тайлбарлах зэрэг уламжлалт арга зүйд тулгуурласан үйл ажиллагаа давамгайлж байна. Улмаар иргэний боловсролын хичээл заах бэлтгэл муутай, сүүлийн жилүүдэд мэргэжлээ дээшлүүлж чадаагүй байгаа багш нар сургалтын болон арга зүйн хэрэглэгдэхүүн хомсдолтой орчинд энэ хичээлийг төлөвлөн заах хэрэгтэй болж байна.

Иргэний боловсролд танхимын гадуурхи орчин маш их нөлөөтэй байдаг тул сургуулийн дотор бүрдсэн соёл болон энэ орчинг бүрдүүлэхэд чиглэсэн дүрэм журамд дүн шинжилгээ хийж үзлээ. Сургууль бүр өөрийн “Сургуулийн дүрэм”, “Дотоод журам”, “Суралцагчийн дүрэм”, “Анги дэвших ба төгсөх шалгалтыг зохион байгуулах журам” зэргийг боловсруулан ашиглаж байгаа ч тэдгээрт суралцагчдад хориглосон, үүрэг болгосон заалтууд голложээ. Тиймээс ч эдгээр дүрэм, журам нь сургуулийг ардчилсан, хүүхдэд ээлтэй, хүүхдийн эрх, оролцоог чухалчилсан орчин болгоход огт чиглэгдэхгүй байгаа юм. Ихэнх сургууль мэдээллийн самбартай ч голдуу хуучирсан мэдээ, хичээлийн хуваарь л байхаас сурагчдад хандсан хамтран зөвлөлдөх, шийдвэр гаргахтай холбоотой ямар нэг мэдээ, мэдээлэл тавигдахгүй байна. Сургуулийн орчны ажиглалтаас дүгнэн үзэхэд сургууль доторх соёл нь сурагчдын хичээлээр олж авсан мэдлэг, чадвар, хандлагыг бэхжүүлэхэд нь бодитой

дэмжлэг болж чадахгүй байна. Мэдээж сайн жишээ болох сургууль, энэ чиглэлээр хийгдэж буй санаачлагууд байгаа ч эдгээр нь ЕБС-ийн нийтлэг соёл болж хэвшээгүй байна.

Шинжилгээ, ажиглалтын эдгээр дүгнэлт дээр үндэслээд Иргэний боловсролыг сайжруулах, сургалтын чанар, үр өгөөжийг ахиулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг тодорхойлсон ба тэдгээрийг гугтайлангийн “Зөвлөмж” хэсгээс үзнэ үү.

2.1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ЗУРАГЛАЛ

Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл хандлагын дагуу дагуу аливаа улс орны Үндсэн хууль нь тухайн нийгэм, ард түмний энэ цаг үед баримталж буй үнэт зүйлсийг өөртөө агуулж байдаг. Ард түмэн ертөнцийг ямар өнцгөөс харж хандах, нийгмийн ямар үнэт зүйлсийг эрхэмлэн дээдлэхийг Үндсэн хуульд зааж, хэвшүүлдэгт түүний үзэл суртлын үүрэг оршдог ажээ.⁷ Үндсэн хуулиар тунхаглаж, баталгаажуулсан үнэт зүйлсээ түгээн дэлгэрүүлж, хүүхэд, залуучууд, нийт иргэдийнхээ амьдралын хэв маягт шингээснээр энэхүү үзэл санааны үүрэг хэрэгжих учиртай. Иргэний боловсролын талаарх харьцуулсан судалгаанаас үзэхэд улс орнууд ерөнхий боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтаар дамжуулан өөрийн орны үндсэн хуулийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлж, иргэдийнхээ итгэл үнэмшил болгон төлөвшүүлэхэд анхаардаг байна. Улсын Үндсэн хуульд тусган баталгаажуулсан үнэт зүйлсийг иргэний боловсролоор дамжуулан иргэдийн үнэлэмж, ертөнцийг үзэх үзэл болгон хэвшүүлдэг.

Хэдийгээр үнэт зүйлсийн талаарх шинжилгээ нь олон талтай, шинжлэх ухааны хувьд ч маргаан мэтгэлцээний томоохон талбар ч гэлээ бид МУ-ын Үндсэн хуульд тулгуурлан МУ-ын иргэний даган баримжаалах үнэт зүйлсийн цогцыг илрүүлэн гаргахыг хичээсэн бөгөөд эдгээр үнэт зүйл нь иргэний боловсролын бодлогын баримт бичиг болон хичээл сургалтын практикаар дамжин залуу үед хэрхэн хүрч байгааг шинжиллээ.

1992 оны МУ-ын Үндсэн хууль нь өнөөгийн Монгол орны нийгэм, улс төр, засаглалын харилцааны үндсийг тодорхойлж, төрийн байгууламж, хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулж өгсөн гол баримт бичиг юм. Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг шүтсэн, либерал ардчиллын үзэл баримтлалд тулгуурласан хүний эрх, эрх чөлөөг хаан боогдуулах аливаа үйлдлээс хамгаалах зорилгоор төрийн эрх мэдлийг тараан хуваарилсан улс төрийн тогтолцооны үндэс суурийг хуульчилжээ.⁸ Өөрөөр хэлбэл,

⁷ Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй. УБ, 2007, 32 дахь тал

⁸ ННФ, НҮБХХ, Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томьёоны тайлбар толь. УБ, 2006, 129 тал

Үндсэн хуулиар төр, иргэн хоёрыг нэгэн түвшинд тавьж, төрийн эрх мэдэл нь хүний эрх, эрх чөлөөг эдлэхэд саад болохгүй, хүний эрх, эрх чөлөөг хангахад үйлчилж байх зарчмыг баталгаажуулжээ.

МУ-ын Үндсэн хууль бол:


- Монгол эх орны төлөө
- Монгол Улсын иргэн бидний төлөө
- Засаг төрийн дүр зоргыг хязгаарласан шударга ёсны төлөө
- Үндэсний эв нэгдлийн төлөө
- Монголын ард түмэн бидний нийтлэг хүсэл зоригийг илэрхийлсэн
- Улсын гол хууль мөн⁹ болно.

Монголын ард түмэн бид тусгаар тогтнол үндэсний эв нэгдэл үнэтэй, бидний эрх, эрх чөлөө үнэтэй, ардчилал эрх зүйт ёс үнэтэй хэмээн хүсэл зоригоо илэрхийлж түүнийгээ Үндсэн хуулиараа бататган хамгаалсан хэрэг юм. Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн Нэгдүгээр зүйлийн 1.2-д “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээн тусгайлан заасан нь төрийн үйл ажиллагааны хүрээ хязгаар, Монголын ард түмнээс төрд тавих шаардлагыг илэрхийлж байна. Үүгээр бид төр, иргэн хоёрын эрх тэгш байдал, нийтлэг үнэт зүйлсийг баталгаажуулж байгаа хэрэг юм (Зураг 2 -ыг харна уу).

Нөгөө талаар Монголын ард түмэн бидний хөгжүүлэхээр зорьж буй нийгэм нь ардчилсан, хүмүүнлэг, иргэнлэг ёсны үнэт зүйлсийг агуулах бөгөөд энэ нь өнөөгийн нийгмийн үнэт зүйлс юм. Тухайлбал, бид Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл санаа, эрх зүйт ёс, эрх мэдэл хуваарилах ёсыг нийгмийн үнэт зүйлс болгон хамгаалсан гэж хэлж болно. Нийгмийн үнэт зүйлс нь иргэд болон нийгмийн институцүүдийн үйл ажиллагаа, амьдралын хэв маягт тусгалаа олж, итгэл үнэмшил болж тогтсон цагт жинхэнэ утгаараа үнэ цэнтэй байх болно.

⁹ Б. Чимэд, Үндсэн хуулийн мэдлэг. УБ, 2008, 33 дахь тал

Зураг 2. МУ-ын Үндсэн хуульд шингээсэн үнэт зүйлс ба Иргэний боловсролын агуулга




Бүхэлдээ ардчилал, эрх зүйт ёс, хүний эрх, эрх чөлөө, бүрэн эрхт байдал, түүхэн уламжлал, ардчиллын зарчмууд нь Үндсэн хууль дахь иргэний үнэт зүйлсийн цөм агуулгыг тодорхойлж байна.

Зураг 3. Үнэт зүйлсийн түвшин



Зураг 4. Үндсэн хууль дахь нийтлэг үнэт зүйлс



Үндсэн хуулиар хамгаалан баталгаажуулсан үнэт зүйлсийн тогтолцоо нь хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгээр дамжин нийгмийн харилцааг зохицуулах процесс, процедур болж хэлбэржээд хүний амьдралд хэрэгждэг. Боловсролын салбарт Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг дагаж мөрддөг. Энэ судалгааны хүрээнд “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (МУ-ын Их хурлын 1995 оны 36 дугаар тогтоол), “Боловсролын тухай хууль”, “Бага, дунд боловсролын тухай хууль” (2002 он), “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандарт” (2004 он), “Бага, дунд боловсролын кикриколим, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл

баримтлал” (БСШУ-ны сайдын 2002 оны 202 дугаар тушаал), “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого” болон эдгээртэй холбоотой зарим журмын уялдаа холбоог ерөнхий боловсролын хүрээнд задлан шинжилсэн болно.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод (1995) “Боловсролын үндсэн зорилго нь хүн бүрийг шинжлэх ухааны мэдлэгийг зохих түвшинд эзэмшсэн, шударга ёс, хуулийг дээдлэн сахидаг, эх оронч, соёлч, хамтач, эрүүл чийрэг, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, бие даан суралцах, ажиллаж амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”, “Боловсролын тухай” хуулийн 4.1 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” хэмээн заасан байдаг. “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 2.1 дүгээр зүйлд “Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчид ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино” гэж тодорхойлсон байдаг. Ийнхүү боловсролын талаар баримтлах бодлогын хувьд тодорхой мэдлэг, чадварын хамт эрх зүйт ёс, шударга ёсны болон түүх соёлоо эрхэмлэн дээдлэх үзэл хандлага төлөвшүүлэх зорилт дэвшүүлжээ. Мөн “Боловсролын тухай” болон “Бага, дунд боловсролын тухай” хуульд эдгээр хандлагыг давтан баталгаажуулахын хамт боловсролын тодорхой түвшин, суралцагчийн хөгжлийн байдалд тохируулан илүү нарийвчлан тодорхойлсон байна.


Мөн “Боловсролын тухай” хуулийн 5.1.2 дахь заалтад “Монгол Улсад боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх бөгөөд үндэсний болон хүн төрөлхтөний соёл иргэншлийн үнэт зүйлс, дэвшилт өв уламжлал, шинжлэх ухаанд тулгуурлана” хэмээн боловсролын зарчмыг тодорхойлжээ. Зарчим гэдэг нь тухайн зорилго, алсын хараанд хүрэхдээ даган мөрдвөл зохих замын зураглал, чиглэл бүхий хэм хэмжээний цогц гэж үздэг. Боловсролын хуулиудад туссан эдгээр зарчим нь бидний авч үзэж буй Үндсэн хуулийн зорилгуудыг агуулахын хамт шинжлэх ухаанч, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх зэрэг боловсролын үйлчилгээний онцлогийг тусгасан зарчмуудыг ч мөн агуулжээ.

Эдгээрийг хураангуйлан нэгтгэвэл, МУ-ын ерөнхий боловсролын зорилго нь:

- хүн бүрийн сурч боловсрох эрхийг хангах;
- суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх;
- суралцагчдад үнэт зүйл төлөвшихөд туслах замаар тэдний хөгжлийг хангахад чиглэж байна.

Үүнийг дараах бүдүүвч болон хүснэгтээр харуулж болох юм.

Бүдүүвч 1. Монгол Улсын ерөнхий боловсролын зорилго



Хүснэгт 1. Боловсролын баримт бичгүүд ба үнэт зүйлс

Үнэт зүйл ¹⁰	ТБББ	БХ	БДБХ	БДБКШХУБ	ЕБССББ
мэдлэг, оюун ухааны хөгжлийг эрхэмлэх	+	+	+	+	+
шударга ёс, хуулийг сахих	+				
эх оронч үзэлтэй болох	+		+		
соёлч, хамтач, эрүүл чийрэг болж төлөвших	+				
байгаль орчноо хайрлан хамгаалах	+				
бие даан суралцах, ажиллаж амьдрах	+	+	+	+	
хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг		+	+	+	
ёс суртахууны зохих чадавхитай болох		+		+	
бие бялдрын зохих чадавхитай болох		+		+	
авьяас чадвараа хөгжүүлэх			+		

¹⁰ Үнэт зүйлсийн жагсаалтыг бодлогын баримт бичгийн эрэмбээр оруулав.

Дүгнэн үзэхэд боловсролын талаарх бодлого ардчилсан хүмүүнлэг, иргэний нийгмийн үзэл санаа, эх оронч үзэл, шударга ёс, хуулийг дээдлэх зэрэг үнэт зүйлсийг зорилго ба зарчмын хувьд агуулж, иргэнийг оюун ухаан, ёс суртахуун болон бие бялдрын хувьд цогцоор хөгжүүлэн төлөвшүүлэхийг эрмэлзэж байна.

Үүнээс үндэслэн Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор баталгаажин хамгаалагдсан нийтлэг үнэт зүйлсэд тулгуурласан үзэл хандлага, итгэл үнэмшил бүхий, өнөөгийн нийгэмд ажиллаж, амьдрахад шаардлагатай мэдлэг, чадвартай, түүнийгээ хөгжүүлэх арга ухаанд суралцсан иргэдийг төлөвшүүлэх нь манай улсын иргэний боловсролын тулгуур үзэл баримтлал болно хэмээн үзэж болохоор байна. Иргэний боловсрол нь суралцагчдад ямар нэгэн шинжлэх ухааны онол, арга зүйн мэдлэгийг дамжуулан олгоход бус харин нийгмийн харилцааны олон талт байдал зэрэг зарчмуудыг өөрийн амьдрал, үйл ажиллагаанд тохируулан хэрэглэх, үнэлэх, улмаар өөрийн үнэт зүйл болгон ухааруулан ойлгуулахад чиглэдэг.

Иргэний боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд хэрэглэгдэж, цаашид улам бүр хөгжин гүнзгийрч байдаг хэрэглээ-үнэт зүйлсийн шинжтэй мэдлэг, чадвар, хандлагын цогц юм. Өөрөөр хэлбэл, “иргэн” хэмээх ойлголт нь ямар нэгэн хийсвэр нэр томъёо биш, харин гэр бүл, сургууль, анги танхим, орон нутгийн удирдлага, найз нөхөд, хамт олон зэрэгтэй нь холбогдох бодит амьдралын асуудал гэдгийг ойлгон, өөрсдийн үзэл хандлага, итгэл үнэмшлийн тогтолцоотой нэгтгэн авч үзсэнээр үр дүнд хүрэх болно. Энэхүү хандлагын үүднээс Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан үнэт зүйлсийн цогцыг иргэний боловсролын агуулгад хэрхэн буулгаж болохыг боловсролын агуулгыг тодорхойлох үндсэн хэмжигдэхүүн болох мэдлэг, чадвар, хандлагын багц үзүүлэлтээр тодорхойлох оролдлогыг хийж байна. Үүнд:

Хүснэгт 2. Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйлс боловсролын агуулгад

Үнэт зүйлийн агуулга			
	Мэдлэг	Чадвар	Үнэлэмж хандлага
Хүний эрх, эрх чөлөө	<ul style="list-style-type: none"> - Хүний эрх ба үүргийн тухай ойлголт (хүний эрхийн ангилал, зарчмууд, үүргүүд) - Хувийн ба хамтын эрхүүд - Хүний эрхийн тодорхой хязгаарлалт, хариуцлага 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн эрхийг мэдэх, эдлэх, бусдаас шаардах - Бусдын эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэх - Хуулийн дагуу эрхээ хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээх, түүний хамгаалалтын механизм 	<ul style="list-style-type: none"> - Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх - Хүний эрхийн зөрчлийг үл тэвчих
Бүрэн эрхт байдал	<ul style="list-style-type: none"> - МУ-ын бэлгэ тэмдэг - МУ-ын хил - МУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь - МУ-ын эдийн засгийн болон өмчийн харилцаа 	<ul style="list-style-type: none"> - МУ-ын төрийн бүрэн эрхт байдлын үндсийг тодорхойлох - Төрийн бэлгэ тэмдгийг ялган таних, тайлбарлах - Бэлгэ тэмдгийг зөв хэрэглэх, хүндэтгэх 	<ul style="list-style-type: none"> - Эх орны бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолоор бахархах, бусад улсын бүрэн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх
Эрх зүйт ёс	<ul style="list-style-type: none"> - Иргэн, төрийн тэгш харилцаа - Үндсэн хууль, хуулийг дээдлэх зарчим, түүний үнэт зүйлс - Эрх мэдлийн хуваарилалт - Төрийн байгуулал, тэдгээрийн эрх зүйн үндэс, төрийн эрх мэдлийн хязгаарлалт 	<ul style="list-style-type: none"> - Иргэний эрхийг хамгаалсан Үндсэн хуулийн хамгаалалтыг тайлбарлах, өөрийгөө хамгаалах - Төрийн үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд байх, иргэд нь хуулийн өмнө адил тэгш эрхтэй болохыг ойлгох - Төртэй тэгш эрхтэй харилцаж, түүний үйлчилгээг авч сурах 	<ul style="list-style-type: none"> - Хүн бүр эрх зүйн этгээд байж, улмаар хууль, шүүхийн өмнө эрх тэгш гэдгийг хүлээн зөвшөөрөх - Төр нь Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх ёстойд итгэж үнэмших
Ардчилал	<ul style="list-style-type: none"> - Ардчиллын үнэт зүйлс: тэгш эрх, шударга ёс, иргэдийн оролцоо, сонгууль, ил тод байдал, тайлагнах ёс 	<ul style="list-style-type: none"> - Сонгуульд оролцох - Үзэл бодлоо илэрхийлэх - Эвлэлдэн нэгдэх - Шийдвэр гаргах үйл явцад зохистой хэлбэрээр оролцох 	<ul style="list-style-type: none"> - Ардчиллын үнэт зүйлд итгэж үнэмших, түүнийг үйл ажиллагааныхаа хэм хэмжээ болгох
Уламжлал	<ul style="list-style-type: none"> - Хэл соёл, уламжлал, ёс заншил, шашин шүтлэг - Нүүдлийн соёл иргэншил - Эрдэм ухаан, түүх соёлын дурсгалт зүйлс 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх, ахмад хүмүүсийг хүндэтгэн харилцах, - Байгаль орчинд ээлтэй амьдрах, хамгаалах 	<ul style="list-style-type: none"> - Үндэсний соёл иргэншил, ахуйн хэв маягийг хүндэтгэх, хамгаалах - Үндэсний дэвшилтэт уламжлалыг өвлөх - Бусдын шашин шүтлэг, соёлд хүндэтгэлтэй хандах

Цаашид энэхүү үнэт зүйлс болон агуулгын зураглалд тулгуурлан иргэний боловсролтой холбоотой стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний агуулгыг судалж, иргэний боловсрол олгож буй өнөөгийн арга хэлбэр, сэдэв, агуулга нь суралцагчдад эзэмшүүлэхээр зорьж буй үнэт зүйлс, хандлага, мэдлэг чадварын төлөвшилд хангалттай эсэх, тухайн боловсролын агуулга нь суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон бөгөөд агуулгын болон хандлагын залгамж холбоог хадгалж чадсан эсэх талаарх шинжилгээг энэхүү бүлгийн дараагийн хэсэгт танилцуулсан болно.

2.2. ҮНЭТ ЗҮЙЛ БА НИЙГМИЙН УХААНЫ БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ЕБС-ийн Иргэний боловсролд үнэлгээ, мониторинг хийх энэхүү судалгааны хүрээнд МУ-ын Үндсэн хууль дахь иргэний үнэт зүйлсийг зураглан гаргаж ирсэн дээрээ үндэслээд тухайн үнэт зүйлс нь боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт хэрхэн туссаныг шинжилж үзлээ. Үнэт зүйл нь агуулгын хувьд мэдлэг, мэдлэгийн тогтолцоо байдаг бол түүнийг өөрийн итгэл үнэмшил болгон төлөвшүүлэхэд тусгайлан боловсруулсан агуулга, арга зүй-дидактик боловсруулалт, үнэлгээ шаардлагатай бөгөөд үүнийг боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрөөр илэрхийлдэг.

Энэхүү шинжилгээ нь танхимын хичээлийн мониторинг хийх суурь, хүрээ болсон бөгөөд уг мониторингийн дүнг энд танилцуулж байна.

Нийгмийн ухааны боловсролын стандарт

Боловсролын стандарт нь ЕБ-ын түвшинд хүрэхээр зорьж буй үр дүнг тодорхойлж өгсөн норматив баримт бичиг болохынхоо хувьд заавал биелэгдэх шинжийг агуулдаг учраас энэхүү стандарт нь хүүхэд, залуучуудад хүний эрх, эрх зүй болон ардчиллын боловсролын чиглэлээр үнэт зүйлс, үр чадвар эзэмших боломжийг хангаж байгаа эсэхийг илрүүлэх нь МУ-ын Үндсэн хуулиар хамгаалан баталгаажуулсан үнэт зүйлс нь суралцагчийн ширээнд бууж, тэдний итгэл үнэмшил болон тогтох үйлийн суурь үндэс болно.

Ерөнхий боловсролыг олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн өөрчилж байгаагийн нэг жишээ нь стандартад түшиглэсэн боловсролын үзэл санааг нэвтрүүлэхэд чиглэсэн багц арга хэмжээ юм. Ерөнхий боловсролын шинэ стандартыг 2002 оноос эхлэн боловсруулж, 2004 оноос батлан хэрэгжүүлж эхэлжээ. Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт нь (ТНУБ-ын стандарт гэх) түүх, эрх зүй боловсролын болон нийгмийн тухай мэдлэгийн боловсролын стандартаас бүрдэж байна.¹¹ Уг стандартууд нь ерөнхий боловсролын дараах түвшинг хамран хэрэгжихээр байна.

Хүснэгт 3. Түүх, эрх зүй болон нийгмийн тухай мэдлэгийн боловсролын стандарт ба ЕБ-ын түвшин

ТНУБ-ын стандарт	Ерөнхий боловсролын түвшин ¹²		
	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Түүхийн боловсрол	Байхгүй		Байхгүй
Нийгмийн тухай мэдлэг	Байхгүй	Байхгүй	
Эрх зүйн боловсрол			

Боловсрол судлаачдын үзэж байгаагаар, шинэчилсэн стандарт нь дараах давуу талтай ажээ:

- Судлагдахууны агуулгыг шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан сонгон боловсруулж байсан хандлагыг өөрчилж, аль болох шинэ зууны иргэнд төлөвшсөн байвал зохих мэдлэг бүтээх, хийж сурах, амьдарч сурах, нийгэмшин иргэншиж сурах зэрэг цогц чадамжийг баримжаалан сонгосон.
- Судлагдахууныг тухайн боловсролын хувьд үндсэн, тогтвортой, энгийнээс нарийн, хөнгөнөөс хүндэд шилжих мэдлэг, анхан, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд анхан шатны болон үндсэн ойлголт нь хэвээр хадгалагдаж, агуулгын хувьд гүнзгийрэн баяжих логиктой мэдлэгийн цөм (хүрээ) буюу агуулгын айгаар тодорхойлсон. Тухайлбал, эрх зүйн боловсрол нь ерөнхий боловсролын аль ч

¹¹ МУ-ын стандарт. Бага, дунд боловсрол. Түүх, нийгмийн ухааны боловсрол. MNS 5420-14:2004. Албан хэвлэл. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв. УБ хот.

¹² Монгол Улсын хууль. Боловсролын тухай. Бага, дунд боловсролын тухай. 2002 он. 3 дугаар зүйл. 3.1.2, 3.1.4, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйл. 7.2

түвшинд “Дүрэм, журам, хууль”, “Эрх, үүрэг”, “Төрийн байгуулал”, “Салбар эрх зүй” гэсэн агуулгын айтай байна.

- Зөвхөн юу заахыг тогтоодог байсан өмнөх практикийг халж яагаад, юуны тулд, юуг, яаж заах, яаж үнэлэх зэрэг асуултад хариулж чадахуйц норматив баримт бичиг болсон.

Энэхүү судалгааны хүрээнд бид ТНУБ-ын стандартаас ТНУ-Эрх зүйн боловсролын стандарт, ТНУ-Нийгмийн тухай мэдлэгийн стандартыг сонгон шинжилсэн бөгөөд учир нь бидний өмнөх хэсэгт авч үзсэн МУ-ын Үндсэн хууль дахь (иргэний) үнэт зүйлсийн зураглалаар тодорхойлсон үнэт зүйлс нь ЕБС дахь иргэний боловсролын сургалтын баримт бичигт хэрхэн тусгалаа олсныг харьцуулан үзэх боломж олгоно гэж үзсэн болно. Нөгөө талаар бидэнд иргэний боловсролын тусгайлсан стандарт байхгүй байгаа нь дээрх стандартуудыг сонгож шинжлэх үндэс боллоо.

Үндсэн хуульд тулгуурлан тодорхойлж авсан үнэт зүйлс нь Нийгмийн ухааны боловсролын стандартад агуулгын хувьд тусгагдсан байна гэж бид дүгнэлээ. Тухайлбал, стандартын зорилтыг мэдлэгийн ай¹³ тус бүрийн хүрээнд мэдэхүйн, чадахуйн, оршин байхуйн, нийгэмшин амьдрахуйн цогц чадамжийг төлөвшүүлэх явдал хэмээн тодорхойлж, уг цогц чадамжид хамаарах мэдлэгийн хүрээг ялгахын зэрэгцээ уг мэдлэгийн хүрээнд эзэмшсэн байх чадварыг тодорхойлж өгсөн байна.

Мөн үнэлгээний стандартын хүрээнд цогц чадамж эзэмшилтийн түвшинг тогтоох үнэлгээний шалгуурыг стандартчилжээ. Харин энэхүү стандартын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд үнэлэх үнэлгээ хараахан хийгдээгүй байна.

¹³ Хүснэгтээс харах

Хүснэгт 4. ТНУ-Нийгмийн тухай мэдлэгийн стандарт

Ай ¹⁴	Мэдлэг	Чадвар	Үнэлэмж/Хандлага	
Нийгмийн тухай мэдлэг	Нийгмийн ойлголт	Нийгэм	- Мэдлэг, ойлголтыг	- Нийгэмшлийн үнэт
		Нийгмийн харилцаа, төрөл	тайлбарлах, задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх	зүйлсийг эзэмших
		Нийгмийн амьдралын хүрээ	- зэрэг аналитик чадвар	- Нийгмийн тодорхой хэв маягийн соёлыг хүндэтгэх
		Нийгмийн хэв маяг	- Социологийн энгийн судалгаа хийх, хэлэлцэх, жишээ, баримт цуглуулах зэрэг харилцаа, оролцооны чадвар	
	Улс төр	Улс төр	- Улс төртэй холбоотой мэдлэг, ойлголтыг	- Улс төрийн соёл, ардчиллын соёлд суралцах, түүнийг түгээн дэлгэрүүлэх
		Улс төрийн эрх мэдэл, хуваарилалт	тайлбарлах, задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, мэдээлэл боловсруулах зэрэг аналитик чадвар	
		Улс төрийн систем		
		Улс төрийн шийдвэр ба оролцогчид	- Улс төрийн амьдралд оролцох, сонголт хийх чадвар	
		Ардчилал		
	Эдийн засаг	Эдийн засаг	- Эдийн засагтай холбоотой ойлголт, эдийн засгийн үзэгдэл, үйл явдлыг	- Эдийн засгийн сонголтод хариуцлагатай хандах
		Эрэлт, нийлүүлэлт, үнэ	тайлбарлах, ажиглах, задлан шинжилгээ хийх, орлого, зарлага хэмнэлтийг тооцоолох, хэмжих	- Шийдвэр гаргахад оролцох нь чухал болохыг ойлгох, оролцохыг эрмэлзэх
		Өрсөлдөөн, монополь		
		Хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлт		
		Санхүү, төсөв	- Эдийн засгийн талаар мэдээлэл солилцох, санал боловсруулах, хамтын шийдвэр гаргах	
		Мөнгө, зээл, банк		
		ҮЭЗ-ийн нэгдмэл үзүүлэлт, гадаад хамтын ажиллагаа		
	Нийгмийн давхраажил	Нийгмийн давхраажилт	- Айн хүрээний мэдлэг, ойлголтыг тайлбарлах, нийгэмд эзлэх өөрсдийн байр суурь, статусыг тодорхойлох	- Нийгмийн бүлгүүдтэй хамтран ажиллах, ойлголцох
		Монголын нийгмийн давхраажилт		
		Шилжих хөдөлгөөн	- Нийгмийн бүлгүүдтэй харилцаж, өөр өөр нөхцөл байдалд дасан зохицох	- Бусдын статусыг хүлээн зөвшөөрөх
		Нийгмийн хамгаалал		
Соёл	Соёл	- Айн хүрээний мэдлэг ойлголтыг тайлбарлах, харьцуулах, хамаарлыг тодорхойлох, хэлэлцэх	- Бусдын соёлыг хүндэтгэх, тэдний баримталдаг хэм хэмжээ, үнэлэмжид хүлээцтэй хандах	
	Соёлын бүтэц, бүрэлдэхүүн			
	Соёлын хэлбэр	- Нийгмийн судалгааны энгийн аргуудыг хэрэглэх		

¹⁴ Монгол Улсын стандарт. Бага, дунд боловсрол. Түүх, нийгмийн ухааны боловсрол. MNS 54-14:2004. Албан хэвлэл. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв. УБ хот.

Хүснэгт 5. ТНУ-Эрх зүйн боловсролын стандарт

Ай ¹⁵	Ерөнхий боловсролын түвшин		
	Бага	Суурь	Бүрэн дунд
Мэдлэг	- Дүрэм, журам	- Хуулийн тухай ойлголт - Хуулийг бүтээх тухай ойлголт	- Хэрэг хянан шийдвэрлэх хуулиуд, холбогдох заалт - Бизнесийн хүрээнд үйлчилдэг хуулиуд
Чадвар	- Анги, хамт олны хүрээнд дүрэм, журам баримтлахын учрыг тайлбарлах - Өөрсдийн мөрдөх дүрмийг боловсруулах, мөрдөх	- Хуулийн тухай ойлголт, хууль нь нийгмийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байгааг, хууль хэрхэн төрдгийг, иргэд түүнд хэрхэн оролцдогийг тайлбарлах - Хуулийг дагаж мөрддөг, хуулийн хэрэгжилтийн талаар өөрийн санал бодлыг илэрхийлэх - Дүрэм, журам болон хуулийн заалт боловсруулж, тэр тухай хэлэлцэж, мэтгэлцэж, зөвшилцөж сурах	- Захиргааны болон хэрэг хянан шийдвэрлэх, бизнес эрхлэх явцад үүсдэг харилцааг зохицуулдаг хуулиудыг нэрлэх, тэдгээрийн зарим зүйл заалтыг тайлбарлах - Холбогдох хууль, тогтоомжийг ашиглан төр, захиргааны болон шүүх байгууллагуудтай бие даан харилцаж чаддаг болох; асуудалд эрх зүйн үүднээс хандах, асуудлын эрх зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлох чадварт суралцах
Үнэлэмж/Хандлага	- Дүрэм, журмыг даган биелүүлэх - Бусдын санаа бодлыг хүндэтгэх	- Хууль нь нийгмийн харилцааг зохицуулдаг болоход итгэх, түүнийг дагаж мөрдөх соёл суралцах	-- Үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулж, хариуцлага хүлээдэг болох
Мэдлэг	- Хүүхдийн эрх, үүрэг	- Хүний эрх, эрх чөлөө - Хувийн, нийгэм, соёлын болон эдийн засаг, улс төрийн эрхийн зарим ойлголт - Хүний эрхийн түгээмэл тунхаглал, МУ-ын Үндсэн хуулийн тухай	- Эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг

¹⁵ Монгол Улсын стандарт. Бага, дунд боловсрол. Түүх, нийгмийн ухааны боловсрол. MNS 54-14:2004. Албан хэвлэл. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв. УБ хот.

Хүснэгт 5. /Үргэлжлэл/

Чадвар	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн эрх, үүргийн талаар тайлбарлах, баримт бичгүүдээс нэрлэх - Хүүхдийн эрхийн хэрэгжилт, эрх, үүргийн зөрчлийн талаар өөрийн санаа, бодлыг илэрхийлэх, зөрчлийг арилгах талаар өөрийн санал бодлыг дэвшүүлж сурах 	<ul style="list-style-type: none"> - Тухайн айгаар үзэж, судалсан үндсэн ойлголт, ухагдахууныг тайлбарлах, хүний эрхийн зарим, үндсэн баримт бичгүүдийг нэрлэх, агуулгыг тайлбарлах - Хүний эрхийн зөрчлийг таньж, түүнийг шийдвэрлэх талаар санал дэвшүүлэх, ашиглах чадвартай болох - Тодорхой хууль болон олон улсын баримт бичгээр хүний эрхийг хамгаалж байдгийг ойлгож, зөрчигдсөн эрхээ сэргээхэд тэдгээр хуулиудыг ашиглаж сурах (жишээлбэл, өмч хөрөнгө эзэмших эрх зөрчигдвөл иргэний хуулийг ашиглах зэрэг) 	<ul style="list-style-type: none"> - Эрх зүйн харилцаанд оролцогчдын (тухайлбал, иргэн-захиргааны байгууллага, сэжигтэн-цагдаагийн ажилтан, шүүгдэгч-шүүгч, прокурор, өмгөөлөгч гэх мэт) эрх, үүргийг тодорхойлж, тайлбарлаж чаддаг байх - Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар өөрийн санал, дүгнэлттэй болох
Үнэлэмж/ Хандлага	<ul style="list-style-type: none"> - Хүн бүр эрхээ эдэлж, үүргээ биелүүлж, дүрэм, журмаа мөрддөг болохыг ойлгож, бусдын эрхийг хүндэтгэж сурах; - Хамтран ажиллахдаа дүрэм, журмыг сахиж, эрхээ зөв эдэлж, үүргээ биелүүлж, хариуцлага хүлээж сурах 	<ul style="list-style-type: none"> - Хүмүүс, хамт олонтой харилцахдаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн өөрийн эрх, үүргээ хэрэгжүүлж, биелүүлж сурах 	<ul style="list-style-type: none"> - Үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх чадвартай болох
Мэдлэг	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн захиргаа болон сум, дүүрэг, баг, хорооны засаг дарга - Дүрэм, журам баталдаг байгууллага, хүмүүс 	<ul style="list-style-type: none"> - Төрийн эрх мэдэл, түүний хуваарилалт - Нутгийн удирдлагын байгууллагууд 	<ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн эрх зүйн үндэс - Төрийн албан хаагч - Захиргааны зөрчил ба хариуцлага

Хүснэгт 5. /Үргэлжлэл/

Чадвар	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн болон сургуулийн удирдах ажилтнуудтай хэрхэн харилцах, тэдэнд хэрхэн хандах талаар суралцах 	<ul style="list-style-type: none"> - Төрийн эрх барих дээд байгууллагуудын (УИХ, Засгийн газар, шүүх) эрх, үүргийг мэдэж, түүнийг тайлбарлах - Төрийн байгууллага, албан тушаалтанд хандах, асуудал шийдвэрлүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Төрөөс иргэнд үзүүлэх үйлчилгээг тодорхойлж, жишээ баримт гаргах, тайлбарлах - Төрийн байгууллагатай харилцаж чаддаг болох
Үнэлэмж/Хандлага	<ul style="list-style-type: none"> - Төрөө хүндэтгэдэг, түүний үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч сурах 		<ul style="list-style-type: none"> - Төрийн хууль тогтоомжийг сахих, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээж сурах
Мэдлэг	<ul style="list-style-type: none"> - Иргэний эрх зүйн тухай ойлголт - Хөдөлмөрийн эрх зүйн тухай ойлголт - Гэр бүлийн эрх зүйн тухай ойлголт - Нийгэм хангамжийн эрх зүйн тухай ойлголт - Хүмүүнлэгийн эрх зүйн тухай ойлголт 		<ul style="list-style-type: none"> - Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа - Бизнесийн эрх зүй
Чадвар	<ul style="list-style-type: none"> - Тодорхой салбар эрх зүйн талаар үндсэн мэдлэг эзэмшиж, тэдгээрийн гол гол ухагдахууныг тайлбарлах - Тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх зүйн болон бусад мэдээллийг олж түүнийгээ хэрхэн ашиглах арга замыг тодорхойлох 		<ul style="list-style-type: none"> - Захиргааны, хэрэг хянан шийдвэрлэх, бизнесийн зэрэг салбар эрх зүйн тухай ойлгож, тайлбарлах - Аливаа асуудалд олон талаас нь бодитой, шүүмжлэлтэй хандаж сурах, асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэслэлийг гаргаж сурах
Үнэлэмж/Хандлага	<ul style="list-style-type: none"> - Хамт олонтойгоо болон харилцаанд оролцогч талуудын эрхийг хүндэтгэж, өөрийн эрх, үүргийг ухамсарлаж, хариуцлага хүлээдэг болох 		<ul style="list-style-type: none"> - Төрийн хууль тогтоомжийг сахин мөрдөж, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээж сурах

Боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр зэрэг нь онцгой ач холбогдолтой. Сургалтын төлөвлөгөө нь тухайн ангийн сурагчдын эзэмших агуулга болон тэдний ачаалал, багшийн нөөц зэргийг тооцож хийсэн, тухайн хичээлийг судлахад заавал баримтлах цагийн сүлжээ байдаг бол сургалтын хөтөлбөр нь тогтоосон хугацаа, тодорхойлсон нөөцийг ашиглан боловсролын стандартаар шаардсан үр дүн, чанарт хэрхэн хүрч болох технологийн шийдлийг илэрхийлсэн арга зүйн¹⁶ удирдамж байдаг.

¹⁶ Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого (БСШУ-ны сайдын 2006. 236 дугаар тушаал)

Нийгмийн ухааны сургалтын төлөвлөгөө

Боловсролын шинэчилсэн стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдон шинэчлэн боловсруулсан сургалтын төлөвлөгөөгөөр “Иргэншил” хичээл шинээр нэмэгдсэн бөгөөд “Иргэний боловсрол”-ыг хичээлээс гадуурх цагаар судлах болсон байна. ЕБС-д дээрх стандартыг “Хүн-орчин”, “Хүн-нийгэм”, “Иргэншил”¹⁷, “Иргэний боловсрол” зэрэг нэртэй хичээлээр дамжуулан хэрэгжүүлж байна. Эдгээр хичээлийг 5+4+2 бүтэцтэй, 11 жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу дараах хүснэгтэд үзүүлсэн цагаар судалж байна.

Хүснэгт 6. Нийгмийн ухааны хичээлийн цаг, анги

№	Нийгмийн ухааны хичээл	Судлах		Хичээлийн хэлбэр
		анги	цаг	
1.	Нийгмийн тухай мэдлэг	10-11-р ангид	Долоо хоногт 3 цаг	Заавал судлах хичээл
2.	Иргэншил	6-9-р ангид	Долоо хоногт 1 цаг	
3.	Иргэний боловсрол	1-11-р ангид	Долоо хоногт 1 цаг	Хичээлийн бус хэлбэрээр
4.	Хүн-орчин	1-3-р анги	Долоо хоногт 1 цаг	Заавал судлах хичээл
5.	Хүн-нийгэм	4-5-р анги	Долоо хоногт 1 цаг	Заавал судлах хичээл

12 жилийн сургалт нь 6+3+3 бүтэцтэй байх бөгөөд одоогоор бага боловсролын 1-4-р ангийн, суурь боловсролын 7-9-р ангийн сургалтын төлөвлөгөө батлагдсан байна.¹⁸ Энэхүү төлөвлөгөөнөөс харахад тухайн ангид нэг долоо хоногт судлах цаг хэвээрээ байна. Нийтдээ иргэний боловсролыг олгож буй хичээлүүд нь бага боловсролд 318, суурь боловсролын түвшинд 210, бүрэн дунд боловсролын түвшинд 420 хүртэл цагаар судлагдахаар байна.

Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр

Ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үр ашгийг сайжруулах чиглэлээр хийж буй ажлын гол нь

¹⁷ 2010-2011 оны хичээлийн жилээс “Нийгмийн ухаан” нэртэй хичээл болсон (БСШУ-ны сайдын тушаалаар)

¹⁸ Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн YIII-IX ангийн сургалтын төлөвлөгөө (БСШУ-ны сайдын 2010 оны 201 дүгээр тушаалын хоёрдугаар болон гуравдугаар хавсралт)

үндэсний сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх явдал болж байна. Энэ хүрээнд ЕБ-ын 12 жилийн сургуулийн шилжилтийн 7-р ангийн болон 1-3, 8-р ангийн сургалтын хөтөлбөр боловсруулагдан баталгаажиж хэрэгжих шатандаа явж байна. ЕБ-ын 11 жилийн тогтолцооны ангиудын (8-11-р анги) хувьд Боловсролын хүрээлэнгээс гаргасан агуулгын хүрээг баримтлан сургууль, багш нар өөрсдөө сургалтын хөтөлбөр боловсруулан, хичээллэж байна. Бид энэхүү судалгаанд 12 жилийн сургуулийн шилжилтийн 7 ба 8-р ангийн сургалтын хөтөлбөр болон танхимын хичээлийн мониторингт хамрагдсан 11 жилийн 9-р ангийн агуулгын хүрээг сонгон шинжилсэн болно.

ЕБ-ын 12 жилийн сургуулийн шилжилтийн 7, 8-р ангийн сургалтын хөтөлбөр нь дараах бүтцээр боловсруулагджээ:

Хүснэгт 7. Тухайн ангийн сургалтын хөтөлбөрийн бүтэц

..... ДУГААР АНГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР					
Хүлээгдэж буй ерөнхий үр дүн:					
Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг	Хүлээгдэж буй үр дүн	Сурах-сургах агуулга			Үнэлгээ
		Мэдлэг	Чадвар	Хэрэглээ	
Арга зүй, хэрэглэгдэхүүн:					
Сургалтын хөтөлбөр	Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг				
	Эрх зүй	Эдийн засаг	Ёс зүй	Нийгэм, нийгмийн харилцаа	
Шилжилтийн 7-р ангийн	+	+	+		
8-р ангийн	+	+	+	+	

Тус хоёр ангийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг харьцуулж үзэхэд хүлээгдэж буй ерөнхий болон тодорхой үр дүнгээр сурагчдад төлөвшүүлэх үнэт зүйл, хандлагыг тодорхойлсон, агуулгын хувьд мөн үнэт зүйлсийг агуулсан, залгамж холбоо нь хадгалагдсан байна.

Хүлээгдэж буй ерөнхий үр дүнг суурь боловсролын эрх зүйн болон бүрэн дунд боловсролын нийгмийн тухай мэдлэгийн стандартын цогц чадамжид баримжаалан тодорхойлсон бөгөөд агуулгын тогтолцоо бүрийн хувьд хүрэх тодорхой үр дүнг гаргаж өгсөн байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэглээ хэсэгт агуулгын хэсгийн мэдлэг, чадвараа хэрэглэх үйл ажиллагааг оруулж өгсөн нь сурагчдад дадал, хандлага тогтоох идэвхтэй үйл ажиллагааг төлөвлөхөд багшид дэмжлэг болохуйц ач холбогдолтой байна. Тухайлбал, эрх зүйн агуулгын тогтолцооны хүрээнд хүний эрхийн тухай судлахдаа мэдлэг чадвар, өөрсдийн боловсруулсан хүний эрхийн хэмжүүр үзүүлэлтийг ашиглан зан үйлээ үнэлэхэд хэрэглэх, дүрэм журмын тухай судлахдаа хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлаар орон нутгийн төр захиргааны байгууллагад хандах зэрэг хэрэглээг тусгасан байна.

ЕБ-ын 11 жилийн сургуулийн 9-р ангийн иргэншил хичээлийн агуулгын үлгэрчилсэн хүрээнд¹⁹ “иргэншлийн тухай ойлголт, ёс зүйн хэм хэмжээ, дүрэм журам хууль, эрх үүрэг, төрийн байгуулал” гэсэн мэдлэгийг ялгаж, энэ хүрээнд эзэмших чадвар, хандлагыг тодорхойлжээ. Энд мөн Энэтхэг, Япон, Лал болон Оросын иргэншлийн хэлбэрүүдийг тодорхойлох гэсэн иргэний боловсролд хамаарахгүй агуулгыг оруулахын зэрэгцээ “төрийн байгуулал” мэдлэгийн хүрээнд захиргааны, эрүүгийн, иргэний эрх зүйн тухай оруулсан зэрэг алдаа мадагтай зүйл байгаа нь 12 жилийн сургалтын хөтөлбөр болон сурах бичгийн агуулгаар залруулагдан хэрэгжиж байна.

ТНУ - Эрх зүйн боловсролын стандарт, ТНУ - Нийгмийн тухай мэдлэгийн стандарт болон иргэншил, нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрт Үндсэн хуулиар баталгаажуулан хамгаалсан үнэт зүйлс болох ардчилал, хүний эрх, эрх зүйт ёсны зарчмууд тусгагдсан гэж үзэж болохоор байна. Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр суралцагчид аналитик чадвараа хөгжүүлэхээс гадна оролцоо, харилцаа, шийдвэр гаргалт, мэдээлэл боловсруулахтай холбоотой чадвараа хөгжүүлэх боломжтой байна. Мөн тэдэнд бусдын сонирхол, үзэл бодол, ялгаатай соёлыг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх, нийцтэй, хүлээцтэй хандах, үүрэг хариуцлага хүлээх зэрэг үнэлэмж төлөвшүүлэхийг зорилго болон хүлээгдэж буй үр дүн хэлбэрээр тодорхойлсон байна.

ЕБ-ын стандарт, агуулгад хүний эрх, ардчилал, иргэний боловсролын агуулга, үнэт зүйлсийг багтаасан нь сайн боловч эдгээрийг танхимын сургалтын явцад хэрэгжүүлэхгүй, ардчиллын боловсролын үзэл санаа нь суралцагч хүүхэд залуучуудад үнэт зүйлийг төлөвшүүлж чадахгүй байгаа

¹⁹ Боловсролын хүрээлэн (2006). ЕБ-ын 11 жилийн сургуульд 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ (дунд, ахлах анги), 33 дугаар тал. УБ

нь судалгаанаас харагдаж байна.²⁰ Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зүйлс хэрэгжилтийн түвшинд ажил хэрэг болохгүй байгаагийн нэг жишээ нь Иргэний боловсрол болох вий гэсэн сэрэмжлэл төрж байлаа.

Сурах бичиг

Ерөнхий боловсролын сургуульд сургалтын гол хэрэглэгдэхүүн нь сурах бичиг байна. 11 жилийн сургалттай ангиудад дараах сурах бичгүүд сургалтад ашиглагдаж байгаагийн зэрэгцээ²¹ 12 жилийн 8-р ангийн Нийгмийн ухааны сурах бичиг шинээр боловсруулагдаад байна. Бид ангийн мониторингийн хүрээнд хамрагдсан 11 жилийн сургуулийн 9-р ангидүзэжбайгааИргэншил-IIсурахбичгийгсонгонанализхийсэнбөгөөд өмнөх залгамж холбоог харах үүднээс Иргэншил I-тэй харьцууллаа.

Хүснэгт 8. Ашиглагдаж буй сурах бичиг

Сурах бичгийн нэр	Анги	Хэвлэлийн газар	Тайлбар
Иргэншил-I, II /11 жилийн ангиудад/	8-9-р анги	Урлах эрдэм	12 жилийн шилжилтийн 7-р ангид эдгээр сурах бичгээс ашиглаж байна
Нийгмийн ухаан /11 жилийн ангиудад/	10-11-р анги	Мөнхийн үсэг	2010 онд шинэчлэгдсэн

Хүснэгт 9. Сурах бичгийн агуулга

"Иргэншил-1"		"Иргэншил-2"	
6-7-р анги	8-р анги	9-р анги	
Хүн ба харилцаа	Иргэн ба нийгэм	Иргэн ба засаг захиргаа	
Хүн, түүний эрхэм чанар	Иргэний ёс суртахуун	Иргэний үнэт зүйлс	
Хүн ба хууль	Иргэний эрх ба үүрэг	Иргэний нийгмийн тухай	
Хүний эрх	Хууль ба үнэт зүйл	Иргэний эрх зүйн тухай ойлголт	

Суурь боловсролын Иргэншлийн хичээлийн агуулга нь ёс зүйн хэм хэмжээг эзэмших, эрхээ эдэлж, үүрэг, дүрэм, журмаа биелүүлэхэд шаардлагатай мэдлэг эзэмшүүлэх, хамтран ажиллах, өөрийгөө

²⁰ Энэхүү судалгааны хүрээнд хийсэн ангийн мониторингийн дүн болон бусад судалгааны тайлан

²¹ БСШУ-ны сайдын тушаалаар (2006 оны 04 дүгээр сарын 21 №133) батлагдсан 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглэх сурах бичгийн жагсаалт

илэрхийлэх зэрэг иргэний оролцооны чадваруудыг хөгжүүлэх зэрэг иргэний боловсролын бүрдэл хэсгүүдийг хамарсны зэрэгцээ нийгэм, иргэний нийгэм, засаг захиргааны тухай судлах бүрэн дунд боловсролын нийгэм судлалын хичээлийн суурь үндсийг тавихад чиглэсэн байна.

Мөн бүрэн дунд боловсролын “Нийгмийн ухаан”, дээр авч үзсэн “Иргэншил-1, 2” сурах бичигт нийгмийн ухаан, иргэний боловсролын чиглэлийн агуулга хэрхэн тусгагдсан, түүний залгамж холбоо хангагдсан байдлыг авч үзлээ.

Хүснэгт 10. Сурах бичгүүдийн агуулгын залгамж холбоо

Агуулгын ай	Сурах бичгийн агуулга	
	Иргэншил (6-7-р анги)	Нийгмийн ухаан (10-11-р анги)
Улс төрийн ай	<ul style="list-style-type: none"> - Улсыг удирдах байгууллага ба хүмүүс - Хууль гэж юу вэ? - Хүний эрхийн тухай ойлголт - Зарим тодорхой эрхийн тухай - Эрхийн хязгаарлалт ба хамгаалалт 	<ul style="list-style-type: none"> - Ардчиллын тухай ойлголт, үнэт зүйлс - Улс төр, улс төрийн системийн тухай ойлголт (төр, нам, сонирхлын бүлгүүд) - Сонгогч ба сонгогдогчид
Эдийн засгийн ай	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэгч ба хэрэглэгч - Мөнгө - Татвар 	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн тогтолцоо - Эдийн засаг, зах зээлийн эдийн засгийн тухай ойлголт - Эрэлт, нийлүүлэлт, үнэ, өрсөлдөөн, ажилгүйдэл, инфляци - Эдийн засаг дахь төрийн оролцоо
Нийгмийн ай	<ul style="list-style-type: none"> - Хүмүүс хэрхэн харилцдаг вэ? - Нийгэм олон талт харилцаа болох нь - Хүн ба нийгмийн харилцаа - Нийгмийн бүлгүүд 	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн тэгш биш байдал ба давхраажилт, нийгэм дэх ангиуд - Нийгэм дэх шилжих хөдөлгөөн
Ёс суртахууны ай	<ul style="list-style-type: none"> - Сайн хүн гэж хэн бэ? - Ёс зүйн тухай ойлголт - Ёс зүйн хэм хэмжээ - Хүний зан чанар 	<ul style="list-style-type: none"> - Нийгэмшил - Соёлын бүтэц (хэл, мэдлэг, албан ба албан бус хэм хэмжээ, үнэлэмж) - Соёлын хэлбэрүүд (элитийн, ардын, нийтийн, дагуул, сөрөг)

Үндсэн сурах бичгүүдэд хийсэн шинжилгээнээс үзэхэд түүх, нийгмийн ухааны боловсролын агуулга, түүний залгамж холбоог сурах бичгээр шийдэх оролдлого хийж байсан нь харагдаж байна. Энэхүү шинжилгээг зөвхөн агуулгын хүрээнд хийсэн бөгөөд арга зүйн болон дидактик боловсруулалтыг авч үзээгүй болно.

ЕБ-ын 12 жилийн тогтолцоонд шилжихтэй холбогдон иргэний боловсрол олгоход чиглэсэн сургалт өөрчлөгдөж байгаа. Үүнд:


- Ерөнхий боловсролын сургуулиар дамжуулан олгож буй нийгмийн ухааны боловсролын тогтолцоо шинэчлэгдэн боловсронгуй болж байна. Тухайлбал, нийгмийн ухааны боловсролын агуулгыг ерөнхий боловсролын бага, суурь, бүрэн дунд гэсэн бүх түвшинд залгамж холбоотой судлах эхлэл тавигджээ “Иргэншил” хичээлийг “Нийгмийн ухаан” гэсэн нэрээр сольсноор иргэний боловсрол олгох агуулга нь өөрчлөгдөхгүй гэж холбогдох мэргэжилтнүүд үзэж байгаа юм байна.

Хүснэгт 11. Хичээлийн залгамж чанар

ЕБ-ын түвшин	Бага боловсрол						Суурь боловсрол			Бүрэн дунд боловсрол		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Анги												
Хичээлийн тогтолцоо	Хүн орчин			Хүн-нийгэм			Нийгмийн ухаан			Нийгмийн ухаан		

- Суурь боловсролын нийгмийн ухаан болон иргэний боловсролын стандарт одоогоор боловсруулагдаагүй байгаа тул сургалтын хөтөлбөрийг эрх зүйн боловсролын стандартад түшиглэн нийгмийн ухааны бүрэн дунд боловсролын стандартыг баримжаалан боловсруулж байна. Тухайлбал, бүрэн дунд боловсролын шатанд эзэмших нийгмийн цогц чадамжийг бүрэн төгс эзэмшүүлэхийн тулд суурь боловсролын шатанд эх үндэсийг нь тавих хэрэгтэй гэж үзэн дараах бүдүүвчид (Зураг 7) үзүүлсэнчлэн шилжилтийн 7-р ангийн сургалтын хөтөлбөрөөс эхлэн эдийн засаг, 8-р ангийн сургалтын хөтөлбөрөөс эхлэн нийгэм, нийгмийн харилцааны агуулга тус тус тусгагджээ.
- 12 жилийн 8-р ангид хэрэгжих Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн агуулга нь өмнө хэрэгжүүлсэн 12 жилийн шилжилтийн 7-р ангийн иргэншилийн хөтөлбөрийн агуулгатай зохих залгамж холбоотой бөгөөд бүрэн дунд боловсролын нийгмийн ухааны хичээлийн суурь болох үүднээс нийгэм, нийгмийн харилцааны тухай агуулгыг нэмж тусгасан онцлогтой.

Зураг 5. НУБ-ын агуулгын тогтолцооны хүрээ



Ерөнхий боловсролоор олгож буй иргэний боловсролд хамаарах баримт бичгүүдэд хийсэн шинжилгээнээс үзэхэд нийгмийн ухааны сургалтад дараах асуудал тулгарч байна гэж үзэж болохоор байна. Үүнд:

- Нийгмийн ухааны болон иргэний боловсролын стандартыг дахин боловсруулах, боловсронгуй болгох асуудал тавигдаж байна. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг судалснаар одоо мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэх боломжгүй байна. Учир нь:
 - Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт нь тухайн боловсролын гэхээсээ илүү хичээл дагаж боловсруулагдсан тул тухайн хичээл өөрчлөгдөхөд стандарт хэрэгжих боломжгүй болсон байна. Тухайлбал, 1998-2004 оны сургалтын төлөвлөгөөгөөр “Эрх зүй” хичээл судалж байсан бол 2005 оны хичээлийн жилээс сургалтын төлөвлөгөө өөрчлөгдөж “Хүн ба орчин”, “Хүн ба нийгэм”, “Иргэншил”, “Иргэний боловсрол” хичээл судлагдах болсон байна.
 - Стандарт байхгүйгээс иргэний боловсролын сургалтын агуулгыг эрх зүйн боловсролын стандартыг баримжаалан сонгож байгаа нь уг боловсролын агуулгыг өрөөсгөл болгож байна.
 - Тухайн боловсролын стандарт нь ерөнхий боловсролын түвшинд залгамж холбоотой, нэвт хэрэгжиж байх ёстой юу, түвшин бүрээр хангагдаж чадахуйц байх уу гэдэг асуудлыг шийдэх хэрэгтэй болгож байна.

- ЕБС-иар олгож буй нийгмийн ухааны боловсролын (сургалтын) нөхцөл байдлаас үзэхэд уг боловсролыг олгох хичээлийн нэршлийг тогтоох, агуулгыг сонгох, хичээлийн ба хичээлийн бус үйл ажиллагааны хэсэгт оновчтой хуваарилах талаар судалгаа хийх шаардлагатай байгаа нь харагддаг. Тухайлбал, сургалтын төлөвлөгөөгөөр Иргэншил (одоо нийгмийн ухаан гэх болсон) хичээл нь заавал судлах хичээлийн тоонд ордог бол Иргэний боловсрол нь хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагт ордог байна.
- Иргэний боловсрол олгож буй хичээлийн цаг тогтвортой байж ирсэн залгамж холбоог хадгалсан боловч заавал судлах хичээл ба хичээлээс гадуурх цаг гэсэн хоёр хэлбэрт хувааж судлахаар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсантай холбоотой сүүлийн 3 жилд сургууль, багш нарт тулгарч байгаа бэрхшээлийг нэн даруй шийдэх шаардлагатай байна.
- Иргэншил, иргэний боловсрол хичээлүүд нь эрх зүй, ёс зүй, төсөлт хичээл зэрэг нэршлээр судлагдаж байсан хичээлүүдийн суурь дээр судлагдаж эхэлсэн агуулгын хувьд эдгээр хичээлтэй залгамж холбоотой боловч манай улсад харьцангуй шинэ хичээл тул түүний агуулгыг судалгаагаар тогтоох шаардлага гарч байна.

2.3. ҮНЭТ ЗҮЙЛ БА ХИЧЭЭЛ

Энэхүү судалгааны нэг хэсэг нь сургалтын хөтөлбөрт туссан агуулгыг хичээлээр хэрэгжүүлж буй явц буюу иргэний боловсролыг танхимын сургалтаар олгож буй байдал, түүнд нөлөөлж буй орчны хүчин зүйлсийг багтаан мониторинг хийж, цуглуулсан мэдээлэлд шинжилгээ хийх явдал байлаа. Бид сургалтын орчны хүрээнд дараах асуудалд анхаарч ажиллалаа:

- Хичээлийн орчин
- Сургуулийн соёл
- Багшийн мэргэжлийн бэлтгэл

Мониторингийг ерөнхий боловсролын 11 жилийн сургуулийн 9-р ангид сонголтын дагуу УБ хотын гурван дүүрэг, Дархан-Уул болон Архангайн аймгийн төвийн болон сумын тус бүр нэг сургуулийн нэг бүлгийг тохиолдлын аргаар сонгож авсан болно.

Ерөнхий боловсролын 11 жилийн сургуулийн 9-р анги нь суурь боловсролын түвшний төгсөх анги бөгөөд эрх зүйн боловсролын стандартад сурагч тухайн түвшний хувьд дараах зорилтыг хангасан байхаар тодорхойлсон байна.

Эрх зүйн суурь боловсролын «Салбар эрх зүй» айн зорилт нь суралцагчдад дараах цогц чадамжийг төлөвшүүлэхэд оршино:

- Тодорхой салбар эрх зүйн талаар үндсэн мэдлэг эзэмшиж, тэдгээрийн гол гол ухагдахууныг тайлбарлаж чаддаг болох;
- Тохиолдол, баримтаас үзэж судалсан эрх зүйгээр зохицуулах харилцааг ялгаж, шийдэх хувилбар, арга зам дэвшүүлж сурах;
- Тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх зүйн болон бусад мэдээллийг олж түүнийгээ хэрхэн ашиглах арга замыг тодорхойлж сурах;
- Хамт олонтойгоо болон харилцаанд оролцогч талуудын эрхийг хүндэтгэж, өөрийн эрх, үүргийг ухамсарлаж, хариуцлага хүлээдэг болох.

*Эх сурвалж: МУ-ын стандарт. Бага, дунд боловсрол.
Түүх, нийгмийн ухааны боловсрол. MNS 5420-14:2004.
Албан хэвлэл. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв. УБ хот.*

Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүнүүд

Мониторингийг дараах арга зүйд тулгуурлан хэрэгжүүллээ:

- Хичээлийн хронометраж
- Хичээлийн соёлын ажиглалт
- Сургуулийн соёлын ажиглалт
- Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага зэрэг болно.

Хүснэгт 12. Хичээлийн соёлын ажиглалт: Үндсэн мэдээлэл

Сургууль	Сурагчдын тоо	Багшийн ажилласан жил	Суудал зохион байгуулалт
УБ	24	12	3 эгнээ
	22		3 жижиг бүлгээр
	20		3 жижиг бүлгээр
	30		3 эгнээ
УБ	32	1	3 бүлгээр
	28	20	3 эгнээгээр
	30	3	5 жижиг бүлгээр
	33	2	6 жижиг бүлгээр
УБ	22	24	3 бүлгээр
	20		3 бүлгээр
Дархан-Уул	31	25	3 эгнээгээр
	27	-	3 эгнээгээр
	32	-	3 эгнээгээр
Дархан-Уул	11	8	3 эгнээгээр
	16	7	3 эгнээгээр
Аймгийн төвийн сургууль	42	16	3 эгнээгээр
	34	5	3 эгнээгээр
Сумын сургууль	30	26	3 эгнээгээр
	25	1	3 эгнээгээр

I. Нэгж хичээлд хийсэн шинжилгээ

Энэхүү шинжилгээг нэгж хичээл бүрт хамаатай “Хичээлийн соёлын ажиглалтын хуудас”, хронометражийн тэмдэглэл болон ангийн суудал зохион байгуулалтын дүрслэл зэргийг ашиглан гүйцэтгэсэн. Уг ажиглалтыг судалгааны багийн гишүүд хамтдаа ажил үүргийн хуваарь гарган тус тусын үзүүлэлтээр ажиглан судалсан болно.

Хэрэглэгдэхүүн 1: Хичээл ажиглах хронометражийн хуудас

Хичээлийн нэр:

Анги

Хүүхдийн тоо

Хичээл заасан багшийн тухай мэдээлэл:

Ажилласан жил

Мэргэшсэн чиглэл:

Төгссөн сургууль, он

№	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Хугацаа-заалт		Ямар үнэт зүйлсийг хөгжүүлсэн: тайлбар
			эхэлсэн	дууссан	

Судалгааны энэхүү хэрэглэгдэхүүнээр цуглуулсан мэдээллийг дараах байдлаар нэгтгэж дүгнэлт гаргасныг нэг аймгийн сургуулийн жишээн дээр танилцуулж байна.

Хүснэгт 13. Сурагчдын хичээлд оролцсон байдал – Дархан-Уул аймгийн сургууль

№	Анги	Сурагч			Үүнээс оролцсон			3-аас дээш	Оролцооны хэлбэр	Сурах бичиг
		нийт	эм	эр	эм	эр	хувь			
9д	27	12	15	8	2	10/37.0%	1	Багшийн тавьсан асуултад хариулах	4	
9г	32	18	14	7	7	14/43.7%	6	Багшийн тавьсан асуултад хариулах	2	
9б	31	17	14	4	6	10/23.2%	6	Багшийн асуултад хариулах Багшийн тавьсан асуултад багш, сурагч 2 зэрэгцэж хариулах	6	
9а ДАХ	13	6	7	4	3	7/53.8	3	Багшийн асуултад хариулах	2	
Нийт	103	53	50	23	18	41/39.8	13		14	

Хичээл дээрх сурагчийн оролцоог үнэлэхдээ дараах зүйлд анхаарлаа:

- Ам, бичиг болон бусад хэлбэрээр өөрийн болон бүлгийн санаа бодлыг бусдад танилцуулах;
- Хичээл дээр шийдэж буй асуудлаар шийдвэр гаргахад оролцож өөрийгөө илэрхийлэх;
- Асуултад хариулах, асуух (багшаас болон бусад хүүхдээс, бүлгээс), шаардлагатай зүйлсийг тухай бүрт тодруулах;

Орон нутгийн цогцолбор сургууль болон тухайн аймгийн нэг сумын сургуулийн хичээлийн ажиглалтын нэгтгэл:

Хүснэгт 14. Сурагчдын хичээлд оролцсон байдал – аймгийн төвийн сургууль

№	Анги	Сурагч			Үүнээс оролцсон				Оролцооны хэлбэр	Сурах бичиг
		нийт	эм	эр	эм	эр	хувь	3-аас дээш		
96		42	24	18	6	8	14\42	7	Багшийн тавьсан асуултад хариулах	6
9а		34	16	18	10	12	22\34	5	Ангийг 3 жижиг бүлэгт хуваасан, бүлгээр ажиллах, дасгалаа хамтран хийх, жүжигчилсэн тоглолтоор асуудал дэвшүүлэх Багшийн тавьсан асуултад хариулах	9
9в ИТ		30	15	15	7	4	11\30	6	Багшийн асуултад хариулах Багшийн тавьсан асуултад багш, сурагч 2 зэрэгцэж хариулах	18
9в ИТ		25	14	11	4	3	7\25	3	Бататгал хичээл байсан бөгөөд багш эхний 20 минутад сурагчидтай ажиллаад, сүүлийн хагаст хичээлийн дэвтэр үзэх үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд энэ үед дэвтрээ үзүүлсэн сурагчид ангиас гарч явсан болно. Багшийн асуултад бүлгээр нэгэн зэрэг хариулах	0
Нийт		131	69	62	27	27	54\131	21		33

Дархан-Уул аймагт хийсэн хичээлийн хронометражийн мэдээллийг нэгтгэж үзэхэд дараах дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 15. Багш 1

Сэдэв: Хүмүүнлэгийн эрх зүйн тухай ойлголт

№	Сурагчийн хийсэн үйлдэл, үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Агуулга			Тэмдэглэл
			мэдлэг	чадвар	үнэт зүйл	
	Сонсох	19	- Гэрээний тухай ойлголт	- Тухайн асуултад өөрийн бодлоор хариулт хэлэх	- Оролцохыг эрмэлзэх	- Багшийн тавьсан асуултаас: - Гэрээ, хэлцэл, ХЭЗ гэж юу вэ? - Манай аймагт хүний эрхийг хамгаалдаг ямар байгууллагууд байдаг вэ? - Бид яагаад дайнд шархдсан хүмүүст туслах ёстой вэ?
	Тэмдэглэх	5	- Хүмүүнлэгийн эрх зүй үүссэн түүх		- Тэгш хандах, бусдыг хүлээн зөвшөөрөх талаар эргэцүүлэл бий болгох	
	Багшийн тавьсан асуултад хариулах, мөн өөрийн санаа бодлыг багшид хэлэх	18				

Хүснэгт 16. Багш 2

Сэдэв: Хөдөлмөрийн гэрээ хэзээ, хэрхэн дуусдаг вэ?

№	Сурагчийн хийсэн үйлдэл, үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Агуулга			Тэмдэглэл
			мэдлэг	чадвар	үнэт зүйл	
	Асуултад хариулах	28/	- Хөдөлмөрийн гэрээ	- Тухайн асуултад хариулт хэлэх	- Оролцохыг эрмэлзэх	- Багшийн тавьсан асуултаас: - Хөдөлмөрийн гэрээ гэж юу вэ? - Зун ямар ажил хийдэг вэ? - Хөдөлмөрийн гэрээний ямар төрөл байдаг вэ? - Гэрээнд өөр юу тусгагдах вэ? - Гэрээ хэзээ дуусах вэ? - Ямар хууль байдаг вэ?
	Унших	7				
	Бичих, тэмдэглэх	1				

Хүснэгт 17. Багш 3

Сэдэв: Эрүүл мэндийн даатгал

№	Сурагчийн хийсэн үйлдэл, үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Агуулга			Тэмдэглэл
			мэдлэг	чадвар	үнэт зүйл	
	Сонсох	6	- Нийгмийн даатгал			
	Уншаад, хуулж бичих	13	- Нийгмийн халамж			
	Хэлэх, нэрлэх	3				
		22				

Ажиглалтаас үзэхэд сурагчдын оролцооны хэлбэр идэвхгүй, хязгаарлагдмал, зөвхөн багшийн санаачилгаар, түүний тавьсан асуултад хариулах байдлаар оролцож байгаа нь харагдаж байна. Багшийн тавьж буй асуултын ихэнх нь хаалттай, нэрлэсэн, агуулгын шинжтэй асуултауд байгаа нь дээрх хүснэгтийн “Тэмдэглэл” хэсгээс харагдаж байна. Гэтэл сурагчдад үнэт зүйлсийг төлөвшүүлэх, иргэний чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт нь нээлттэй, сурагчийн хөгжлийг дэмжсэн, үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангасан, ялгаатай үзэл бодлыг харьцуулан өөрийн үндэслэл нотолгоог дэвшүүлэхэд чиглэсэн асуултыг шаарддаг билээ.

Мөн хичээлийн явцад багшийн зүгээс сурагчдын оролцоог дэмжих, тэдэнд оролцох боломж олгох, оролцоог зохион байгуулах, жигд оролцоо, тэгш боломжийг хангах зэрэг хичээлийн менежментийн арга дутагдалтай байгаа нь бидний ажиглалт хийсэн дээрх гурван хичээлийн үед унших, тэмдэглэх (бичих), зөвхөн багшийн тавьсан асуултад хариулах зэрэг үйл ажиллагаа давамгайлж байгаагаас харж болно. Багшийн тавьсан асуултад хариулт хэлэх байдлаар оролцсон нийт 10 сурагчийн хоёр нь 11 удаа, дөрөв нь 4-7 удаа оролцсон байгааг үзэхэд зөвхөн идэвхтэй сурагчдыг татан оролцуулж, бусад нь орхигдож байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 18. Сурагчдын хийсэн үйл ажиллагаа ба хугацааг нэгтгэж харвал

№	Сурагчийн хийсэн үйлдэл, үйл ажиллагаа	Багш 1	Багш 2	Багш 3	Нийт
	Сонсох	19		6	25
	Тэмдэглэх, бичих, хуулж бичих	5	1	13	19
	Асуултад хариулах (хэлэх, нэрлэх)	18	28	3	49
	Унших		7		7
	Нийт	42	36	22	100 мин

График 1. Хичээлийн үеэр сурагчдын хийсэн үйл ажиллагаа





График 2: Хичээлийн үеэр сурагчдын хийсэн үйл ажиллагааны хуваарилалт




Хичээлийн үеэр сурагчдын хийсэн үйл ажиллагааны нийт хугацаанд сонсох буюу багш ярих, асуултад хариулах буюу багшийн тавьсан асуултад нэр үг, холбоо үгээр хариулах байдал хамгийн их хувийг эзэлж байгаа нь дээрх дүгнэлтүүдийг баталж байгаа хэрэг болно.

Хэрэглэгдэхүүн 2: Ангийн суудал зохион байгуулалтын хүснэгтийн загвар

Энэ нь тухайн хичээлээр тухайн анги ямар бүлэг, зохион байгуулалтаар хичээллэж байгаагаас хамаарч 3 эгнээ бүхий уламжлалт, “П” хэлбэрийн, хагас тойрог зэрэг суудал зохион байгуулалтын хүснэгтийг зурж, ажиглалтанд ашигласан болно. Уг хүснэгтэд үндэслэн хичээлийн

явц дахь багшийн хөдөлгөөн, чиглэл, сурагчидтай харилцаж буй байдал, мөн сурагчдын хоорондын харилцаа, хичээлд оролцох идэвх, анхаарал зэрэг хүчин зүйлсийг тодорхойлоход ашигласан болно.


Зураг 6. Ангийн суудал зохион байгуулалт (уламжлалт хэлбэр)



Энэхүү зургаас харахад үзэхэд багш нарын зүгээс суудал зохион байгуулалт ихэвчлэн уламжлалт хэлбэрээр буюу 3 эгнээ цуварсан хэлбэрээр ангийг зохион байгуулдаг хэвээр байна. Энэ нь хоёр талтай. Нэгдүгээрт ангид байх сандал, ширээнүүд нь ихэвчлэн овор хэмжээ том, байнга хөдөлгөөнтэй, шилжин суух боломж олгодоггүй тул уг хэвээр нь сургалтыг зохион байгуулдаг. Нөгөө талаас, багш нар тухайн хичээлийг сайтар төлөвлөж, бэлтгэлээ хангаж хэвшээгүйгээс бусад хэлбэрийн суудал зохион байгуулалтыг төдийлэн ашигладаггүй байна. Хичээлд нь сууж ажиглалт хийсэн багш нарын заасан хичээлийн 14 орчим хувьд нь тухайн ангийг бүлгүүдэд хуваан, өөр зохион байгуулалтад оруулсан байна. Үүнд дараах хэлбэрийн суудал зохион байгуулалтыг багш нар ашиглаж байсан болно.

Хоёрдугаарт, Зураг 7-д харуулсантай адил жижиг бүлгээр ажиллах загварыг сонгож байсан. Энэ нь манай сургуулиудын анги бүрд нийтлэг тохиолдох 3 эгнээ бүхий жижиг ширээ, сандлыг богино хугацаанд өөрчлөх боломжтой тул үүнд тулгуурлан ангиа зохион байгуулж байв.


Зураг 7. Ангийн суудал зохион байгуулалт (жижиг бүлгээр)




Том бүлгээр болон тойргоор ангийн суудлыг зохион байгуулах хэлбэр эдгээр ажиглалтын үед тус бүр нэг удаа тохиолдсоныг хэлэх нь зүйтэй. Ер нь эдгээр хэлбэрээр ширээг байрлуулах нь сурагчид өөрсдөө зөөж чадах ширээ, сандалтай газар л боломжтой. Суудлыг ийнхүү өөрчлөн зохион байгуулах нь хичээлийн үйл явцыг илүү сонирхолтой, өрсөлдөөнтэй, хөгжилтэй арга хэлбэрт оруулах боломж олгож байна. Тухайлбал, олонх тохиолдолд багш нар сурагчдыг жижиг бүлгүүдэд хуваан, хооронд нь өрсөлдүүлэх, өөр олон төрлийн даалгавар, дасгал ажиллуулах, багууд бие биеэ сонсох, асуулт тавих, нэр томъёоны тайлбар өгөх зэргээр бүлэг хоорондын ажил үүргийн хуваарилалт хийх боломж гарч байлаа.

Мөн суудал хуваарилалтын эдгээр хувилбар нь хичээлийн явцад зарим хүүхэд оролцохгүй үлдэх, бусдадаа саад болох, анги танхимын уур амьсгалыг эвдэх зэргээс сэргийлэх боломж олгодог ажээ.

Зураг 8. Ангийн суудал зохион байгуулалтын хэлбэр (том бүлгээр)



Зураг 9. Ангийн суудал зохион байгуулалтын хэлбэр (тойргоор)



Учир нь уламжлалт 3 эгнээ бүхий суудлын хуваарилалтын үед багш нар болон ар талын бүсэд суусан суралцагчдын хооронд идэвхтэй харилцаа үүсэхгүй байх явдал түгээмэл гарч байгаа нь бидний ажиглагдсан хамгийн чухал зүйл байв. Өөрөөр хэлбэл, олонх багш нарын хувьд зөвхөн танхимын урд хэсэгт сууж буй сурагчидтай илүү их харилцаа үүсгэж, араар суусан сурагчид хичээлийн үйл явцаас ихээхэн хөндийрэн, хоцорч байв. Багш нарын хувьд хичээл заах явцдаа ангийн арын суудлын хэсгээр явж, эргэх холбоо хангаж хэвшээгүй тул тэдгээр сурагчдыг хичээлд татан оролцуулах, бусадтайгаа хамтран ажиллуулахад тавих анхаарал дутагдаж, ангид идэвхтэй, идэвхгүй гэсэн бүлэг үүсэн, танхимын уур амьсгал хуваагдмал шинжтэй болж байлаа. Арын эгнээгээнд суусан сурагчид чанга ярих, бүсдыг үймүүлэх зэргээр анхаарлыг өөр дээрээ татахыг оролдох, эсвэл эсрэгээр багшийн үл хайхрах байдалд дасан зохицсон шинжтэй байлаа.

Хэрэглэгдэхүүн 3:

ХИЧЭЭЛ АЖИГЛАЛТЫН ХУУДАС (Иргэний боловсрол)

Багшийн нэр: _____ Хичээл: _____
Байрлал: _____ Сурагчдын тоо, ирц: _____
Ажиглагч: _____ Огноо: _____

Зааварчилгаа:

Энэхүү ажиглалтын хуудсыг нэгж хичээлийн агуулга, арга зүй, зохион байгуулалтын хүрээнд суралцагчдад төлөвшиж буй иргэний боловсролын үнэт зүйлсийг тодорхойлох зорилгоор ашиглана. Үүний тулд доор тодорхойлсон 6 үнэт зүйлс тус бүрд 5 нөхцөл дэвшүүлж, тус бүрийг нь 1-4 хүртэлх тоогоор үнэлж харгалзах утгын өмнөх зайд бөглөж тэмдэглэнэ.

Өгөгдсөн нөхцлөөс гадна анхаарах, цаашид тодруулах шаардлагатай зүйлс, тохиолдлыг Тэмдэглэл хэсэгт бөглөнө.

Маш сайн	Хангалттай	Сайжруулах шаардлагатай	Хангалтгүй	Тодорхой бус
4	3	2	1	Т/Б

Ардчилсан уур амьсгал бүрдүүлэх:

- ___ 1. Хичээлийн зорилго, зорилгоо суралцагчдад танилцуулж саналыг нь авсан.
- ___ 2. Хичээлийг зохион байгуулах арга хэлбэр, бүтцийн талаар суралцагчидтай хэлэлцсэн.
- ___ 3. Сургалтын үйл явц бүхэлдээ найрсаг, харилцан ойлголцсон, хамтрах, дэмжлэг бүхий уур амьсгалд өрнөсөн.
- ___ 4. Сургалтын явцад суралцагчид асуудал дэвшүүлэх, дүрэм журам тодорхойлох зэрэг боломжууд нээлттэй хэвээр байсан.
- ___ 5. Хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг төгсгөлд нь суралцагчдын хамт дүгнэн хэлэлцсэн.

Тэмдэглэл:

.....
.....

Оролцоог хангах:

- ___ 1. Хичээлээр хэлэлцэх асуудлуудын талаар суралцагчидтай ярилцаж зөвшилцсөн.
- ___ 2. Хичээлийн үйл явц бүхэлдээ оролцоог хангахад чиглэж байсан.
- ___ 3. Ямар нэгэн бүлэг болон зарим сурагчид илүү давамгай оролцож, бусдынхаа оролцоог хааж буй байдлыг шийдвэрлэж, тэгш бололцоог хангасан.
- ___ 4. Хичээлд сонирхолгүй болон оролцохгүй байгаа хүүхдийг урамшуулж, оролцуулах талаар идэвхжүүлж, дэмжсэн.
- ___ 5. Нийгмийн амьдралд оролцох нь тухайн асуудлыг зохистойгоор шийдвэрлэхэд болон хувь хүний хөгжилд чухал ач холбогдолтой болохыг таниулсан.

Тэмдэглэл:

.....
.....

Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах:

- ___ 1. Суралцагчдын асуулт, шүүмжлэлд хүндэтгэлтэй хандаж, эерэг байдлаар хүлээн авсан.
- ___ 2. Танхимд нээлттэй, илэн далангүй харилцаа үүсгэж, зохион байгуулсан.
- ___ 3. Олонхитой санал нийлэхгүй болон эсэргүүцэж буй бүлгийн үзэл бодлыг сонсох боломж олгосон.
- ___ 4. Өрсөлдөж буй санал, байр суурийг багшийн зүгээс шууд таслан зогсоож шийдвэрлэхээс түдгэлзэж, хэлэлцэх боломж олгосон.
- ___ 5. Нийгэмд олон янзын ялгаа бүхий үзэл бодол, байр суурь оршдог бөгөөд олон ургальч үзэл орших нь чухал болохыг тайлбарлан таниулсан.

Тэмдэглэл:

.....
.....

Мэдээллийн нээлттэй байдал, олон талт эх сурвалж:

- ___ 1. Багш хичээлдээ олон төрлийн эх сурвалжаас мэдээлэл авч хэрэглэсэн.
- ___ 2. Хичээлдээ ашиглаж буй нэмэлт материалуудын эх сурвалжуудыг суралцагчдад мэдээлсэн.
- ___ 3. Суралцагчид өөр бусад эх сурвалжуудаас мэдээлэл авч, тэдгээрийг сургалтандаа ашиглах, хэлэлцүүлэхийг дэмжсэн.
- ___ 4. ТВ, сонин, интернет болон радио зэргээс нэмэлт мэдээллээр баяжуулж ашигласан.
- ___ 5. Аливаа мэдээлэлд анхааралтай, нягт хандаж үнэн зөвийг нягтлан шалгасаны үндсэн дээр сургалт болон өөрийн амьдралдаа ашиглахын чухлыг таниулсан.

Тэмдэглэл:

.....
.....

Хариуцлагатай хандах:

- ___ 1. Эрх ба үүрэг, хариуцлагын харилцан хамаарлын талаар ойлголт, хандлагыг сурагчдад тайлбарлан таниулсан.
- ___ 2. Сурагчид, сургуулийн удирдлага, багш, эцэг эх, албан тушаалтнууд зэрэг бүх хүний эрхэд хүндэтгэлтэй хандах үүргийг хүлээдэг болохыг ойлгуулахад чиглэсэн.
- ___ 3. Өөрөө эрхээ эдлэхийн хамт бусдын эрхийн өмнө үүрэг хариуцлага хүлээх байдлыг сургалтын үйл явцад харуулсан.
- ___ 4. Үүргээ биелүүлэхгүй байх нь ёс суртахууны болон эрх зүйн хариуцлага хүлээх үндэс болохыг сургалтын явцад таниулсан.
- ___ 5. Сургалтын явцад үүргээ биелүүлээгүй сурагчдад оногдуулж буй хариуцлага нь шударга ёс болон хүний эрхийн зарчимд нийцсэн.

Тэмдэглэл:

.....
.....

Эдгээр хэрэглэгдэхүүнийг ашиглан нэгж хичээл бүрийг эхлэлээс төгсгөл хүртэл дэлгэрэнгүй ажиглалт хийж, багш сурагчдын хооронд буюу ангид болж буй бүх үйл ажиллагааны явц дахь харилцааг анхааран тэмдэглэж авсан бөгөөд энэ нь бидэнд тухайн хичээлийн соёлыг тодорхойлох боломжийг олгосон юм. Өөрөөр хэлбэл, бид анги танхимд ардчилсан уур амьсгал бүрдүүлэх замаар сурагчдын үнэт зүйлсийн төлөвшлийг болон иргэний чадвараа хөгжүүлэхийг дэмжиж чадаж буй эсэхийг илрүүлэхийг зорьсон болно.

Үүний тулд үзүүлэлт бүрээр цуглуулсан онооны дунджийг гаргах замаар багш аль үнэт зүйлийн төлөвшлийг дэмжиж чадаж байгааг илрүүлсэн болно.

Хүснэгт 19. Багшийн дэмжиж буй үнэт зүйлсийн үзүүлэлт

Үнэт зүйл	Багш 1	Багш 2	Багш 3	Дундаж
Ардчилсан уур амьсгал бүрдүүлэх	2.5	1.8	1.4	1.9
Сурагчдын оролцоог хангах	2.8	1.8	1.6	2.1
Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах	1.0	2.3	1.6	1.6
Мэдээллийн нээлттэй байдал, эх сурвалж	2.2	1.0	2.0	1.7
Хариуцлагатай хандах	3.1	2.7	1.0	2.3
Тэгш байдлыг хангах, үл алагчлах	1.5	1.0	1.0	1.2

График 3. Багшийн дэмжиж буй үнэт зүйлсийн үзүүлэлт, багшаар





График 4: Багшийн дэмжиж буй үнэт зүйлсийн үзүүлэлт, үйл ажиллагаагаар



Ажиглалтын тэмдэглэлийг тоон өгөгдөлд оруулж үзэхэд багш нар цуглуулах ёстой онооныхоо маш цөөн хувийг цуглуулсан байна. Энэ нь бидэнд хичээлийн зохион байгуулалт, хичээлийн үеэр багш-сурагч, сурагч-багш, сурагч-сурагч зэрэг олон талт харилцаагаар дамжуулан сурагчдад үнэт зүйлсийн баримжаалал, иргэний чадваруудыг төлөвшүүлэх байдал тун хангалтгүй байгааг харуулж байна.

Тоон өгөгдлийг боловсруулсан байдлаас үзэхэд багш нар сурагчдыг хариуцлага хүлээдэг болгох /2.3/, сурагчдын оролцоог хангах /2.1/, хичээлийн зорилт болон хүрсэн үр дүнг хамтран хэлэлцэхэд /1.9/ анхаарч байгаа нь харагдаж байна. Гэвч хариуцлага хүлээх талаар сурагчид үйл ажиллагааны явцад ойлгож авахаасаа илүү багшийн хэлсэн анхааруулга, сануулга, зэмлэлийг сонсох замаар ойлгож, хичээлд оролцох оролцоо нь зөвхөн багшийн тавьсан хаалттай голдуу асуултад хариулахаар л хязгаарлагдаж байгаа нь анхаарал татаж байна.

“Иргэншил” хичээлийн зорилго нь суралцагчдад харилцааны болон ёс зүй, эрх зүй, хүний эрхийн зохих мэдлэг эзэмшүүлж, өөрийн эрхээ хэрэгжүүлж, зөрчигдсөн эрхээ хамгаалах чадвар суулгаж, хүний эрхийг хүндэтгэдэг, үүрэг, хариуцлага хүлээдэг, ялгаатай соёлыг хүндэтгэдэг цогц чадамжтай болоход нь туслах, дэмжлэг үзүүлэх, орчныг бүрдүүлэхэд чиглэх ёстой болохыг Түүх, нийгмийн ухааны боловсролын стандартад хийсэн шинжилгээ харуулж байна. Тиймээс бид ажиглалт хийхээр 9 дүгээр анги буюу суурь боловсролын түвшний төгсөх ангийг сонгосон болно.

Хичээлд хийсэн ажиглалтын дүнд дараах дүгнэлтийг хийлээ:

- Хичээл багшийн удирдлага дор явагдах нь гарцаагүй боловч үйл ажиллагаагаа төлөвлөхдөө зөвхөн нэг талын буюу багшаас сурагчид руу чиглэсэн урсгалтай байхаар зохион байгуулж байгаа нь хичээл дээр сурагчид багштай болон өөр хорондоо харилцах замаар харилцааны болон оролцооны, цаашлаад асуудал шийдвэрлэх, харилцан буулт хийх, хүлээцтэй байх, багаар ажиллах, багийн гишүүн байх, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, үзэл бодлоо илэрхийлэх, хариуцлага хүлээх, дүрэм журмаа мөрдөх зэрэг хүний эрх, ардчилал, эрх зүйт ёсны үнэт зүйлсийг эзэмшихэд нь дэмжлэг болж чадахгүй байна.
- Багш нар сурагчдыг хичээлд татан оролцуулахын тулд бүлгээр ажиллуулах, харилцан асуулт тавьж хариулт авах, хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг аргуудыг ашиглахыг хичээж байна. Гэвч багшид үүнийг хэрхэн үр дүнтэй, сурагчдын үнэт зүйлсийн баримжаалалд нөлөөлөхүйцээр зохион байгуулах талаар туршлага, арга зүйн дэмжлэг шаардлагатай байна. Мөн хичээлийн агуулгаас үзэхэд иргэншлийн хичээл нь нийгмийн ухааны чиглэлийн томоохон судлагдахууны агуулгыг багтааж буй тул багшид мэргэжлийн мэдлэг дутагдалтай байгаа нь харагдлаа. Тухайлбал, бидний ажиглалт хийсэн хичээлийн сэдвүүд ихэнх нь салбар эрх зүйн сэдвүүд байсан бөгөөд энэ чиглэлээр багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх талаар цаашид анхаарал хандуулах шаардлагатай байна.
- Багш нар сурагчдыг хичээлд оролцохыг уриалах, асуултад хариулахыг хүсэх, сурагчдын хамтын ажиллагааг зохион байгуулахыг оролдохдоо ихэвчлэн сурах бичгээс авсан болон өөрийн өгсөн мэдээллийг сэргээн давтахыг шаардсан нэрлэсэн асуултад хариулт хүсэж байгаа нь тэдний үнэт зүйлсийн баримжаалал, иргэний чадварын хөгжилд анхаарахгүй байна гэдэг дүгнэлт хийхэд хүргэж байна. Багшийн зүгээс тухайн сэдэв, агуулгын хүрээнд гол анхаарлаа хандуулдаг бөгөөд үүний хамт нийгэм дэх ялгаатай байдал, олон ургальч үзэл, мэдээллийн олон эх сурвалж, үүрэг хариуцлага хүлээх зэрэг сурагчдад төлөвших иргэний чанар, үнэт зүйлс болон харилцаа хандлага зэрэгт төдийлэн анхаардаггүй байна.

- Багш нарын зүгээс хичээлийн зорилго, зорилгоо танилцуулах, хичээлийг зохион байгуулах арга хэлбэр, бүтцийн талаар суралцагчидтай хэлэлцэж санал авах болон төгсгөлд нь тухайн хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг дүгнэн хэлэлцэж байгаа явдал бараг тохиолдоогүй бөгөөд нийтлэгээр хэвшээгүй байна.
- Хичээлийн явцад илүү давамгай оролцож буй бүлэг, сурагчидтай илүү тулж ажиллах, харилцах хандлагатай бөгөөд хичээлд сонирхолгүй, эсхүл оролцохгүй байгаа хүүхдийн идэвхийг сэргээх, урамшуулах бус харин шаардлага тавих, анхааруулахыг илүүд үздэг байна.
- Сургалтын үр дүнд чухал нөлөөтэй хүчин зүйл болох сурах бичгийн хүрэлцээ хангамж туйлын хангалтгүй байна.

“Иргэншил” хичээлийн соёл нь бүхэлдээ олон талт харилцаа, оролцоог эрхэмлэдэг гэхээсээ илүү багшийн амыг харсан нэг талын харилцаа зонхилсон цөөнхийн оролцоо давамгайлсан байдлаар явагддаг байна.

II. Сургуулийн орчинд хийсэн шинжилгээ

Энэхүү шинжилгээг доорх “Сургууль ажиглалтын хуудас”-ыг ашиглан гүйцэтгэсэн бөгөөд судалгааны багийн гишүүд доорх хүснэгт дэх асуултуудын дагуу тухайн сургуулийн орчинд ажиглалт хийн мэдээллийг тэмдэглэж байлаа.

Хэрэглэгдэхүүн 1:

СУРГУУЛЬ АЖИГЛАЛТЫН ХУУДАС

Сургуулийн нэр: _____ Харьяалал: _____
Байрлал: _____ Суралцагчдын тоо: _____
Ажиглагч: _____ Огноо: _____

Ажиглалтаар тодорхойлох орчин	Тийм ; + Үгүй; --	Тайлбар
1. Сургуулийн дүрэм журмыг сурагчдын өмнө, ил тод байрлуулсан эсэх:		
2. Захирал, сургалтын менежерүүд сурагчидтай уулзах цагийн хуваарь байгаа эсэх:		
3. Сургуулийн дотоод дахь мэдээллийн бие даасан суваг, хэвлэл байгаа эсэх (радио узель, сонин, е-мэйлийн сүлжээ г.м):		
4. Сургуулийн дотор мэдээллийн самбарууд байгаа эсэх (тоо, хүртээмж):		
5. Мэдээллийн самбарын агуулга:		
6. Ангийн буланд Сурагчдын дүрэм журам, хэрэгцээт мэдээллүүд байгаа эсэх:		
7. Сурагчдын зөвлөл, ХӨУБ-уудад зориулсан анги, танхим, өрөө байгаа эсэх:		
8. Сурагчдын зөвлөл, ХӨУБ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, үйл ажиллагаа байгаа эсэх:		
6. “Иргэншил, Иргэний боловсрол” хичээлд зориулсан дагнасан анги, кабинет байгаа эсэх:		
10. Сурагчид, багш нар өөр хоорондоо мэндэлдэг эсэх:		
11. Багш, ажилтнуудын зүгээс сурагчдад хүндэтгэлтэй хандаж буй эсэх:		
12. Бие засах газрын орчин (хүртээмж, цэвэр байдал):		
13. Бусад:		

Юуны өмнө судалгаанд хамрагдсан сургуулиудын дүрэм журам, сургуулийн хүрээн дэх эрх зүйн зохицуулалтуудтай танилцах хүсэлт гаргасны дагуу сургууль бүрээс “Сургуулийн дүрэм”, “Сургуулийн үйл ажиллагааны дотоод журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Суралцагчийн дүрэм”, “Анги дэвших ба төгсөх шалгалтыг зохион байгуулах журам” зэрэг материалыг авч шинжиллээ. Эдгээр дүрэм, журамд сургуулийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон багш, ажилчдын хөдөлмөрийн гэрээ, түүний зохицуулалт, нийгмийн баталгаа зэрэг асуудлууд голчлон тусгагдсан байлаа.

Эдгээр дүрэм журамд зааснаар, сургуулийн үйл ажиллагааг Монгол Улсын “Үндсэн хууль”, “Боловсролын тухай”, “Бага, дунд боловсролын тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Төрийн албаны тухай” болон бусад хууль тогтоомж болон сургуулийн дотоод дүрэм, журмаар зохицуулдаг байна. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн дотоод журам, хамтын болон хөдөлмөрийн гэрээний заалтууд, ажлын байрны тодорхойлолт, захирлын тушаал зэргийг хэрэгжүүлж ажилладаг байна.

Хэдийгээр эдгээр баримт бичиг нь сургуулийн нийтлэг үйл ажиллагааг зохицуулах чиглэсэн, тогтсон нийтлэг жишгээр боловсруулагдсан боловч дүн шинжилгээ хийх явцад тэдгээрийн өвөрмөц тал, онцлогууд илэрч байна. Тухайлбал, Жигүүр цогцолбор сургууль, БЗД-ийн 88 дугаар сургуулийн хөдөлмөрийн дотоод журам нь маш нарийвчлалтай, ажилтан бүрийн ажлын байрны онцлогт тохируулан тэдгээрийн эрх, үүргийг нарийвчлан зааж өгсөн байна. Үүнд сургуулийн захирал, сургалтын менежерээс эхлэн нийгмийн ажилтан, багш (анги удирдсан, кабинет хариуцсан, жижүүр), нягтлан бодогч, нярав, эмч, номын санч, жижүүр ба үйлчилгээний ажилчин, цахилгаанч, сантехникч болон хувцас харагч зэрэг бүх ажилтны эрх үүргийг тодорхойлж өгсөн байна. Зарим ажлын байрны онцлогийг харгалзан сурагчидтай зөв боловсон харьцах, хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх, хүүхдийн оролцоо, сонирхлын бүлгүүдийг дэмжих зэрэг шаардлагыг тун зохистой байдлаар багтааж өгсөн байлаа.

Мөн нийслэлийн БГД-ийн 13 дугаар сургуулийн дотоод журамд багш нарын ажил үүргийн хуваарь, зорилго, чиглэлийг тодорхойлон гаргасан байв. Тиймээс багшийн ажлыг дүгнэх үзүүлэлтүүдэд дараах зүйлсийг багтаажээ:

- А. Үндсэн бүтээгдэхүүн буюу заадаг хичээлийн сурлагын амжилт,
- Б. Захиалгат бүтээгдэхүүн буюу сургалтын орчин бүрдүүлэлт, тохижуулалт, багшийн харилцааны соёл, анги, хамт олны төлөвшил,

багшийн өөрийн үлгэр дууриал, хүүхдийн оролцооны эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зэргээр нарийвчлан тодорхойлж, тус бүрд өгөх оноо, тэдгээрийн багшийн нийт үнэлгээнд эзлэх хувь хэмжээ зэрэг болно.

Мөн тус сургуулийн дотоод журмын 9 дүгээр бүлэг нь “Суралцагсдын оролцоог нэмэгдүүлэх, эрх ашгийг хамгаалах” гэсэн бие даасан бүлэг байна. Үүнд, тухайлбал:

- 9.1 Сургууль дээр аливаа үйл ажиллагааг зохион байгуулахдаа сурагчид, сурагчдын байгууллагын санал, санаачлагыг дэмжин, анхааралтай авч үзэх;
- 9.2 Хүүхдийн эрүүл мэнд, ёс суртахууны хүмүүжилд тэргүүн зэргийн ач холбогдол өгч ажиллах;
- 9.3 Суралцагчдад харилцааны соёл эзэмшүүлж, “Эелдэг харилцаа - Дотно инээмсэглэл” уриан доор багш, суралцагчид, ажилчдын хоорондын харилцаа зохион байгуулагдах;
- 9.5 Сургуулийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхөд сурагчид, эцэг эхийн оролцоог харгалзан үзэж байх;
- 11.2 Сургалт, хүмүүжлийн ажилд эцэг эхчүүдийн үүрэг оролцоог сайжруулах, тэдний сурган хүмүүжүүлэх мэдлэгийг дээшлүүлэхэд бүх талын арга хэмжээ авч ажиллах зэрэг заалт багтсан байна.

Үүнээс гадна тус сургууль нь “Хүүхдэд ээлтэй сургууль”-ийн загвар болохоор НҮБ-ын Хүүхдийн Сан, БСШУЯ-ны төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллаж байгаа тул тус сургуулийн үйл ажиллагааны үндсэн удирдамжийн нэг нь “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх талаар баримтлах бодлого” юм. Энэхүү төслийн хэрэгжилт, түүнд хийгдсэн үнэлгээний талаар дараагийн хэсэгт илүү дэлгэрэнгүй авч үзнэ.

Эдгээр заалтаас харахад манай сургуулиуд өөрсдийн дотоод дүрэм журам, баримт бичгүүддээ боловсролын харилцааг илүү ардчилсан, оролцоот болгох зорилтуудыг тусган баталгаажуулсан байна. Харин эдгээрийг сургуулийн өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэх, сургуулийн соёлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг болгон хэвшүүлэх нь илүү их хүчин чармайлт, хамтын ажиллагаа шаардсан ажил болно. Энэ нь сургуулийн нийт хамт олон, ялангуяа багш нарын хичээл зүтгэл, хүсэл эрмэлзлэлээс ихээхэн шалтгаалдаг болох нь бидний хийсэн хичээлийн соёлын ажиглалт, түүнд хийгдсэн анализын үр дүнгээс харагдаж байна.

Мөн бидний зүгээс суралцагчид хичээлээр сурсан зүйлсээ хэрэглээ болгох, ардчилсан соёлыг сургуулийн дотор бүрдүүлж чадсан эсэхийг

аливаа хуваарь, мэдээллийн самбар зэргээр суралцагчдын шууд мэдээлэл авах боломжийг хангаж, мэдээллээр үйлчилж чадаж буй байдал, хүмүүс хоорондын харилцааны байдлаар илрүүлэх боломжтой гэж үзсэн болно.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд үүдний танхим, хонгил, ангиудад сурагчдад зориулсан мэдээллийн самбаруудыг байрлуулсан байна. Ялангуяа үүд болон гол хонгилоор байрлах нэгдсэн мэдээллийн самбаруудад Боловсролын тухай хууль, Суралцагчдын эрх үүрэг болон сурагчдын дүрэм зэргийг суралцагчдад ил тодоор байрлуулсан байна. Мөн үүний хамт тэмцээн уралдаан, амжилт гаргасан сурагчдын талархал болон хичээл шалгалтын хуваарь, спорт, эрүүл мэндийн мэдээлэл зөвлөлгөөнүүд зонхилж байна. Гэхдээ эдгээр мэдээллийн самбарууд нь байнга солигдох шийдэлтэй боловч самбаруудын агуулга нь олонх тохиолдолд шинэчлэгддэггүй байна.

Мөн анги бүр Ангийн булан хэмээх самбартай, үүнд ихэвчлэн сурагчдын дүрэм, ангийн ирц болон цэвэрлэгээ хийх нэрсийн дараалал зэрэг мэдээллүүд багтсан байна. Улмаар ямар хичээлийн кабинет болгон тохижуулснаас хамаарч анги бүрт үзүүлэн самбар болон мэдээллийн буланг тухайн хичээл, судлагдахууны үндсэн ойлголт, агуулга болон танин мэдэхүйн мэдээллээр дүүргэсэн байдаг.

Судалгаанд хамрагдсан сургуулиудад сонин, радио уэль зэрэг сургуулийн дотоод дахь мэдээллийн тусгай суваг байхгүй байна. Харин БГД-ийн 13, Архангай аймгийн Хүмүүн-III цогцолбор сургуулиуд нь НҮБ-ын Хүүхдийн Сан, МБХАН-ийн хамтран хэрэгжүүлж буй “Сурагчийн хэвлэл” төсөлд хамрагдаж, сурагчид өөрсдийн сонины 1-2 дугаарыг гаргаж эхэлж байв. Мөн Дарханы Жигүүр ЦС вэбсайттай болохоор төлөвлөж байгаа ажээ.

Мөн сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн зүгээс сурагчидтай уулзах тодорхой цагийн хуваарь боловсруулж, сурагчдын өмнө ил тодоор байрлуулсан сургууль одоогоор байхгүй байна. Гэхдээ олонх сургуулийн удирдлага, төлөөлөгчид нь сурагчидтай уулзахад ямар нэгэн хориг саад байхгүй, уулзах тохиолдолд хүсэлт гарган уулзаж болно гэж мэдээлдэг.

Аливаа сургууль ардчилсан, хүүхдэд ээлтэй байхын нэг гол шинж бол тухайн сургууль дахь хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд идэвхитэй, ил тод, тогтвортой ажиллах явдал юм. Одоогоор сургуулиудын ХӨУБ-ын хамгийн гол загвар болох Сурагчдын зөвлөл нь дээрх сургуулиудад бүгд ажиллаж байгаа боловч, сургуулийн зүгээс үзүүлэх дэмжлэг, зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй байна. Олонх

сургуулийн хувьд Сурагчдын зөвлөл үйл ажиллагаагаа явуулах байр танхим байхгүй бөгөөд хурал цуглаан, уулзалтыг ихэвчлэн нийгмийн ажилтаны өрөөнд хийдэг. Харин хүүхдэд ээлтэй загвар сургууль болсон БГД-ийн 13 дугаар сургууль энэ талаар бусад сургуультай харьцуулахад давуу талтай байгааг хэлэх нь зүйтэй. Тус сургуульд 12 бие даасан ХӨУБ ажиллаж байгаа бөгөөд сургуулийнхаа “Хүүхэд хөгжлийн төв”-ийг тодорхой цагийн хуваарийн ашиглан, үйл ажиллагаагаа зохион байгуулж хэвшсэн байна. Мөн Дархан Уул аймгийн Жигүүр ЦС-д “Эцэг эхтэй ажиллах төв” нэртэй танхим, Архангайн Хүмүүн-III ЦС-д Сурагчийн зөвлөлд ажиллах танхим гаргаж өгчээ.

Судалгааны явцад багш сурагчдын өөр хоорондоо мэндлэх, харилцан хүндэтгэлтэй хандах байдалд ажиглалт хийсэн болно. Ангид хичээл эхлэхийн өмнө багш сурагчид бүгд мэндэлцгээдэг, сурагчдын зүгээс багш нарт хүндэтгэлтэй хандаж, мэндчилдэг. Харин сурагчид өөр хоорондоо мэндчилэх, харилцан хүндэтгэлтэй хандах байдалд төдийлэн онцгойлох зүйл ажиглагдаагүй болно.

Судалгааны хүрээнд “Иргэншил”, “Иргэний боловсрол” хичээлийн кабинет, танхим байгаа эсэхийг тодруулахад одоогоор дагнасан кабинет байхгүй байна. Олонх сургуулийн хувьд тухайн хичээлүүдийг нийгэм судлалын, түүхийн кабинеттэй хамт тохижуулсан байна. Иргэншил хичээлийн кабинетгүй байгаа, мөн ерөнхий боловсролын түвшинд кабинетийн системээр хичээл орохгүй байгаа зэрэг нь уг хичээлийн зорилго, ач холбогдолд сөргөөр нөлөөлж буй бөгөөд энэ талаар багш нартай хийсэн ярилцлагын үеэр маш дэлгэрэнгүй хөндөгдсөн болно.

Хэдийгээр эдгээр үзүүлэлтүүд нь сургуулийн аж ахуйч байдал, төсөл хөтөлбөрт хамрагдсан байдал зэргээс ихээхэн шалтгаалах боловч эдгээрийг даган сургуулийн дотоод харилцаа, ардчилсан уур амьсгал болон суралцагчдад иргэнлэг чанар төлөвшихөд ихээхэн нөлөөлөл үзүүлэхүйц орчин юм. Сургуулийн эдгээр орчин нь сургалтын чанар, үр дүнд шууд нөлөөлөх, цаашид сургуулийг ардчилсан, хүүхдэд ээлтэй болгон хөгжүүлэх гол алхмууд байх болно.

Сургуулийн орчны ажиглалтаас үзэхэд сурагчдын хичээлээр олж авсан мэдлэг, чадвар, хандлагыг бэхжүүлэхэд багш, сурагчдын харилцаа, сургуулийн үйл ажиллагаа нь өөрөө ардчилал, хүний эрх, нээлттэй олон ургальч хандлагыг хүндэтгэсэн байх зэргээр илрэх сургуулийн соёл нь бодитой дэмжлэг болж чадахгүй байна. Хэдийгээр энэ чиглэлээр зарим нэг сайн эхлэл тавигдаж эхэлсэн боловч энэ нь түгэн дэлгэрч бүхэлдээ ЕБС-ийн соёлыг тодорхойлохуйц хэмжээнд хүрээгүй байна. Иймээс бодлогын

түвшинд “Хүүхдэд ээлтэй сургуулийн загвар” зэрэг сайн эхлэлийг нийт ЕБС-д түгээх, хэвшил болгоход анхаарах шаардлагатай байна. Үүний тулд сургуулийн удирдлага, менежментийг өөрчлөн боловсронгуй болгох, захирал, сургалтын менежерүүдийг мэргэшүүлэх шаардлагатай байна.

III. “ЕБС-ийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг” судалгааны фокус бүлгийн ярилцлага

Энэхүү судалгааны хүрээнд зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагуудад Дархан-Уул, Архангай аймаг болон нийслэлийн багш, арга зүйч нийт нийт 36 мэргэжилтэн оролцлоо. “Иргэншил” ба “Иргэний боловсрол” хичээлийг нийгмийн ухааны мэргэжлийн багш нар ихэвчлэн заадаг тул тухайн мэргэжлийн багш нарыг ярилцлагад урьж оролцуулсан юм. Ярилцлагаар “Иргэншил” ба “Иргэний боловсрол” хичээлийн агуулгын хүрээ, цагийн багтаамж, ном сурах бичгийн хүрэлцээ хангамж, багш нарын ажлын ачаалал, мэргэжлийн бэлтгэл, техник хэрэглэгдэхүүн, сургуулийн удирдлага болон бусад багш нарын дэмжлэг, хамтын ажиллагаа, суралцагчдын идэвх, сонирхол, оролцоо зэрэг олон асуудал хөндөгдсөнийг дор тоймлон танилцуулж байна.

Юуны өмнө “Иргэншил” ба “Иргэний боловсрол” хичээлүүд нь өнөөгийн нийгмийн байгууламж, ардчилал, хүний эрх, ёс зүй, эрх зүй зэрэг агуулгыг хамарч, хүнийг, иргэнийг төлөвшүүлэн, хөгжүүлэхэд чиглэдэг учраас багш нарын маш чухалчлан үздэг хичээл ажээ. Нөгөө талаас, тухайн хичээлээр нийгмийн амьдралын асуудлуудыг авч үзэн, сэдэв агуулга нь өргөн хүрээг хамардаг тул суралцагчид сонирхож, үзэл бодлоо илэрхийлэх, харилцааны чадварт суралцах боломж хэмээн идэвхтэй оролцдог байна. “Иргэншил” хичээлийн үндсэн агуулгад нь эрх зүй, хүний эрх зонхилж байгаа бөгөөд Иргэншил-I болон II сурах бичиг 2006, 2007 онд шинээр хэвлэгдэн гарч, тэдгээрт иргэний чадвар, үнэлэмжид хандсан сэдвүүд нэмж орж ирсэн нь илүү амьдралд нийцтэй, сонирхолтой болгож байгааг багш нар онцолж байна. Тухайлбал, Иргэний баримт бичиг, иргэний эрхэмлэл, үнэт зүйлсийн тогтолцоо болон иргэн хүнд байвал зохих чадварууд зэрэг сэдвийг амьдралын бодит жишээн дээр тулгуурлан сурагчдад хүргэж байгаа нь тэдний сонирхолд нийцэн, хичээлийг илүү сонирхолтой хэлбэрээр зохион байгуулахад тус нэмэр болдог байна.

Эдгээр сайн зүйл бий болохын зэрэгцээ дутагдалтай талууд мөн оршсоор байна. Тухайлбал, хамгийн гол асуудал бол эдгээр хичээл нь өөр хоорондоо огт уялдаа холбоогүй, тус тусдаа, өөр өөр хандлагаар заагдаж байгаад оршиж байгаа бөгөөд хичээл заахад тулгарч буй асуудал, бэрхшээлийг багш нар дараах байдлаар тодорхойлж байна:

- “Иргэншил” хичээлийн харилцаа, эрх зүй, хүний эрх зэрэг бүлэг, сэдвүүдийг суралцагчид их сонирхож идэвхтэй оролцдог бөгөөд эдгээр асуудлаар ихэвчлэн маргаан мэтгэлцээн, бүлгийн ажил зохион байгуулагддаг. Гэтэл нэг хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байдаг тул төлөвлөсөн хичээлээ цагт нь багтааж чаддаггүй тул тухайн хичээлийн цагийг сунгах, эсвэл долоо хоногт 2 цагаар орох зэрэг зохицуулалт хийх шаардлагатай байна.
- Анги дүүргэлт өндөр байгаа нь хичээлийг интерактив арга зүйгээр зохион байгуулахад бэрхшээл учруулдаг. Ажиглалтын тэмдэглэлээс харахад сумын сургуулийн ачаалал бага, харин нийслэл, аймгийн төвийн ажиглалт хийсэн ангиуд 30-40 сурагчтай байлаа.
- Төгсөх ангид уг хичээлээр шалгалт авдаггүй учраас сурагч, багш нар тухайн хичээлд ач холбогдол өгөхгүй хайнга хандах байдал гардаг.
- “Иргэншил” хичээлийн сурах бичгийн хүрэлцээ хангамж муу, багш нарт зориулсан гарын авлага, нэмэлт материал дутмаг байдгаас хичээлийг төлөвлөсний дагуу зохион байгуулахад хүндрэлтэй байдаг. Мөн сургууль бүр номын сантай боловч шинэ номоор фондоо баяжуулахдхгүй. Тухайлбал, сургуулийн номын санд Үндсэн хууль ганц хувь л байдаг. Сургалт семинар зэрэгт ихэвчлэн захирал, сургалтын менежер оролцдог боловч түүний дараа сургууль дээрээ түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулдаггүй, ном, гарын авлага зэргийг сургуулийн номын сан, багш нарт өгөхгүй байх нь нийтлэг, бусад эх сурвалжаас багш нар хүрэх мэдээлэл хязгаарлагдмал тул багш нар мэдээллээс хоцрогдож байгаа ажээ. Ядаж л багш нарт олдохгүй байгаа түүх, нийгмийн ухааны боловсролын стандартын баримт бичгүүдийг олонтоогоор олшруулж, багш, сургуулиудаар түгээх шаардлагатай байна.
- Кабинетийн систем алдагдаад байгаа нь хичээлийн чанарт сөргөөр нөлөөлж байна гэж багш нар үзэж байна. Сургууль, ангийн эд хогшлийг хамгаалах гэсэн зорилго давамгайлснаас

сургалтын чанар, үр өгөөжийг анхаарахгүйд хүрч байгаа ажээ. УБ хотын хэмжээнд Иргэний боловсролын кабинет тохижуулсан ганц сургууль (87-р сургууль) байдаг ажээ.

- Энэ хичээлийг зааж буй багш нарт нийгмийн шинжлэх ухааны тал бүрийн мэдлэг хэрэгтэй болдог. Зарим үед сурагчдын асуултад хариулж чадахгүй байх тохиолдол гардаг бөгөөд энэ нь залуу багш нарыг хүнд байдалд оруулдаг тухай тэд ярьж байна. Энэ байдал нь багш нарын мэргэжлийн бэлтгэлтэй шууд холбоотой гэж тэд үзэж байгаа бөгөөд иргэний боловсролын системтэй боловсрол эзэмшээгүй багш нар олон байна. Багшийг зөвхөн тодорхой шинжлэх ухааныг судалж, заахад бэлтгэдэг тул иргэний боловсролын чиглэлээр сурагчдад мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх аргагүйг олж аваагүй тухай багш нар онцолж байна.

Ярилцлагаар иргэний боловсролын сургалтын талаар багш нарын санаа, бодлыг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ:

- “Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөр, стандарт, агуулгын хүрээ боловсрогдоогүй, арга зүйчдэд болон багш нарт зориулсан нэгдсэн заавар зөвлөмж байдаггүй тул сургууль, багш бүр өөр агуулга, арга зүй, хандлагаар уг хичээлийг заадаг.
- Уг хичээлийг ихэвчлэн цаг дутуу багшийн ажлын ачааллыг нөхөх юмуу анги удирдсан багшаар заалгадаг практик нэлээд дэлгэрсэн байна. Мөн “Иргэний боловсрол” хичээлийн цагт өөр бусад судлагдахуун, агуулгыг нэмж оруулах, оруулахаар санал болгох тохиолдол их байна. Тухайлбал, 2009-2010 оны хичээлийн жилд төвийн бүсийн нийгмийн ухааны багш нарт зориулан 2 удаа сургалт зохион байгуулж, “Хүмүүнлэгийн эрх зүй”, “Хүн худалдаалах гэмт хэрэг” гэсэн сэдвээр хичээлийн сэдэв, агуулга боловсруулсныг “Иргэний боловсрол” хичээлийн хүрээнд багтаан заахыг багш нарт даалгасан байлаа.

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулиар аймаг, нийслэлийн боловсролын газар нь сургуулиудыг арга зүйн удирдлагаар хангах, боловсролын хяналтын байгууллага нь стандартын хяналтыг тогтмол хийх чигүүрэгтэй байдаг. Гэтэл эдгээр байгууллага ЕБС-ийн хүний эрхийн нөхцөл байдал болон боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөнд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахад анхаардаггүй тухай урьд өмнөх судалгаанд ч мөн дурьдагдаж байжээ.²² Энэ нь мөн

²² БХАН (2003). Монгол дахь сургууль завсардалтын судалгааны тайлан (хэвлэгдээгүй)

боловсролын байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо, ажлын чиг үүрэг, бодлого, төлөвлөлт, үнэлгээний тогтолцоо бүрэн сайн жигдэрч чадаагүйтэй холбоотой байна.

Иргэншил хичээлийг чухалчлан үзэх нь

Манай суманд энэ хавар нэгэн асуудал дэгдсэн юм. Ахлах ангийн сурагчид сургууль дээрээ маргалдан зодолдсоны улмаас нэг сурагч бэртэж гэмтсэн тул сурагчдыг цагдаагийн хэсгээс шалгасан юм. Энэ байдал нь манай сургуулийн хэмжээнд нилээд асуудал дэгдээсэн. Тухайлбал, багш нарын зүгээс эдгээр сурагчид орж байгаа “Иргэншил” хичээлийн агуулга, түүнээс сурагчдад үзүүлж буй нөлөөллийн талаар ихээхэн шүүмжилж, маргалдахад хүрсэн юм. Ялангуяа уг хичээл өөрийн үндсэн зорилгодоо хүрч, сурагчдад үлгэр дууриал болж, хууль эрх зүй болон үүрэг хариуцлагын талаарх ойлголт, мэдлэг өгч чадаж буй эсэх талаар хүчтэй шүүмжлэл өрнөсөн. Энэ нь ч үнэний хувьтай зүйл байсан юм. Үүний дараа манай сургуулийнхан ярилцсанаар “Иргэншил” хичээлийг зөвхөн нийгмийн ухааны багш нараар заалгаж байхаар тогтсон. Энэ нь тухайн хичээлийн үүрэг зорилго, ач холбогдлын талаар багш нарт нэгэн нийтлэг ойлголт бүрэлдэж байна гэсэн үг юм.

Багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Багш нартай хийсэн ярилцлага нь бидний ажиглалтын судалгааны баримтууд болон дүгнэлтийг чанарын хувьд баталгаажуулж өгснөөрөө ач холбогдолтой болсон юм.

Хэдийгээр энэхүү судалгаанд хамруулаагүй ч ерөнхий боловсролын түвшинд иргэний боловсрол олгох талаар өргөн хүрээнд ажиллаж байгаа нийслэлийн БГД-ийн Гоц авъяастан хүүхдийн ᠑3 дугаар сургуулийн жишээг энд харуулъя. Энэ сургууль 2001 оноос “Хүн байхын учир” (сурагчдын нэрлэж хэвшсэнээр “Итгэл, урам” хичээл) хэмээн нэрлэсэн сургалтын багц хөтөлбөрийг боловсруулан зааж байна. Уг сургалтын хөтөлбөр дараах зорилтуудыг агуулдаг байна:

- *Бага боловсрол* – суралцагчдад эерэг, зөв дадал зуршил, зан чанартай болоход анхаарсан “Хүн болох багаасаа” хөтөлбөр
- *Суурь боловсрол* – хүний амьдралын мөн чанарыг ойлгон ухаарч, өөртөө итгэлтэй, өөдрөг бодол санаатай, зорилготой хүн болж төлөвшүүлэх зорилготой “Хүн байхын учир” хөтөлбөр
- *Бүрэн дунд боловсрол* – мэдсэн сурсан зүйлээ амьдралдаа бүтээлчээр хэрэглэхэд сургах зорилттой “Сайн үйлийн эзэн” хөтөлбөр

Улмаар 2009-2010 оны хичээлийн жилээс эхлэн нийслэлийн БГД-ийн бүх ЕБС-д энэ хөтөлбөрөөр “Хүн байхын учир” хичээлийг орж байна.

БГД-ийн хувьд энэ хичээлийг “Иргэний боловсрол” хичээлийн цаг дээр бүх сургууль дээр орохоор журамлаж, уг сургалтыг зохион байгуулах сургагч багш нарыг дүүргийн хэмжээнд бэлтгэж, мэргэжлийн удирдлага, заах арга зүйн талаас ᠑3 дугаар сургууль зөвлөх үүрэгтэйгээр ажиллаж байна. Үүний дагуу 13 дугаар сургуульд дээрх хөтөлбөрүүдийн дагуу “Итгэл, урам” хичээлийг –“Иргэний боловсрол” хичээлийн хүрээнд хичээлийн жилийн 4 улиралд нийт 35 цагаар (I-10, II-9, III-8, IV-8 цаг) орж байна.

Хүснэгт 20. “Итгэл, урам” хичээлийн агуулгын тойм

Анги	Үндсэн ай	Үзүүлэлтүүд	Шалгах арга хэлбэр
Зорилго: Зөв дадал, зуршлын эзэн болох			
1-2-р анги	- Эрүүл бие - Сайхан сэтгэл - Саруул ухаан	- Ахуйн ариун цэвэр - Хоол, хүнс - Хөдөлгөөн, - Ажил амралтаа зохицуулах - Хүнийг хайрлах хүндэтгэх - Өөрийн зорилго, авьяас сонирхлыг нээх	- Өдрийн дэглэм, - Цагийн хуваарь - Сурагчийн дадал, зуршил
Зорилго: Шилдэг зан чанарын эзэн болох			
3-5-р анги	- Эрүүл бие - Сайхан сэтгэл - Саруул ухаан	- Цэвэрч нямбай зан - Хувцаслах соёл - Хайр талархалтай байх - Итгэл даах - Асуудалд бодитой хандах - Ажилсаг бүтээлч байх	- Өөрийн яриа, үнэлгээ - Эцэг эхийн яриа, үнэлгээ - Найз нөхдийн ажиглалт үнэлгээ, - Багшийн ажиглалт, тэмдэглэл - Сурснаа биеэр хийж үзүүлэх - Амжилтын дэвтэр, зорилгын дэвтэр түүний хэрэгжилт
Зорилго: Өөртөө итгэлтэй, өөдрөг санаа бодолтой, зорилготой хүн болж төлөвших			
6-8-р анги	- Тухайлсан айг ялган зааж өгөөгүй байна	- Аз жаргал, амжилтын эзэн байх - Зөв үг яриа, бодол санаа, үйл, хандлага, хайр хүндлэл, эргэцүүлэл, тэмүүлэл, бясалгал, төвлөрөл	- Өөртөө гарсан өөрчлөлтөө тэмдэглэдэг дэвтэр - Бодол санаагаа удирдах арга барил, туршлага - Сайн ажил үйлсийн жишээ, түүнээс авсан сургамж - Хүсэл мөрөөдлийн цомог
Зорилго: Хүүхэд залууст өөрсдийг нь байнга хөгжүүлж байх амьд бүтээлч орчин бий болгон асуудал шийдвэрлэхэд нь тусалж, бүтээлч сайн үйлийн эзэн болгох			
9-12-р анги	- Тухайлсан айг ялган зааж өгөөгүй байна	- Өөрийнхөө жинхэнэ эзэн байх - Гэр бүлийн гишүүн байх - Найз нөхөр байх - Шавь, сурагч байх - Бүтээлч иргэн болох	- Багаар хамтарч ажиллах - Сайн дурын клубууд байгуулах - Асуудал шийдвэрлэх, бодит үйл ажиллагаанд оролцох - Нэгтгэн дүгнэх

ЕБС-ийн олгож буй Иргэний боловсролд үнэлгээ, мониторинг хийх энэхүү төслийн хүрээнд хийсэн танхимын сургалтын мониторингийн дүнг хичээлийн болон сургуулийн соёлын хүрээнд нэгтгэн дараах дүгнэлтийг хийж байна:

Зураг 10. Ангийн мониторингийн бүрэлдэхүүн хэсгүүд



- Хичээлээр болон сургуулийн соёлоор МУ-ын Үндсэн хууль болон нийгмийн ухааны боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт тусгагдсан үнэт зүйлсийн баримжаалал, иргэний, ардчилсан, хүмүүнлиг нийгэмд ажиллаж амьдрахад шаардагдах мэдлэг, хандлагыг бодитой дэмжиж чадахгүй байна. Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр нь газар дээрээ буюу сургуулийн анги танхимд хэрэгжихгүй, тэнд уламжлалт чиглэл давамгайлсан хичээл явагдаж байна.
- Иргэний боловсролын үндсэн чиглэл (үзэл баримтлал, бодлого), стандарт байхгүй, иргэний боловсрол олгох хичээлийн агуулгыг бүрэн дунд боловсролын түвшинд хэрэгжих нийгмийн тухай мэдлэгийн болон эрх зүйн боловсролын стандартыг баримжаалан сонгон боловсруулж байгаа нь агуулга тогтворгүй байх, материал олдоцыг харж сэдэв сонгох зэрэг бэрхшээлийг үүсгэж байж болох талтай.
- Үндсэн хуулиар баталгаажуулан хамгаалж, сургалтын баримт бичигт тусгалаа олсон үнэт зүйлс, үнэлэмжийг сурагчдад төлөвшүүлэхэд багшийн мэргэжлийн мэдлэг, хамгийн гол нь заах арга зүйн ур чадвар дутагдалтай байна. Ялангуяа хичээлийн зорилгыг хангах, чанаржуулахын тулд сурагчдын сурах үйлийг

дэмжсэн идэвхтэй оролцооны аргуудыг өргөнөөр хэрэглэх нь зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, иргэний боловсрол нь зөвхөн анги танхимд төвлөрөх бус харин анги танхим, сургууль, хороо, дүүрэг зэрэг тухайн суралцагчийн амьдарч буй орчин, нийгэм дэх асуудлыг судлан танилцах, оролцон хэрэгжүүлэх боломжтой байхуйцаар зохион байгуулах арга хэлбэрүүдийг эрэлхийлэх хэрэгтэй. Үүний тулд орон нутаг дахь үйлдвэрлэл, бизнесийн байгууллага, сум дүүрэг, баг хороодын засаг захиргаа, Иргэдийн хурал, боловсрол соёлын бусад байгууллага, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах, тэдгээрийг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах нь зүйтэй. Яамдын байр, Парламентын ордон нь сургуулийн сурагч, багш, оюутнуудаар дүүрэн байдаг бусад улс орны адилаар манай Төрийн ордон ч мөн нээлттэй байх, оролцох, ажиглах боломжийг олгох нь зүйтэй. Мөн тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаатай танилцах, бидний хэрэглэж буй бараа, бүтээгдэхүүн хэрхэн үйлдвэрлэгдэж хэрэглэгчдэд хүрч байгааг танилцуулах нь мэргэжлийн чиг баримжаа олж авах, сонголт хийх болон бусдыг хүндэтгэх соёлд сургах болно.

- Сургалтын явцад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээллийн агуулгыг задлан шинжлэх, судлах, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой ажиллах байдлаар зохион байгуулж болох юм. Хүний эрх, иргэний боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд нь энэ хичээлийг зохион байгуулж буй багш нарын хувьд байнгын хамтран ажиллах, жижиг төсөл хэрэгжүүлэх боломжийг нээж өгнө. Энэ бүхэн нь суралцагчдын хувьд бие хүн төлөвших, нийгэмшин амьдрах, нийгмийн амьдралыг зохицуулах хэм хэмжээ, дүрэм журамтай танилцан, түүнийг мөрдөх, хэрэгжүүлэх, түүнд зохицон амьдрах чадварыг бий болгох, хөгжүүлэхэд чиглэгдэнэ.
- Иргэний боловсролын бусад боловсролоос ялгагдах нэг онцлог нь орчны нөлөөлөл хүчтэй байдгийг иш үндэс болгон сургуулийн орчин, соёл нь хүний эрхийн болон ардчилал, хүмүүнлэгийн үнэт зүйлсийг дээдэлсэн орчин байхад анхаарах шаардлагатай байна.

ГУРАВ. ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

3.1 Иргэний боловсролын тухай ойлголт, үзэл баримтлал

Иргэний боловсрол хэмээх ойлголт нь англи хэлтэн улс орнуудад *Civic education, Citizenship education* хэмээх хоёр ойлголтоор илэрхийлэгддэг бөгөөд боловсролын харилцаанд янз бүрийн утгаар хэрэглэгдэж байна. Зарим судлаач “civic education” буюу иргэний боловсрол нь хүүхэд, залуучуудыг нийгмийн идэвхтэй гишүүн болгон бэлтгэх боловсролын салбар, харин “citizenship” буюу иргэншил нь тухайн нийгмийн гишүүд иргэн болон төлөвших үйл явцыг тэмдэглэсэн ойлголт хэмээн ялган үздэг байна.

“Иргэний боловсрол”-ын талаарх ихэнх тодорхойлолтыг харахад²³ ардчилсан нийгэмд ажиллаж амьдрахад зайлшгүй шаардагдах, төртэй эрх тэгш харилцах мэдлэг, чадвар, арга ухаанд суралцах үйл явц болох талаас нь тодорхойлсон байна. Тийм ч учраас өнөөдөр иргэний, улс төрийн, ардчиллын болон хүний эрхийн боловсрол нь дэлхийн улс орнуудын боловсролын хөгжлийн чухал чиглэл болоод байгаа. Боловсролоор дамжуулан иргэнлэг чанар төлөвшүүлэх, иргэний боловсрол олгох үйл ажиллагаа нь боловсролын үндсэн зорилгын нэг, түүний чанарын шалгуур, нийгмийн зөвшилцлийн арга хэрэгсэл мөн хэмээн олон улс оронд хүлээн зөвшөөрч, иргэний боловсролын талаар төрийн бодлого, үзэл баримтлал боловсруулан хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО) нь өөрийн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдэд иргэний боловсролд холбогдох дараах зарчмуудыг баримтлахыг зөвлөдөг:

- Иргэний боловсрол нь хүний эрхийн зөрчил, аливаа хүчирхийллээс сэргийлж, тэгш байдал, ардчилсан нийгэм дэх шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог дэмжиж байдгийн хувьд тогтвортой хөгжлийн үндэс суурь болно.
- Иргэний боловсрол нь хүний эрх чөлөөг эрхэмлэн хүндэлж, аливаа зөрчил, эрсдлээс хамгаалж байдгийн хувьд зөв, шударга нийгмийг зохион байгуулахад чухал хөрөнгө оруулалт болно хэмээн үздэг.

²³ Фелиса Тиббетс (1999) “Латин Америк дахь иргэний боловсрол: Ирээдүйд бэлтгэх нь” судалгааны тайлан. Мөн Буттс (1990). The Thesaurus of ERIC Descriptors (Houston)

Улмаар улс орон, тэдгээрийн боловсролын байгууллагад хандан иргэний боловсрол олгох сургалтын хөтөлбөрт дараах 4 үндсэн харилцааг тусгах шаардлагатай хэмээн ЮНЕСКО-ийн зөвлөмжид тусгаад, эдгээр нь “Иргэний боловсрол” хичээлийн агуулгыг бүрдүүлэх тухай зөвлөжээ:²⁴

1. Хувь хүн ба нийгэм хоорондын харилцаа
2. Иргэн ба төр хоорондын харилцаа
3. Иргэн ба ардчилсан ёс хоорондын харилцаа
4. Иргэний эрх ба үүрэг хоорондын харилцаа

ЮНЕСКО-гоос 1987 онд “Хүний эрхийн сургалт, мэдээлэл ба баримт бичиг” сэдвээр Мальт улсад зохион байгуулсан олон улсын бага хурлаас НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хандан “бүх иргэн, хүн амын бүлэгт хүртэх боломжтой хүний эрхийн боловсрол, сургалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг гишүүн улс орнуудын анхааралд хүргэн”, “түүх, иргэний боловсрол зэргийн хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг тусгаж, зөрчлийг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийлийн бүс стратегийг боловсруулах, улмаар гишүүн орон бүрийн тухайн боловсролын талаарх амжилт ололтыг 5 жил тутамд үнэлж байх”²⁵ талаар зөвлөжээ.

1999 онд хэрэгжүүлсэн Иргэний боловсролын олон улсын харьцуулсан судалгаанд²⁶ хамрагдсан улс орнууд Иргэний боловсролтой холбогдох зорилго, зорилтуудыг янз бүрээр тодорхойлдог болохыг онцолжээ. Тэдгээрийг тоймлон үзвэл дараах хэдэн зорилт илүү нийтлэг байна:

- Хувь хүний чадавх, бололцоог нэмэгдүүлэх
- Тэгш бололцоог дэмжих
- Залуу үеийг ажил хөдөлмөрт бэлтгэх
- Цаашдын буюу дээд боловсрол эзэмших үндэс суурийг тавих
- Мэдлэг, чадвар, ойлголт бий болгох
- Иргэншил буюу ардчилал ба нийтлэг хэм хэмжээнд суралцуулах
- Соёлын өв уламжлалаа хадгалах, эдлэх явдал зэрэг болно.

²⁴ Civics education for the twenty-first century <http://portal.unesco.org/education/en/2006-08-26>

²⁵ Viswanath D.Karad (1999) Human Rights Education, Social Change and Human Values. Balwant Printers Pune: India, 21 дэх тал

²⁶ David Kerr (1999). Citizenship Education: International Comparison Study

Үүнээс үзэхэд иргэний боловсрол нь хүний эрх, ардчилал, улс төр, иргэн - төрийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцын талаар мэдлэг эзэмших, чадвар, хандлагаа хөгжүүлэх үйл явцыг багтаасан, олон бүрэлдэхүүн хэсэг бүхий насан туршийн боловсрол юм. Иргэний боловсролын агуулгад мөн плюрализм, олон соёлт орчин, угсаатны ба соёлын өв уламжлал, нийгмийн ялгарал, хүлээцтэй хандах байдал, нийгмийн зүй ёс, үндэсний онцлог, ухаалаг байдал, байгаль орчны ач холбогдлын мэдрэмж зэрэг олон шинэлэг асуудал тусдаг байна.

Баримт бичгүүд болон судлаачдын үзэл бодлоос харахад иргэний боловсролын гол зорилго нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихэд нь дэмжлэг үзүүлэх, чиг баримжаа олгоход чиглэж байна. Хүн нийгмийн амьдралын олон талт харилцаанд оролцдог учир тухайн хүнд нийгмийн харилцааны үндэс суурь, зарчмууд, үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдлэг, ойлголт байх шаардлагатай. Тиймээс иргэний боловсролын хичээлийн агуулга нь улс төр, эдийн засаг, нийгэм, ёс суртахуун, соёлын гэсэн 5 үндсэн ай (домайн)-н хүрээнд боловсрогдож, эдгээрийн талаар зохих мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн судлаачид үздэг байна.²⁷

Дэлхийн улс орнуудад “Иргэний боловсрол”-ын агуулгыг олон хичээлийн хүрээнд багтаан олгодог. Тухайлбал, нийгмийн ухаан, нийгэм судлал, дэлхий судлал, хүн ба нийгэм, амьдралын ухаан, албан ахихуй, хүний эрхийн боловсрол, ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд улс орнууд өөрийн иргэддээ орчин үеийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох талаар зохих чадвар, хандлагыг төлөвшүүлж иржээ. Түүнээс гадна иргэний боловсрол нь түүх, газарзүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин судлал, шашин судлал, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдтэй байнгын интеграцид байж, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд анхаардаг байна.

Олон улсын хамтын нийгэмлэг болон дэлхийн олон улс орнууд иргэний боловсролд анхаарч байгаа боловч түүнд нийтлэг бэрхшээлүүд байгааг судлаачид тэмдэглэж байна. Юуны өмнө иргэний боловсролын тодорхойлолт, ойлголт, загварууд маш олон янз байна. Энэ нь улс орон бүр

²⁷ Kathleen Cotton (2006). Educating for Citizenship өгүүлэл. www.nwrel.org/scpd/sirs/10/c019.html

иргэний боловсролын үндэслэл, нөхцөл байдал, цар хүрээ зэргийг өөр өөрөөр тодорхойлоход хүргэдэг байна.

3.2 Иргэний боловсролын талаарх үндэсний санаачлагууд

Бодлого, хөтөлбөр, эрх зүйн орчны чиглэлээр:

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”²⁸ гэж заасан нь иргэний боловсролын эрхэм зорилго, үндэс суурь болж байна. 2002 онд батлагдсан “Боловсролын тухай” хуульд Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус тогтолцооноос бүрдэх тухай зааж, “албан бус боловсрол гэж боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ”²⁹ гэж тодорхойлжээ. Энэ талаар бид тайлангийн хоёрдугаар хэсэгт авч үзсэн болно.

УИХ болон Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдэд иргэний боловсрол болон түүнд хамаарах боловсролын салаа мөчрүүдийг ямар нэгэн байдлаар тусгасан ч тэдгээрийн хэрэгжилт, үр нөлөө янз бүр байна. Тухайлбал, 2003 оны 10 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан “Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр” нь Монголын төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа, механизмыг бүрдүүлэх, хүний эрхийг эрхэмлэн дээдлэхэд бүх талын оролцоо, санаачлага, хариуцлагыг өрнүүлэх, чиглэл, арга замыг тодорхойлсон баримт бичиг юм. Хөтөлбөрийн 1.1.2.6-д “Хүний эрхийн боловсролын төлөв байдал, хэрэгцээ шаардлага, хамрах хүрээг судалсны үндсэн дээр хүн ам, төрийн албан хаагчид, удирдах ажилтан, бүх шатны сургуулийн сурагч, оюутны хүний эрхийн албан ба Хүний эрхийн сургалтын тогтолцоог бүрдүүлж, энэ асуудлаар үндэсний мэргэжилтэн, сургагчдыг бэлтгэхэд хөтөлбөргарган хэрэгжүүлнэ” хэмээн заагаад, “...иргэдийн ерөнхий боловсролын болон эрх зүйн мэдлэгийн түвшинг цаашид дээшлүүлэн эрхээ эдлэх, хамгаалах чадвар эзэмшүүлэхэд чиглүүлэх шаардлага тавигдаж байна”³⁰ хэмээн онцолжээ. Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар авсан удирдлага, зохион

²⁸ Kathleen Cotton (2006). Educating for Citizenship өгүүлэл. www.nwrel.org/scpd/sirs/10/c019.html

²⁹ Боловсролын тухай хуулийн 3.1.7 дугаар заалт

³⁰ Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. УБ, 2003 он, 4 дэх тал.

байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө нөөц дутмаг байдлаас шалтгаалан хөтөлбөрийн хэрэгжилт удааширч, орхигдсон байна. Үүний улмаас 2007 оны 1 дүгээр сард Засгийн газрын 17 дугаар тогтоолоор “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2007, 2008 оны төлөвлөгөө” батлагдсан бөгөөд үүнд хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцооны загвар боловсруулж, хүний эрхийн асуудлаар мэргэшсэн үндэсний мэргэжилтэн, сургагч бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулж, цаашид хэрэгжүүлж ажиллахыг БСШУЯ-д даалгасан байна. Мөн хүний эрхийн боловсролын албан ба албан бус боловсролын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахыг ХЗДХЯ, ХЭҮК, ХЗҮТ зэрэг төрийн байгууллага, Сонгогчдын боловсрол төв, МАОЭНХ, МҮЭХ, Эмнести Интернейшнл зэрэг ТББ-д тус тус чиглэл болгожээ.

Үүний адилаар МУ-ын Засгийн газрын “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ХЗДХЯ-наас 2004 оны 2 дугаар сард “Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр”-ийг баталж, “Эрх зүйн албан бус сургалтын төв”-ийг Хууль зүйн үндэсний төвийн дэргэд байгуулсан нь ялангуяа хууль, хяналтын байгууллагын ажилтан албан хаагчдад хүний эрх, иргэний боловсрол олгох үйл ажиллагаанд нэгэн чухал алхам болсон гэж үзэж байна.

2005 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилт” баримт бичигт “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх гэсэн зорилгын үүднээс Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэж, чандлан сахих, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох, ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх, авилгыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх”³¹ гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн нь иргэний, ардчиллын боловсролын хэрэгцээ шаардлага, зорилгыг Мянганы хөгжлийн зорилтын түвшинд тодорхойлсон гэж үзэж болно .

2006 онд батлагдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрт олон нийтийн мэдээллийн нээлттэй орчинг бүрдүүлэх замаар улс төр, эдийн засаг, нийгэм, боловсрол, шинжлэх ухаан, урлаг, соёлын талаарх мэдээллийг хүртэх тэгш боломжийг бий болгох, мэдээллийн бүх нийтийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах зорилгоор цахим ардчиллыг хөгжүүлэх санал, санаачилгыг дэмжих³² зорилго тавьжээ.

³¹ Төрийн мэдээлэл (2005). №17, 384 дэх тал

³² Төрийн мэдээлэл (2006). №2, 25 дахь тал

Хамгийн сүүлийн байдлаар 2010 онд Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний цогц хөгжлийн баримт бичигт заасны дагуу боловсролын салбарт баримтлах шинэ үзэл баримтлал, бодлогыг тусгасан “Боловсрол” үндэсний хөтөлбөр боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлаад байна. Энэхүү хөтөлбөрт үндэсний цөөнх эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангах, төрийн хэлний боловсрол эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх, хүний эрх, ардчиллын үзэл санааг албан боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх зэрэг олон санаачлага тусчээ.

Судалгаа, сургалтын үйл ажиллагааны талаар:

1990-ээд оны дунд үеэс олон улсын болон дотоодын иргэний нийгмийн байгууллагууд ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт “Иргэний боловсрол” хичээлийг оруулах чиглэлээр бодлогын нөлөөлөл явуулж, техникийн туслалцаа үзүүлж иржээ. МННХ-ээс иргэний боловсролын (эрх зүй) хичээлийн агуулга, арга зүйг боловсруулан, багш нарыг сургаж бэлтгэх, сурах бичиг зохиож хэвлүүлэх зэрэг ажлыг өөрийн сүлжээний дэмжлэгтэй хэрэгжүүлсний зэрэгцээ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, АНУ-ын Азийн сан, Конрад Аденауер сан, АНУ-ын БНОУХ зэрэг олон улсын байгууллага, мөн Иргэний Боловсрол төв, Сонгогчдын боловсрол төв, УТБА зэрэг дотоодын төрийн бус байгууллагууд ЕБС-ийн багш нарыг сургах, сургалтын материал, гарын авлагаар хангахад дэмжлэг үзүүлж иржээ.

Тухайлан иргэний боловсролын чиглэлээр хэрэгжсэн судалгааны ажил гэвэл үндэсний хэмжээнд 2006-2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Иргэний боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр” боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа, мөн СЕХ-ны захиалгаар хийсэн “Иргэний ба сонгогчийн боловсрол” судалгаа зэргийг нэрлэж болно. Харин иргэний боловсролын агуулгад холбогдох судалгаанууд нь ихэвчлэн хүний эрх, эрх зүйн боловсролд төвлөрсөн тал ажиглагдаж байна. Тухайлбал, ХЗҮТ-ийн “Иргэдийн эрхзүйн албан бус боловсролын хэрэгцээг судалсан тайлан” (2006), МУБИС-ийн Нийгмийн ухаанытэнхимээс Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Төв Азийн судалгааны санаачлага” төслийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн “Монголчуудын хүний эрхийн боловсрол ба соёлын хамаарал” судалгаа (2004), мөн “Монголын Хүүхэд Залуучуудын хөгжил” ТББ-аас зохион байгуулсан “Өсвөр үеийнхний хэрэгцээг үнэлэх судалгаа”, Азийн Сангийн Монгол дахь төлөөлөгчийн газраас “Эрх зүйн гэгээрэл Монголд” зэрэг судалгааны ажлууд хийгдсэн байна. Эдгээр судалгааны үр дүн болон түүнээс үндэслэн гарсан санал зөвлөмжүүд бүгд хүний эрхийн болон иргэний боловсролын

түвшин хангалтгүй, энэ чиглэлээр тодорхой бодлого боловсруулан ажиллах шаардлагатай болохыг онцолсон байна. Монголчуудын хүний эрхийн боловсролын ач холбогдлыг ойлгож байгаа боловч амьдрал дээр өөрийн эрх, эрх чөлөөг хэрхэн хамгаалах, аливаа зөрчил, эрсдэлээс хэрхэн сэргийлэх талаар цогц ойлголт, мэдлэг мэдээлэлгүй байна.

Хүний эрхийн боловсролын талаар:

Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүний эрхийг хангаж, хамгаалахад боловсрол ихээхэн чухал үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрсөн билээ. Энэ хүрээнд Хүний эрхийн боловсролын НҮБ-ын 10 жил (1995-2004), Бүхнийтийн боловсролын Дакарын тунхаглал (2000), Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр (2004) зэрэг олон улсын бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Ялангуяа Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн Үйл ажиллагааны төлөвлөгөөнд сургуулийн тогтолцоонд хүний эрхийн боловсролын нэвтрүүлэх, улмаар эрхэд суурилсан чанартай боловсрол олгох талаар зохих арга хэмжээ авах талаар гишүүн орнуудад даалгасан байдаг.

Хүний эрхийн боловсролын НҮБ-ын 10 жилийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн дорвитой үйл ажиллагаа бол албан боловсролд хүний эрхийн боловсролыг оруулжирсэн “Хууль бидний амьдралд” хөтөлбөр юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад анх удаа ерөнхий боловсролын сургуулиудад эрх зүй, хүний эрхийн боловсрол олгох цогц хөтөлбөр, сурах бичиг зэргийг арга зүйн хамт боловсруулсан байна. Үүний үр дүнд “Хүний эрх” хэмээх бие даасан хичээл дунд сургуулийн хөтөлбөрт анх удаа 1994 оноос орж эхэлжээ.

2004 онд БСШУЯ нь “Бага, дунд боловсролын стандарт”, мөн түүний бүрэлдэхүүн хэсэг болох “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-ыг шинэчлэн баталжээ. Энэхүү стандартын шинэчлэлийн хүрээнд хүний эрхийг ерөнхий боловсролын түвшинд заах, сургах талаар тухайн боловсролын агуулга, үнэлгээний стандартад тусгаж өгсөн нь хүний эрхийн боловсролыг албан боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх чиглэлд нилээд дэвшилттэй алхам болсон юм. Тухайлбал, өмнө нь зөвхөн нэг ангийн хүрээнд судалдаг байсан хүний эрхийн хичээлийг стандартын “агуулгын ай”-аар дамжуулан бага, дунд боловсролын бүх түвшинд судалж, сурагчдад хүний эрхийн мэдлэг, хандлага, чадварыг төлөвшүүлэхээр оруулсан байна. Энэ нь хүний эрхийн тухай ойлголт, мэдлэгийг суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан заах тухай НҮБХЭДКГ-аас гаргасан зөвлөмжид дөхөж очсон чухал өөрчлөлт болсон.

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрт дурдсанчлан бага, дунд сургуулийн тогтолцоон дахь хүний эрхийн сургалтын чанар, үр өгөөж нь тухайн сургуулийн хүний эрхийн орчинтой салшгүй холбоотой ажээ. Тиймээс БСШУЯ-наас “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх” тухай бодлогын баримт бичгийг батлан, хэрэгжүүлж байна. Энэхүү баримт бичиг нь “Бүх нийтийн боловсрол” Дакарын тунхаглал, НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” зэрэг олон улсын тунхаглалын үзэл санаанд нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд сургалтын орчин нь бүхэлдээ хүүхэд, залуучууд, суралцагчдын оюун санаа, бие бялдар, нийгэмшин хөгжихийн хэрэгцээ шаардлагад нийцэж, тэдний эрх, эрх чөлөөг хангасан байх ёстой гэсэн үзэл санаанд суурилсан байна. Улмаар БСШУЯ-наас бага, дунд сургуулиудын сургалт, үйл ажиллагааг хүүхдэд ээлтэй буюу тэдний эрхийг хэрхэн хүндэтгэж байгааг үнэлэх үнэлгээний загвар, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан байна.

Энэ салбар дахь томоохон санаачлагын нэг нь ХЭҮК-оос ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр “Хүний эрхийн боловсрол ерөнхий боловсролын сургуульд” төслийг 2005 онд хэрэгжүүлсэн явдал юм. Энэхүү төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуульд орж буй “Хүний эрх” хичээлийн чанар, үр нөлөө, сургалтын агуулга, заах арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ, багшлах боловсон хүчний өнөөгийн байдал, сургуулийн хүний эрхийн орчинд судалгаа хийж, нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид энэ хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгоход чиглэсэн үндэсний хэмжээний судалгааны ажлыг зохион байгуулжээ. Судалгааны үр дүнд хүний эрхийн хичээл нь сургалтын зорилго, агуулга, арга зүйд нийцэхүйц хэмжээнд хүрч чадаагүй, уламжлалт болон идэвхгүй арга зонхилсон хэвээр, энэхүү хичээлийг заах багшийг бэлтгэх, багшид тавигдах шаардлага боловсруулагдаагүй бөгөөд ЕБС дахь хүний эрхийн орчин төдийлөн хангалттай сайн биш гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Үүнээс уламжлан тус хичээлийн заах арга барил, чанар, үр өгөөжийг сайжруулах зорилгын үүднээс хүний эрхийн боловсролд холбогдох зөвлөмж, “Хүний эрх” хичээлийг заах багш нарт тавигдах шаардлага зэргийг боловсруулан холбогдох яам, байгууллагуудад хүргүүлсэн байдаг.

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т “...хүний эрхийн сургалтын албан ба албан бус тогтолцоог бүрдүүлж, үндэсний мэргэжилтэн сургагч багш нарыг бэлтгэх дэд хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ” хэмээн заалт багтсан бөгөөд уг заалтыг 2008 оны нэгдүгээр улиралд багтаан хэрэгжүүлэхээр уг хөтөлбөрийн 2007-2008 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгажээ.

Олон улсын Эмнести Интернэшнл байгууллага энэ зорилтыг дэмжин “Бага, дунд боловсролын байгууллагын багш нарт зориулсан “Хүний Эрхийн Боловсрол” төслийг 2006 оны 5 сарын 1-нээс Монгол – Австралийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлжээ. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүний эрх болон эрхэд суурилсан боловсролын тухай мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх замаар хүний эрхийн боловсролыг дэмжих, хүний эрхийг ЕБС-ийн хичээлүүдийн агуулгад интеграчилах замаар суралцагчдад суралцах таатай орчинг бүрдүүлэн, чанартай боловсрол эзэмших нөхцлийг хангахад хувь нэмэр оруулахад энэхүү төсөл чиглэжээ. Төслийн хүрээнд Эмнести Интернэшнл байгууллагын Английн салбараас хэвлүүлж гаргасан “Хүний Эрх Сургалтын Хөтөлбөрт” цувралын “Математик” ба “Түүх” ном, зурагт плакатыг хэвлүүлэн түгээжээ. Мөн “Хүний Эрхийн Боловсрол-Чанартай Боловсрол” сэдэвт сургалтыг нийт аймаг орон нутагт 14 удаа зохион байгуулсан байна. Улмаар уг төслийн залгамж ажлын хүрээнд Эмнести Интернэшнл байгууллагын хэрэгжүүлж буй “Хүний эрхэд ээлтэй сургууль” олон улсын төслийн үйл ажиллагаанд УБ хотын Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуулийг загвар болгон хамруулжээ.

Хүний эрхийн боловсролыг албан боловсрол, ялангуяа ерөнхий боловсролд нэвтрүүлэхэд зайлшгүй анхаарах хэрэгтэй байгаа бөгөөд багш бэлтгэх, давтан сургах чиглэлээр хамтын ажиллагаа шаардлагатай байна. МУ-д багш бэлтгэх хамгийн томинститут болох МУБИС-д НҮБ-ын Хүүхдийн сан БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхдэд ээлтэй сургууль” төслийн хүрээнд багш бэлтгэх боловсролд хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэх зорилго бүхий Хүний эрхийн боловсролын төвийг байгуулан ажиллаж байна. Тус төв нь 48 цагийн агуулгатай 2 кредитийн “Хүүхдийн эрхийн боловсрол” шинэ курс хичээлийн хөтөлбөрийг боловсруулан, багш мэргэжлийн оюутнуудад сонгон суралцах хичээл хэлбэрээр хүргэж эхэлсэн байна. Уг хөтөлбөр нь хүний эрхийг заан сургах цогц чадамж олгоход чиглэгдсэн 8 модуль бүхий сургалтын иж бүрэн хөтөлбөр, гарын авлага, дасгал ажлын хэрэгслүүдтэйгээр боловсруулагдсан байна. Уг хөтөлбөрийг 2006 оноос хойш МУБИС-ийн түүх, нийгмийн ухаан, эрх зүй, хүмүүнлэгийн ухааны багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд сонгон суралцах боломжтой бөгөөд жил бүр дунджаар 60-90 оюутан хамруулж байна. Гэвч уг хичээлийг МУБИС болон бусад их дээд сургуульд багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд сонгон суралцах боломж хязгаарлагдмал хэвээр байна. Тиймээс “Хүүхдийн эрхийн боловсрол” хичээлийг багш мэргэжлээр суралцаж буй болон багш нарын мэргэжил

дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт заавал сонгон судлах хичээл болгон оруулах зорилгоор хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, сургалтын агуулга, арга зүйг өргөжүүлэх чиглэлд тус төв ажиллаж байна. Уг ажилд БСШУЯ, ХЭҮК, НҮБ-ын Хүүхдийн сан, МУБИС зэрэг байгууллага хамтран ажиллахаа илэрхийлжээ.

МННХ (Соросын сан)-гаас хэрэгжүүлсэн “Хууль Бидний Амьдралд” хөтөлбөр:

1970-аад оны дундуур АНУ-д хүүхэд, залуучуудад эрх зүйн туслалцаа үзүүлэх, тэдний иргэний чадварыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжиж эхэлсэн “Хууль бидний амьдралд” (Street Law) хөтөлбөр нь манай оронд МННХ (Соросын сан)-ийн санаачлагаар 1997-2002 онд хэрэгжсэн юм.

Энэхүү төслийн хүрээнд ННХ-ийн сүлжээнд хамрагдсан бусад орны адил, МННХ нь хуульч, нийгмийн ухааны багш, арга зүйчдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, эрх зүйн заах арга, сургалтын материалыг боловсруулах сургалтанд хамруулснаар хөтөлбөрийн үйл ажиллагаа өргөжиж Гэгээрлийн Яамтай (хуучин нэрээр) хамтран ажилласан байна.

“Хууль бидний амьдралд” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Ерөнхий боловсролын түвшинд хүрсэн үр дүнг нэгтгэж үзвэл:

- Бага дунд боловсролын түвшинд эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг иргэний, ардчилсан, эрх зүйт төрийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчилсэн.
- 1-10 дугаар ангийн эрх зүйн сурах бичгийг багшийн гарын авлагын хамт боловсруулан сургалтад хэрэглэж эхэлсэн.
- Эрх зүйн сургалтын шинэчлэлийг гардан зохион байгуулах чадвар бүхий 26 үндэсний сургагч багш, эрх зүйн сурах бичиг хөтөлбөр боловсруулах чиглэлээр мэргэшсэн 20 орчим нийгмийн ухааны багш нар бэлтгэгдсэн байна.

Хөтөлбөрийн хүрээнд багш бэлтгэх, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлыг хийж үлдээсэн байна:

- «Хэрэглээний эрх зүй» арга зүйн 3 кредит бүхий хичээл, олон нийтийн сонирхлын эрх зүйн 1 кредит цаг бүхий дадлага хичээлүүдийг бэлтгэж МУБИС-ийн ТНУС-ийн нийгэм–эрх зүйн тэнхимийн сургалтын хөтөлбөрт оруулсан нь ЕБ-ын болоод их сургууль, коллежийн нийгмийн ухааны багшид тавигдах шаардлага, загварыг тодорхойлох, багш бэлтгэх үйл ажилагааг институтчилэхэд хувь нэмрээ оруулжээ.

- Эрх зүйн модуль сургалтын 144 цагийн хөтөлбөр нь ЕБС-ийн нийгмийн ухааны багш нар мэргэжил, боловсролоо байнга дээшлүүлэх гарын авлага болсон байна.
- Хөтөлбөрийн хүрээнд хийсэн сургалтад давхардсан тоогоор 5201 багш, 10-аад хуульч, бага ангийн 76 сургалтын менежер хамрагдсан байна.

Энэхүү хөтөлбөрийн сайн туршлага нь:

- Сонирхогч талуудын оролцоог хангахад анхаарсан. Энэ нь төр, ИНБ, мэргэжлийн бүлгүүдийн оролцоог хамарсан гэсэн үг юм. Тухайлбал, эрх зүйн сурах бичиг боловсруулахад болон багш нарын чадавхийг дээшлүүлэх сургалтад багш, арга зүйч, практик хуульчид хамтран ажиллажээ.
- Сурах бичгийн бодлогын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан.
- Жигд хүртээмжтэй байсан. Тухайлбал, 21 аймаг, Улаанбаатар хот тус бүрд сургагч багш бэлтгэжээ.
- Иргэний боловсрол нь сургалтын болон сургалтаас гадуурх орчноор дэмжигдэж байж үр дүнд хүрдэг болохыг анхаарч, эрх зүйн боловсрол олгох танхимын бус болон албан бус арга хэлбэрийг дэмжиж байсан.

Дээрх сайн туршлага нь өнөөдөр ч ерөнхий боловсролын нийгмийн ухааны сургалтад хэрэглэгдэж байна. Тухайлбал, ТНУ - Эрх зүйн боловсролын стандартыг уг хөтөлбөрийн үр дүнд тулгуурлан боловсруулсан бөгөөд одоо ч хүчин төгөлдөр мөрдөгдөж, нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр боловсруулах суурь үндэс болж байна. Гэвч зөвхөн эрх зүйн боловсрол дээр үндэслэн боловсруулагдсан энэхүү стандартыг цаашид иргэний боловсролын болгож өргөтгөн боловсронгуй болгох хэрэгцээ байна.

Мөн хөтөлбөрийн хүрээнд боловсруулж, 2000-2006 он хүртэл ашиглагдаж байсан эрх зүйн сурах бичгийн агуулга, арга зүй иргэншил, нийгмийн ухааны сурах бичгүүдэд иргэний боловсролын агуулгаар баяжигдан тогтвортой хадгалагдаж, хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш өнөөдөр ч үнэ цэнэтэй хүний нөөц хэвээрээ байгаа юм.

Дээр дурьдсан хууль, хөтөлбөрүүдэд ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх, эрхээ эдлэх, хамгаалах чадвар эзэмшүүлэхэд чиглүүлэх, хүний хөгжлийн түвшинг ахиулах зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн боловч “Монгол Улсад хүний эрхийг хангах хөтөлбөр”-өөс бусад хөтөлбөрт “иргэний боловсрол”-ын асуудлаар тусгайлсан тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх талаар заалт, төлөвлөсөн арга хэмжээ байхгүй байна.

2005 оны 8 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”-т иргэний эрх, эрх чөлөө, иргэдийн бүх талын оролцоо, хариуцлагатай төрийн байгууллагын хууль ёсны шүтэлцээнд түшиглэсэн ардчилсан засаглалыг бэхжүүлэх агуулгын хүрээнд “Иргэний боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор боловсруулна³³ гэсний дагуу дээр тэмдэглэсэн судалгааг үндэслэн “Иргэний боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, БСШУЯ-д өргөн барьсан байна. Үүний үндсэн дээр БСШУЯ-ны дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж, Засгийн газрын хуралдаанаар батлуулахаар тогтсон боловч өнөөг хүртэл шийдвэр гаргах түвшинд хэлэлцэж, батлагдаагүй байна.

Мөн хугацаанд боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2006-2012), Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2008) зэрэг хөгжлийн шинжтэй томоохон бодлогын баримт бичгүүд батлагдан гараад байна. Гэвч дээр дурдсан баримт бичгүүдэд иргэний боловсролын ойлголт, агуулга, боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх арга стратегийн талаар үнэлгээ дүгнэлт өгөөгүй байна.


Улмаар 2010 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 103 дугаар Зарлиг гарч, “ЕБС-ийн суралцагчдад үндэсний үнэт зүйлс, соёл, уламжлалт сэтгэлгээ, зан заншлын нийтлэг хэм хэмжээг таниулах зорилгоор “Иргэний боловсрол” хөтөлбөрийн хүрээнд заавал судлах “Монголын уламжлалт сэтгэлгээ, арга билгийн ухааны үндэс” хичээлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон байна. БСШУЯ-наас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 103 тоот зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн “Иргэний боловсрол” хичээлийн сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээг боловсруулах, сурах бичиг болон багш нарт зориулсан зөвлөмж боловсруулах талаар төлөвлөгөө, шаардагдах зардлын тооцоог гаргах ажлыг хийж байна.

³³ Төрийн мэдээлэл. 2005 он, №40, 710 дахь тал.

Дээр авч үзсэн санал, санаачлагууд нь иргэний боловсрол, түүний дотор хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болж байна гэж үзэж болохоор байна. Гэвч эдгээрийг хэрэгжүүлэх механизм тодорхойгүй, ялангуяа орон нутаг, засаг захиргааны нэгжүүд эдгээр туршлага, үйл ажиллагааг өөрийн өвөрмөц онцлогт нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, тайлагнах тогтолцоо сайтар бүрэлдэж чадахгүй байгааг хэлэх нь зүйтэй. Ялангуяа, иргэний боловсролыг ЕБС-ийн сургалтад нэвтрүүлэх чиглэлээр тодорхой заалт, үзэл санаанууд тусгагдсан боловч иргэний боловсролын агуулгыг ялгахад баримтлах нэгдсэн бодлого, үзэл баримтлал үгүйлэгдэж байна.

4.1. ЕБС-ИЙН СУРГАЛТААР ОЛГОЖ БУЙ ИРГЭНИЙ БОЛОВСОЛ: ОДООГ ХАРАХ НЬ

Ерөнхий боловсролын сургуулиар олгож буй Иргэний боловсролын сургалтад үнэлгээ өгөх энэхүү судалгааны хүрээнд МУ-ын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, агуулга хөтөлбөрийн баримт бичгээр баталгаажсан иргэний үнэт зүйлс нь ЕБС-ийн танхимын сургалтаар хэрхэн заагдаж, суралцагчдад ямар мэдлэг, чадвар, хандлагын өөрчлөлт бий болгож буйг тодорхойлох зорилгоор үнэт зүйлсийн зураглал, баримт бичгийн шинжилгээ, сургах, суралцах үйл явцын ажиглалт, орчны шинжилгээний аргуудад тулгуурлан хот болон хөдөөгийн сургуулиудыг хамруулан мэдээлэл бүрдүүлж, дүн шинжилгээ хийн, зөвлөмж боловсрууллаа. Иймд судалгааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох МУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үнэт зүйлс, сургалтын баримт бичиг болон хичээлийн соёл гурвын уялдаа холбоо нь уг судалгааны хүрээг тодорхойлсон болно. Үүнийг дүрслэн харуулбал:



Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтын үнэлгээ, мониторингийн үр дүнд дараах үндсэн дүгнэлтүүдийг хийж байна:

1. Монголын ард түмэн Үндсэн хуулиараа хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг баталгаажуулан хамгаалсан байх бөгөөд энэ нь өнөөгийн иргэний зэмшвэл зохих нийтлэг үнэт зүйлсийн илэрхийлэл юм. Эдгээр үнэт зүйлс нь одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, “Боловсролын тухай” хууль тогтоомж, тэдгээрт үндэслэн боловсруулагдсан сургалтын

баримт бичгүүдэд зохих хэмжээгээр тусгалаа олжээ³⁴. Гэвч Үндсэн хууль болон боловсролын суурь баримт бичгүүдэд тусгагдсан эдгээр үнэт зүйлс нь иргэний боловсролын бодлого, хөтөлбөр болж хэлбэржээгүй байна. Энэхүү дүгнэлтэд бид дараах тодруулгыг хийж байна.

Аливаа ардчилсан орны хөгжил дэвшилд иргэний байр суурь, үзэл бодол, оролцоо нэн чухал. Өнөөдрийн суралцагчид нь маргаашийн шийдвэр гаргагчид бөгөөд тэдний эзэмшиж буй боловсрол XXI зууны хөгжлийн хандлагыг тодорхойлох болно. Тиймээс ардчилсан нийгэмд амьдарч, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг эрхэмлэн дээдэлж, бусдын үзэл бодол, ахуй соёлын ялгааг хүлээн зөвшөөрдөг хандлагыг суралцагчдад эзэмшүүлэх нь сургуулийн хүлээх үүргийн нэг болж байна. Ардчилсан шилжилтийн жилүүдэд манай улс боловсролын салбарт ихээхэн анхаарал хандуулж, нийгмийн гишүүдэд чанартай, хүртээмжтэй боловсрол эзэмшүүлэх талаар хүчин чармайлт гарган, зохих хэмжээний амжилт олсныг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ ардчилсан нийгмийн, хариуцлагатай иргэн гэж хэн болох, тэдний итгэл үнэмшил, үнэт зүйлс, төлөвшлийн тухай асуудал манай улсын боловсролын салбарын бодлого болон судалгааны орхигдсон нэгэн сэдэв болж байна.

Боловсролын салбарт төрийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагуудын санаачлагаар иргэний боловсролыг дэмжсэн олон тооны үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр (хүний эрхийн, ардчиллын, тогтвортой хөгжлийн боловсрол гэх мэт) хэрэгжиж байна. Гэвч эдгээр санаачлага нь нэгдсэн бодлого уялдаа холбоо, тууштай дэмжлэг дутагдсаны улмаас хүрсэн үр дүнгээ хадгалж чадахгүй, тогтолцоо болж хэвшиж чадахгүй байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, тэдгээр санаачлагын үр дүн, ололт амжилтыг нэгтгэн, уялдаа холбоог нь хангаж, сургалтад нэвтрүүлэн, үр дүнг тооцох тогтолцоо сайтар бүрэлдэж чадаагүйн улмаас иргэний боловсролыг хөгжүүлэх санал, санаачлагууд “төслийн загвар” төдий хэлбэрээр үргэлжилсээр байна.

Мөн судалгаанаас үзэхэд иргэний боловсролын агуулгыг бодлогын хүрээнд оновчтой ялган тодорхойлж чадаагүйгээс тухайн боловсролд нэг агуулгыг хэт давамгай тусгах (тухайлбал, эрх зүйн боловсрол), нөгөө талаас зарим шинжээчийн цохон тэмдэглэснээр экологийн, шашны, хүлээцтэй хандах, олон соёлт, эдийн засгийн зэрэг иргэний боловсролын бусад бүрэлдэхүүн хэсэг тусгагдахгүй байгаа нь уг боловсролыг маш

³⁴ Тайлангийн 2.1-д харуулсан Зураглал “Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйлс – Иргэний боловсролын агуулгад” хэсгийг үзнэ үү

хязгаарлагдмал хүрээтэй болгож байна. Үүнээс үзэхэд, боловсролын салбарын шийдвэр гаргагчид нь иргэний боловсролын талаарх дэлхий нийтийн чиг хандлага, эрдэмтэн судлаачдын байр суурь, ялгаатай хандлагуудыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсын өнөөгийн хөгжилд нийцсэн иргэний боловсролын үзэл баримтлалыг олон талын оролцоотой тодорхойлж, түүндээ нийцсэн бодлого, сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Ардчилсан нийгмийн иргэний нийтлэг үнэт зүйлсийг суралцагчдад төлөвшүүлэх зорилго нь албан ба албан бус боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн зорилт болон дэвшигдэж, улмаар ЕБС-ийн иргэний боловсрол олгож буй хичээлийн агуулга, сургуулийн соёл, орчноор дамжин хэрэгжих ёстой. МУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан үнэт зүйлсийг суралцагчдад төлөвшүүлэх үзэл санаа нь Боловсролын стандарт болон сургалтын хөтөлбөрүүдэд тодорхой хэмжээгээр туссан байгаа нь энэхүү дүн шинжилгээгээр батлагдаж байна.³⁵ Гэвч иргэний боловсролын хичээлийн тухайлсан стандарт, сургалтын хөтөлбөр гараагүй байгаа тул бүрэн дунд боловсролын эрх зүйн боловсролын стандартад түшиглэн иргэний боловсрол олгох практик тогтоод байна.

Ерөнхий боловсролын сургуулиар олгож буй нийгмийн ухааны боловсролын (сургалтын) өнөөгийн нөхцөл байдлаас үзэхэд иргэний боловсролын хичээлийн нэршлийг тогтоох, агуулгыг сонгох, хичээлийн ба хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оновчтой хуваарилах талаар дахин нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна. Тухайлбал, одоо мөрдөж буй сургалтын төлөвлөгөөний дагуу “Иргэншил”, “Иргэний боловсрол” гэсэн хоёр хичээлийг нэгэн зэрэг судалж байна. Эдгээр хичээл нь иргэний боловсрол олгох нэгэн зорилготой боловч хоорондоо тодорхой ялгаатай байгаа нь харагда байна. Үүнд, “Иргэншил” нь Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 8-9-р ангийн сургалтын төлөвлөгөөний³⁶ дагуу сургалтын тогтвортой агуулга болох тул заавал судлах хичээл байхаар тогтсон бөгөөд үүний хамт уг хичээлийн нэрийг 2009 оноос эхлэн “Нийгмийн ухаан” болгон өөрчилжээ. Харин “Иргэний боловсрол” нь сургууль өөрөө зохицуулах агуулгад хамаардаг бөгөөд уг хичээлээр ёс суртахууны өндөр соёлтой, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач энэрэнгүй, эх оронч, үндэсний дэвшилтэт

³⁵ Тайлангийн 2.2-т буй “Үнэт зүйл ба НҮБ-ын стандарт, сургалтын хөтөлбөр”-ийг үзнэ үү.

³⁶ Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн VIII-IX ангийн сургалтын төлөвлөгөө, БСШУ-ны сайдын 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 201 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

ёс заншил болон хүн төрөлхтөний соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж заажээ. Гэвч мониторингийн үйл ажиллагаа, багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэл зэргээс харахад уг хичээлийн талаарх сургалтын хөтөлбөр, мэргэжлийн заавар, зөвлөмж байхгүй, ном сурах бичиг байхгүй, сургуулийн удирдлага, багш нарын зүгээс ач холбогдол өгч, чухалчлан үзэх байдал өөр өөр байгаагаас зорьж буй үр дүнд хүрэхгүй байгаа нь илэрхий байна. Үүнээс үндэслэн дүгнэхэд, эдгээр хичээл нь хэдийгээр нэгэн ижил зорилготой боловч өөр хоорондоо огт уялдаа холбоогүй, тус тусдаа, өөр өөр хандлагаар заагдаж байгаа нь энэ чиглэлд гаргаж буй хүчин чармайлт, шинэчлэлтийн үр дүнг сааруулахад хүргэж байна.

3. Хичээлийн болон сургуулийн орчны ажиглалтын судалгаанаас үзэхэд Үндсэн хууль, нийгмийн ухааны боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт тусгагдсан үнэт зүйлс, иргэний, ардчилсан, хүмүүнлэг нийгэмд ажиллаж амьдрахад шаардагдах мэдлэг, хандлагыг суралцагчдад эзэмшүүлэх үйл явц нь танхимын сургалт болон сургуулийн соёлоор бодитой дэмжигдэж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн ухааны боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт тусгагдсан үнэт зүйлсийн баримжаалал, мэдлэг, ур чадварыг иргэншлийн хичээл болон сургуулийн соёлоор дамжуулан төлөвшүүлэх, эзэмшүүлэх байдал нь хот болон хөдөөгийн сургууль, мэдээллийн хүртээмж, багш нарын дадлага туршлага зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөс хамааралгүйгээр бүхэлдээ тун хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна³⁷.

Цаасан дээр боловсруулж, сургалтын анги танхимд нэвтрүүлэхээр төлөвлөсөн мэдлэг, чадвар, хандлагын тогтолцоо болон сургуулийн анги танхимын амьдрал, үйлявцын хооронд томоохон зай завсар байна. Өөрөөр хэлбэл, ардчилал, сонгууль, хүний эрх зэрэг сэдвүүдийг хичээлийн хүрээнд зааж байгаа хэдий ч хичээлийн явц болон сургуулийн орчинд суралцагчидтай зөвлөлдөх, тэдний оролцоог хангах, ялгаатай байр суурь, үзэл бодлыг сонсох, шийдвэрийг хамтдаа гаргах байдал харагдахгүй байна.

4. Суралцагчдад ардчилсан нийгмийн үнэт зүйлс, хувь хүний үнэлэмж төлөвшихөд хамгийн чухал үүрэгтэй хүмүүсийн нэг бол багш юм. “Иргэншил”, “Иргэний боловсрол” хичээлүүд нь өнөөгийн нийгмийн байгууламж, ардчилал, хүний эрх, ёс зүй, эрх зүй зэрэг агуулгыг хамарч, хүнийг, иргэнийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд чиглэдэг учраас багш нар

³⁷ Тайлангийн 2.3-д багтаасан “Үнэт зүйл ба хичээл” хэсгийг үзнэ үү.

эдгээр хичээлийг маш чухалчилж ханддаг ажээ. Нөгөө талаас, тухайн хичээлүүдээр нийгмийн амьдралын асуудлуудыг судалдаг, сэдэв агуулга нь өргөн хүрээг хамардаг, суралцагчид үзэл бодлоо илэрхийлэх, харилцах боломжийг илүү хангадаг тул тэд идэвхтэй оролцдог тал байна. Гэвч дээр дурдсанчлан, “Иргэний боловсрол” хичээлийн сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээ, сурах бичиг гараагүй, энэ чиглэлээр мэргэжлийн заавар зөвлөмж өгдөггүй тул багш нар ямар агуулга, арга зүйг сонгон хичээл сургалтыг зохион байгуулах нь тодорхойгүй байх бэрхшээл тохиолдож байна. Өөрөөр хэлбэл, багш нарт сургалтын хэрэглэгдэхүүн хомсдолтойн дээр өөрсдөө иргэний боловсролын талаар сургалт, мэдээлэл авч байгаагүй, мөн тэдний мэргэжлийг дээшлүүлэх, дахин бэлтгэх тогтолцоо алга байна. Мөн уг хичээлийг нийгмийн ухааны буюу холбогдох мэргэжлийн багш нар бус, харин голдуу анги удирдаж буй, эсхүл цаг хүрэхгүй байгаа зэрэг шалтгаанаар өөр мэргэжлийн багш заадаг практик байгаа нь судалгаанаас харагдлаа. Нийгмийн ухааны багш нарыг чадваржуулах, тэдэнд ардчилал, иргэний нийгмийн тухай мэдлэг, түүнийг сурагчдад заах ур чадварыг эзэмшүүлэхэд 1990-ээд оны сүүлч, 2000-аад оны эхээр үндэсний болон олон улсын ТББ-ын эзэлж байсан орон зай хоосон хэвээр, хариуцах эзэнгүй үлдсэн байна. Иймд иргэний боловсролын чиглэлээр багш бэлтгэх, багш нарын мэргэжил дээшлүүлэх, давтан бэлтгэх талаар төлөвлөгөөт ажлыг нэн даруй эхлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

5. Иргэний боловсролын агуулга, арга зүй, үнэлгээ болон иргэний чанар, үнэт зүйлсийн талаар гарсан бодлого, судалгааны материал ховор байна. Үүний зэрэгцээ боловсролын салбарын шинэчлэлтэй холбоотойгоор сурах бичгүүд богино хугацаанд солигддог, сурах бичгийн агуулга, хэрэглээнд үнэлгээ хийгддэггүй тул багш нарт иргэний боловсролын агуулга, сургалтын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц судалгаа, сургалтын хэрэглэгдэхүүн хомс хэвээр байна.

Сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүний хүртээмж хангалтгүйн дээр бүтээлч заах арга зүй, дидактик шийдлүүд сургалтын орчин, анги дүүргэлт зэргээс шалтгаалан хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл багшийн ур чадвар болж хэвшээгүй тул уншуулах, бичүүлэх, өөрөө ярьж тайлбарлах зэрэг уламжлалт арга зүй, үйл ажиллагаа сургалтад зонхилж байна. Энэ нь иргэний боловсролын хичээлийн хөтөлбөр тодорхойгүй, агуулга тогтворгүй, сургалтын материалын олдоцод тулгуурлан хичээл, сургалтыг өөрчлөн зохион байгуулах зэрэг бэрхшээл үүсгэж байна.

б. Иргэний боловсролд орчны нөлөөлөл хүчтэй байдаг нь түүний бусад боловсролоос ялгарах онцлог болдог тул сургуулийн орчин болон дүрэм журамд дүн шинжилгээ хийсэн юм. Сургууль бүр “Сургуулийн дүрэм”, “Дотоод журам”, “Суралцагчийн дүрэм”, “Анги дэвших ба төгсөх шалгалтыг зохион байгуулах журам” зэргийг боловсруулан сургуулийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон багш, ажилчдын хөдөлмөрийнгэрээ, нийгмийн баталгааны талаарх асуудлуудыг зохицуулж байна. Харамсалтай нь эдгээр дүрэм, журамд чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах талаар үүрэг хүлээх бус харин сургууль, багшийн зүгээс суралцагчид руу хандсан хориглосон, үүрэг болгосон заалтууд голложээ. Иймд эдгээр дүрэм, журам нь манай улсын ерөнхий боловсролын сургуулиуд ардчилсан, хүүхдэд ээлтэй, суралцагчдын өөрийн удирдлага, оролцоо, хамтран шийдвэр гаргах байдлыг дэмждэг хэмээн үзэх боломжгүйд хүргэж байна.

Сургуулиудад хуучирсан мэдээлэлтэй самбар, хичээлийн хуваариас өөр суралцагчдад зориулагдсан, тэднийг хүлээн авах, хамтран зөвлөлдөх, шийдвэр гаргах, сургуулийн удирдлагуудтай уулзах цагийн хуваарь, цуглаж хэлэлцэх танхим, орчин нөхцөл алга байна. Багш, сурагчдын харилцаа, сургуулийн орчин, үйл ажиллагаа нь өөрөө ардчилал, хүний эрх, нээлттэй олон ургальч хандлагыг хүндэтгэсэн байх, суралцагчдын болон эцэг эхийн зөвлөлдөх байгууллага нь сургуулийн шийдвэр гаргах үйл явцын нэгэн салшгүй хэсэг байх зэрэг оролцоот, ардчилсан, хүүхдэд ээлтэй сургуулийн үндсэн шаардлагууд сургуулийн соёл болж хэвшээгүй хэвээр байна. Сургуулийн орчны ажиглалтаас дүгнэн үзэхэд сурагчдын хичээлээр олж авсан мэдлэг, чадвар, хандлагыг бэхжүүлэхэд илрэх сургуулийн соёл нь бодитой дэмжлэг болж чадахгүй байна. Хэдийгээр энэ чиглэлээр зарим нэг санаачлагууд хэрэгжиж эхэлсэн боловч бүхэлдээ ЕБС-ийн соёлыг тодорхойлохуйц хэмжээнд хүрээгүй байна.

Цаашид судлах шаардлагатай асуудлууд


Судалгааны хүрээнд авч үзээгүй боловч иргэний боловсролтой холбоотойгоор зайлшгүй хөндөгдөж буй нэгэн асуудал бол иргэний боловсрол болон бусад хичээлүүдийн уялдаа холбоо, хамаарлын тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл, иргэний боловсролыг зөвхөн “Нийгмийн ухаан”, “Иргэний боловсрол” хичээлээр дагнан олгохоос илүүтэй ЕБС-д судалж буй бусад хичээлийн агуулга, хэрэглэгдэхүүн, заах арга зүйгээр дамжуулан олгох, бусад хичээлийн агуулга, арга зүйд интеграцчилан оруулах нь иргэний боловсролыг дэмжих илүү үр дүнтэй, зохистой хувилбар гэж үзэж байна. Гэхдээ манай улсын хувьд уг асуудалтай холбогдуулан ЕБС-ийн хичээлүүдийн уялдаа холбоо, агуулгын залгамж чанар, багш нарын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх аргачлал журам, сургуулийн дотоод ардчиллын тухай цаашид дэлгэрүүлэн судалсны үндсэн дээр авч үзэх боломжтой болно.

Мөн иргэний боловсролын чанар, цаашдын үр нөлөөнд зайлшгүй нөлөөлөх нэг асуудал бол боловсролын байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, нэгдсэн удирдлага, зохицуулалт юм. Тухайлбал, боловсролын стандартад тусгагдсан үнэт зүйлс, агуулгын тогтолцоог суралцагчдад хүргэх, тэдний бодит мэдлэг, чадвар, хандлага болон төлөвшиж чадахгүй боловч үүний хариуцлагыг хүлээх “эзэн” тодорхой биш байна. Үүнд боловсролын бодлогыг тодорхойлж буй БСШУЯ, түүнийг аймаг нийслэлд хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Боловсролын хүрээлэн, Боловсрол, соёлын газар, сургуулийн удирдлага, багш бэлтгэх сургууль, боловсролын мэргэжлийн хяналтын болон үнэлгээний байгууллага оролцох боловч эдгээрийн хооронд зохистой хамтын ажиллагаа, зохицуулалтын механизм байхгүй байна. Энэ нь дээр дурдсан Иргэний боловсролын талаарх бодлого, үзэл баримтлал байхгүйтэй холбоотой бөгөөд үүнийг тодорхойлохын тулд дээрх оролцогч байгууллагуудын уялдаа, гүйцэтгэх үүргийн талаар нэгдсэн ойлголцолд хүрэх шаардлагатай байна.

Судалгааны дүн бүхэлдээ Монгол Улсын хөгжлийн үндсэн чиглэл болох хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгмийн үзэл баримтлал болон тэрхүү нийгэмд ажиллаж, амьдрах иргэдийг төлөвшүүлэх иргэний боловсрол, сургалтын хооронд маш том “ангал” байгааг харуулж байна.

Судлаачдын багийн зүгээс Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүгээр баталгаажсан үнэт зүйлс иргэн (суралцагчдад)-д хүрэх боловсролын зураглалыг доор дурдсан 8 шатлалтай бүтэц байдлаар төсөөлж болох юм.

Бүдүүвч 2. Үнэт зүйлс: Хуулийн заалтаас хувь хүний хандлага болон төлөвших үе шат




Дээрх зураглалаар Үндсэн хууль болон боловсролын баримт бичгүүд дэх үнэт зүйлсийг хувь хүний хандлага, итгэл үгэмшил болгон төлөвшүүлэх хүртэлх боловсролын үе шатуудыг дүрслэн үзүүлэв. Өөрөөр хэлбэл, үнэт зүйлс боловсролын зорилго, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн болон орчноор дамжин иргэд, суралцагчдад очих замын зураг юм. Зураглалын шатлал бүрт дэвшүүлсэн зорилго, түүний бодит хэрэгжилт хоёрын хооронд алдагдал гарч байгаа бөгөөд тэрхүү алдагдлууд нийлэх буюу улам гүнзгийрсээр эцсийн үр дүнд ЕБС-ийн иргэний боловсролын сургалт суралцагчдад үр өгөөжгүй, сонирхолгүй, ач холбогдол багатай хичээл болж очиж байна. Энэ нь зөвхөн цаг хугацааны, санхүүгийн бус нийгмийн хөгжил, үнэт зүйлсийн төлөвшил, ухаалаг, хариуцлагатай иргэн болох боломжийг алдахад хүргэхүйц сорилт юм.

Монгол Улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг байгуулах зорилгодоо хүрэхэд иргэдийн мэдлэг, боловсрол, үнэт зүйлс нь тулгуур хүчин зүйл байх болно. Монгол Улс ардчиллыг эргэлт буцалтгүйгээр сонгосныг баталгаажуулж, иргэдэд ардчилсан үнэлэмж төлөвшүүлэх үндсэн арга замын нэг нь тодорхой, цэгцтэй үзэл баримтлалд суурилсан иргэний боловсрол юм.

Судалгааны ажлын үр дүнд үндэслэн иргэний боловсролд тулгамдаж буй өнөөгийн асуудлуудыг дараах байдлаар авч үзлээ.

Бүдүүвч 3. Иргэний боловсрол: Асуудлын зураглал



4.2 БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ: УРАГШАА ХАРАХ НЬ

Энэхүү үнэлгээ, мониторинг нь ЕБС-д судалж буй “Иргэншил” хичээлийн хүрээнд хийгдсэн бөгөөд зөвлөмж нь ЕБ-ын иргэний боловсролын сургалтыг сайжруулахад чиглэж байна.

Ерөнхий боловсролын сургуулиудад:

- ЕБС-ийн иргэний боловсролд холбогдох сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, сургууль ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн, хүүхдэд ээлтэй орчин байх талаар багш, суралцагч, эцэг эхийн төлөөлөл бүхий хамтын зөвлөлгөөн зохион байгуулж, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- Сургуульдаа ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхийн тулд:
 - Сургуулийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журмуудыг ардчилал, хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн суралцагчдын оролцоотойгоор шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх;
 - Багш бүр хичээлээрээ иргэний үнэт зүйлсийг дэмжих, ардчилсан хандлагатай байхыг шаардахаас гадна ажлыг нь үнэлэх, дүгнэх шалгуурт тусгах;
- Сургуулийн удирдлага, багш нарын зүгээс суралцагчидтай уулзах, зөвлөлгөө өгөх ажлыг журамлаж, цагийн хуваарь гарган дагаж мөрдөх;
- Сургуулийн Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлж, суралцагчидтай холбоотой шийдвэр гаргахдаа Сурагчдын зөвлөл буюу зохих төлөөллийг оруулж, хамтран шийдвэр гаргаж хэвших;
- ЕБС-ийн иргэний боловсролын хичээл заах багш нарыг чадваржуулах, сургуулийн түвшинд мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Иргэний боловсролыг дэмжих чиглэлээр төрийн ба иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, багш бэлтгэх болон бусад ЕБС-иудтай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох;

- Ардчилал, хүний эрх, эрх зүй, ёс суртахуун зэрэг иргэний боловсролд холбогдох чиглэлээр судалгаа, сургалтын хэрэглэгдэхүүнээр сургуулийн материаллаг бааз, номын санг баяжуулах, ашиглалтыг сайжруулах.

Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудад:

- Иргэний боловсролын хичээлийн тусгайлсан болон интеграцчилсан хөтөлбөр боловсруулж, багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудад сонгон судлах боломжийг бүрдүүлэх;
- ЕБС-д иргэний боловсролын хичээл заах багшийг бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
- Төгсөн гаргасан багш мэргэжилтнүүдийн дунд мэргэжил дээшлүүлэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлж, шинэлэг мэдээлэл, арга зүй, сургалтын технологиор хангаж, эргэх холбоо бүрдүүлэх;
- Иргэний боловсролын ач холбогдол, үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх.

Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газарт:

- Сургуулийн удирдлагуудад иргэний боловсролын сургалтын менежментийн талаар арга зүйн зөвлөмж өгөх, хэрэгжилтэнд хяналт тавих;
- ЕБС-ийн иргэний боловсролын сургалтын чанар, стандартын хэрэгжилтэд үнэлгээ шинжилгээ тогтмол хийх, сайжруулах талаар санал гаргах;
- ЕБС-д “Иргэний боловсрол” хичээл зааж буй багш бүрт хүрсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, харилцан туршлага солилцох уулзалт, уралдаан тэмцээнийг зохион байгуулж хэвших.

Боловсролын хүрээлэнд:

- ЕБС-ийн иргэний боловсролын стандартын төслийг боловсруулж, холбогдох мэргэжилтэн, байгууллагуудаас санал авч БСШУЯ-аар батлуулахаар өргөн барих;
- ЕБС-ийн иргэний боловсролын стандарт, хөтөлбөр, сурах бичигт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг тасралтгүй явуулж, холбогдох

байгууллагуудыг эрдэм шинжилгээ, арга зүйн зөвлөмжөөр хангах;

- Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын арга зүйч, сургуулийн удирдлага, менежерүүд, багш нарын дунд иргэний боловсролын талаар мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч хэвших;
- Иргэний боловсролыг нийгмийн бүх бүлэг, сургалтын түвшинд хүргэх зорилгоор судалгаа шинжилгээний ажлын чиглэл боловсруулах, судлаач багш нарыг дэмжин урамшуулах.

МУ-ын Засгийн газар, БСШУЯ-д:

- Иргэний боловсролын тусгайлсан стандарт, сургалтын хөтөлбөрийг 12 жилийн сургалтын тогтолцооны шинэчлэлтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх;
- ЕБС, сургуулийн удирдлага, багш нарын ажлыг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлтэд сургуулийн ардчилсан, хүүхдэд ээлтэй байх болон хүний эрхийн орчны үзүүлэлтийг тусгах, урамшууллын болон хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, удирдамжаар хангах;
- “Хүүхдэд ээлтэй сургууль”, “Олон нийтийн оролцоот сургууль”, “Хүний эрхэд ээлтэй сургууль”, “Эко сургууль” зэрэг боловсролын салбар дахь олон төрлийн санаачлагуудын үр дүнг бүх сургууль болон салбарын хүрээнд түгээн дэлгэрүүлэх, өргөжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Сургууль дахь Сурагчдын зөвлөл болон хүүхдийн өөрийн удирдлагын бусад байгууллагыг дэмжин тусалж, тэднийг үйл ажиллагаа явуулах танхим, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургуулийн шийдвэр гаргах бүтцэд адил тэгш, зөвлөлдөх эрхтэй оролцдог байх жишгийг журамлах;
- Иргэний боловсролыг албан боловсролын хөтөлбөр болон интеграцчилсан хичээлийн хөтөлбөрт оруулахад чиглэсэн багш нарын мэргэжил дээшлүүлэх шинэ сургалтын тогтолцоог бий болгож, хөгжүүлэх;
- Иргэний боловсролын талаар багш оюутнууд, суралцагчдад зориулсан, суралцагчдын нас, сэтгэхүйн хөгжилд тохирсон мэдээлэл, зөвлөгөөг агуулсан вэб хуудас боловсруулан ажиллуулах;
- Суралцагчид, багш нар хялбар холбогдож, мэдээлэл авах болон өөр хоорондоо үзэл бодол, мэдээлэл, туршлагаа хуваалцах боломжтой

зайны болон телевизийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

- Иргэний боловсрол хичээлийн хэрэглэгдэхүүн, сурах бичиг, гарын авлага, үзүүлэн тараах материалыг боловсруулах, энэ чиглэлээр гарч байгаа иргэний нийгмийн болон сургалт, судалгааны байгууллагуудын үүсгэл санаачлагыг дэмжих.

МУ-ын төрийн эрх барих дээд байгууллага УИХ-д:

- Монгол Улсын иргэдийн үнэт зүйлс, нийгмийн гишүүдэд төлөвшүүлэх иргэний боловсролын зорилго, агуулгыг тодорхойлсон бодлого, үзэл баримтлалыг судалгаа шинжилгээний болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор боловсруулан баталгаажуулах;
- Энэхүү иргэний боловсролын бодлого, үзэл баримтлалыг боловсруулах, хэрэгжүүлэх талаар иргэний нийгмийн болон сургалт, судалгааны байгууллагуудын санаачлагыг дэмжин, төсвийн болон удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх.

Олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудад:

- Хөгжлийн туслалцааны болон төр, иргэний нийгмийн түншлэлийн хүрээнд иргэний боловсролын чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж төрөөс баримтлах бодлого, стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, нөлөөлөх;
- Нийгмийн ухааны болон иргэний боловсролын сургалт явуулж буй багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, чадавхжуулахад хамтран ажиллах, төсөл хөтөлбөрүүд санаачлах;
- Иргэний боловсролын сургалтад ашиглах судалгаа, сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах, түгээх ажлыг санаачлан хэрэгжүүлэх, ЕБС болон багш бэлтгэх сургуулийн материаллаг бааз, номын санг баяжуулахад дэмжлэг үзүүлэх;
- Иргэний боловсролыг тогтолцоот байдлаар хөгжүүлэх, үр дүнд хүргэхийн тулд олон улсын зөвлөх үйлчилгээг сонгон ажиллуулах, дотоодын мэргэжилтэн, судлаачдын чадавхийг дээшлүүлэх;
- Иргэний боловсролыг дэмжих чиглэлээр хүний болон санхүүгийн нөөцийг татан төвлөрүүлэх, энэ чиглэлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг хөгжлийн туслалцааны болон хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон чухалчлан үзэх.

